

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-7

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 8-64

1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/	8-29
2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	29-52
3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрийн өмчийг Нийслэлийн өмчид ишлэжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	52-64

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
08 дугаар сарын 20-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 17 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Тасалсан: Н.Алтаншагай, Х.Баттулга, Ж.Ганбаатар.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж өнөөдрийн хэлэлцэх асуудалд орсон “Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны дарга сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хойшлуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, мөн яамны Орон сууц, санхүүжилтийн хэлтсийн дарга Э.Батболд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга О.Энхмөнх, Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах

зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Б.Жаргалан, Д.Энхтүвшин, Э.Батшугар, М.Бадамсүрэн, М.Энхцэцэг, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Эдийн засаг, хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 2 дэд заалт нэмэх:

“1.Эрдэнэтийн овооны Оюут ордын нөөцийг тооцоолон, ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад бүрэн бэлтгэнэ.

2.Эрдэнэтийн стратегийн ордын талбайн эрэл хайгуулын ажлыг дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаан ашиглан дараагийн шинэ Эрдэнэтийн хэмжээний ордыг нээж, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 12
Бүгд: 20
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 2 дэд заалт нэмэх:

“1.Эрдэнэтийн овооны Оюут ордын нөөцийг тооцоолон, ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад бүрэн бэлтгэнэ.

2.Эрдэнэтийн стратегийн ордын талбайн эрэл хайгуулын ажлыг дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаан ашиглан дараагийн шинэ Эрдэнэтийн хэмжээний ордыг нээж, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 13

Бүгд: 20

35.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 9

Бүгд: 20

55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 2 дэд заалт нэмэх:

“1.Эрдэнэтийн овооны Оюут ордын нөөцийг тооцоолон, ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад бүрэн бэлтгэнэ.

2.Эрдэнэтийн стратегийн ордын талбайн эрэл хайгуулын ажлыг дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаан ашиглан дараагийн шинэ Эрдэнэтийн хэмжээний ордыг нээж, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, О.Батнайрамдал, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 8

Бүгд: 20

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3 дахь заалтын “Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“1.Эрчим хүчний салбарт реформ хийх, салбарын эрх зүйн орчин, Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиуд болон

холбогдох дүрэм, журам, эрх зүйн актуудыг шинэчлэн зохих өөрчлөлтийг оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 5
Бүгд: 20
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3 дахь заалтын “Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн заалтад доор дурдсан өөрчлөлтийг оруулах:

“3.3.3.37.Сонгино-Дархан чиглэлийн 220кВ-ын шугамыг барьж, эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.2.2 дахь заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“1.Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд нэг цонхны бодлогоор дэмжинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 4 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, мөн хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга О.Энхмөнх, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Н.Уранцэцэг, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дашням, Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхжин, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, О.Цогтгэрэл, М.Бадамсүрэн, Б.Жаргалан, Л.Соронзонболд, Ж.Алдаржавхлан, Д.Энхтүвшин, П.Сайнзориг, Н.Батсүмбэрэл, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төр, хувийн

хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрийн өмчийг Нийслэлийн өмчид шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, мөн хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга О.Энхмөнх, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Н.Уранцэцэг, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дашням, Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхжин, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрийн өмчийг Нийслэлийн өмчид шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул нар хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл үг хэлэв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн тавьсан асуултад Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.“Төрийн өмчийг Нийслэлийн өмчид шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 55 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 88.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 17 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе. Өнөөдөр 2024 оны ээлжит бус чуулганы Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн боллоо. Хуралдааны ирцийг танилцуулъя. Мөнхсоёл гишүүн гадаадад томилолттой. Бусад гишүүд хүрэлцэн ирж, ирц 60 хувьтай байгаа тул хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд, 3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болгосонд тооцох тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн өмчийг Нийслэлийн өмчид шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, ЗГ 2024 оны 8 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ бид Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. 4.Байнгын хорооны тогтоолын төсөл Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны дарга сонгох тухай гэсэн 4 асуудал өнөөдрийн Эдийн

засгийн байнгын хороогоор хэлэлцэхээр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс тов дараалал баталсан байгаа.

Гэхдээ дэд хороодын дарга нарыг сонгох, нэр дэвшүүлэх асуудал дээр Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүд зөвшилцөж амжаагүй байгаа бөгөөд одоогоор Байнгын хороонд албан ёсоор хандаж, дэд хорооны даргад нэр дэвшүүлсэн талаарх хүсэлт ирээгүй байгаа тул Байнгын хорооны даргын хувьд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудаас Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг хасах горимын санал гаргаж байна. Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт 80 хувиар дэмжигдэж санал дэмжигдлээ. Энхтүвшин гишүүн үү? Төхөөрөмж ажиллаагүй байна, энийг протоколд тэмдэглэнэ. Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлаас асуудлын жагсаалтаас хаслаа. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэх асуудалдаа оръё. Ажлын хэсгээ оруулъя. Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг танилцуулъя. Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Эрхэмбаярын Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД, Нансалын

Тавинбэх ЭХЯ-ны ТНБД, Лхагвасүрэнгийн Балчиндүвсан Эдийн засгийн хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Пүрэвийн Оюунцэцэг ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Отгонтогтохын Энхмөнх Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга, Эрдэнэбатын Батболд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын Орон сууц, санхүүжилтийн хэлтсийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бат-Ирээдүйн Мөнх-Эрдэнэ ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын шинжээч ийм хүмүүс ирсэн байна.

Хажууд бас ХЗБХ давхцаж байгаа учраас зарим ажлын албаны хүмүүс тийшээ орсон байна. Тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан асуух асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Яамны энэ хариуцсан хүмүүс нь л хариуцах юм уу? Ийм нэр л гаргаж өгсөн байна. Энэ сайд нар энд орж ирэхгүй байсан юм уу? Цаг байгаа байгаа учраас цаашаа үргэлжлээд явж байя. Тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Цогтгэрэл гишүүнээр тасалъя. Соронзонболд гишүүн асуултаа асууна уу.

Л.Соронзонболд: Өглөөний мэнд. Мөрийн хөтөлбөртэй холбоотой хэд хэдэн асуулт байгаа юм. Ялангуяа энэ НДШ-ийг ингээд шинээр иргэн бүр дээр ингээд хуримтлалын данс бий болгоно гэж тусгасан байна л даа мөрийн хөтөлбөрт. Гэтэл одоо нийгмийн даатгал төлж байгаа хүмүүс дээр болохоор бол тэтгэврийн нэрийн данс гээд ингээд хуримтлуулагдсан явж байдаг. Энэ дээр миний ойлгож байгаагаар бол нэлээд их наяд төгрөгийн

хамгийн багадаа л 20 их наяд төгрөгийн өр байдаг гэж би ойлгож байгаа.

Монгол улсын ЗГ гадаад, дотоодоос авсан зээлээ бол бүртгээд байдаг. Тэгсэн мөртөө ингээд нийгмийн даатгалын, нийгмийн даатгалаа төлж байгаа иргэдийнхээ төлөх ёстой өрөө болохоор бол өөр дээрээ ингээд бүртгэхгүй байгаа асуудал байгаа. Хэрвээ зүгээр ойролцоогоор хамгийн багадаа 20 их наяд гэж бодох юм бол энэ ЗГ-ын өр чинь аль хэдийн 70 хувь давчихсан байна гэж би хэлэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр хэрвээ үнэхээр боломж нөхцөл нь байдаггүй юм гэж үзвэл энийг жишээлбэл энэ ирэх ЗГ-ын үйл ажиллагааны 4 жилийн хугацаанд ядаж хэдэн хувийг нь мөнгөжүүлэх юм бэ гэдэг ийм тодорхой зорилтыг тавимаар байна гэдэг ийм саналыг бол бүүр тусгах саналтай байна. 1 дүгээр асуудал бол ийм байна.

2 дугаарт болохоор бол Монгол Улс болохоор бол Дэлхийн ногоон уур амьсгалын сан гэж байдаг. Энэхүү сангаас болохоор бол Монгол Улсад ногоон төслүүдийг санхүүжих зорилгоор ногоон ийм ногоо ногоон санхүүгийн корпорацад хөрөнгө оруулахаар бол бас тодорхой хэмжээний мөнгө тусгачихсан байдаг юм байна. Энэ хүрээндээ болохоор бол 2024 онд Сангийн сайдын багцад 63,9 тэрбум төгрөгийг энэ ногоон санхүүгийн корпорацад дүрмийн санд нь хөрөнгө оруулах зорилгоор ингээд тусгасан байдаг. Энэ ажлын гүйцэтгэл ямар байгаа вэ? Энэ талаар ер нь цаашидаа энэ ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр дээр харахаар Хөгжлийн банкний бүтцийн өөрчлөлт хийгээд ногоон санхүүжилтийн ийм сан байгуулах ийм дурдахдаа тусчихсан байгаад байдаг. Гэтэл энэ ногоон санхүүгийн корпорацыг дэмжих замаар хийх ажлуудын талаар ерөөсөө тусгагдаагүй байна гэж би харж байгаа юм. Тэгэхээр энэ талаар надад энэ тал дээр ямаршуу мэдээлэл байгаа вэ? Энэ

талаар мэдээлэл авах саналтай байна. 2 дугаар асуудал.

3 дугаарт болохоор бол ерөнхийдөө эдийн засгийн салбаруудыг дэмжих ялангуяа энэ орон сууцжуулах асуудал дээр бол тодорхой бодлогын дэмжлэг үзүүлээд цаашдаа үргэлжлүүлж явна гэж тусгасан байна. Энэ дээр болохоор бол би бол энэ ялангуяа энэ ногоон шилжилтийг дэмжих зорилгоор энэ ногоон дэд бүтцээ ногоон технологиор шийдсэн ийм бие даасан шийдэлтэй амины орон сууц, ногоон орон сууцыг энгийн орон сууцын зээлийн хүүгээс ийм ялгаатай байдлаар бас бодлогоор дэмжих ёстой болов уу гэж бол.../минут дуусав/

Р.Сэддорж: Баярлалаа. Нийгмийн даатгалын асуудал бол манай Байнгын хороонд харьяалагдахгүй байх. Тэгээд санал бол дараа нь явна. Энэ бол зөвхөн асуулт байгаа. Соронзонболд гишүүний энэ ногоон санхүүжилттэй холбоотой, бусад асуудлаар хэн хариулах вэ? 2 дугаар микрофон өгье.

Э.Баттулга: Та бүхний энэ өглөөний амгаланг айлтгая. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД Баттулга байна. Соронзонболд гишүүний асуусан асуулттай холбогдуулаад ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.1 дээр хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлэх, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн ногоон санхүүжилт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зохицуулалтаар хангах эрх зүйн орчныг сайжруулна гэсэн нэг зорилт орсон байгаа. Энэ хүрээндээ бид нар бол Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулна.

Дээр нь байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх энэ олон улсын нийтлэг жишиг болсон энэ хэлбэрүүдийг бол ашиглана. Энэ

дотор бол ногоон зээл байгаа, ногоон бонд байгаа, ногоон бирж байгаа, ногоон даатгал, өрийн солилцоо, ногоон худалдан авалтуудын ийм шилдэг туршиллагуудыг нэвтрүүлнэ гэж байгаа. Энэ санхүүжилтийн эх үүсвэр дээр бол манай Сангийн яам нэмээд хариулах байх. Бидний ойлгож байгаагаар бол энэ Монголын ногоон санхүүгийн корпорац болбол нийтдээ олон улсын санхүүжилтийн ногоон санхүүжилтийн сангууд, сангуудаас бол нэг нийт 50 орчим сая ам.долларын энэ хөрөнгө татах боломжтой болсон гэж ойлгож байгаа. Монголын талын оролцоог ирэх жилийн төсөв дээр суулгаад ингээд шийднэ гэж харж байна.

Дараагийн асуудал нь болбол энэ уур амьсгалын өөрчлөлтийн олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах хувийн хэвилийн санаачилгуудыг дэмжих, зах зээлийн бус зах зээлийн болон зах зээлийн бус хэрэгслийг ил тод, байгаль орчны үр нөлөөг тооцож, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн ийм 3.1.2.2 гэсэн заалтуудаар бас тусгаж өгсөн байгаа. Тэгэхээр саяын гишүүний ярьдаг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой, ногоон санхүүжилттэй холбоотой заалтууд болбол ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаа.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн тодруулга.

Л.Соронзонболд: Тэр нийгмийн даатгалын нөгөө өрийн асуудлыг нөгөө манай Байнгын хорооных биш гээд байгаа нь арай жоохон ойлгогдохгүй байна л даа. Яагаад гэхээр энэ чинь өр шүү дээ. Эдийн засгийн асуудал чинь өрийн асуудал ярих ёстой л гэж бодоод байх юм. Өөрөөр хэлбэл энэ чинь нийгмийн даатгал төлж байгаа 600, 700 мянган хүнд ирээдүйд төлөх ёстой өрөө улс өнөөдөр бүртгэхгүй байгаа асуудал байхгүй юу. Тийм учраас би асуугаад байгаа шүү дээ. Тэгвэл манай хорооны

эрхлэх асуудал биш гэж байгаа нь бол буруу байна л гэж бодож байна.

Р.Сэддорж: Яах вэ энэ ажлын хэсгийнхэн л яаж байна л даа. Улсын өр, улсын өртэй холбоотой асуудал бол манайд харьяалагдах л юм байна. Тэгээд нийгмийн даатгалын өр бол нөгөө Байнгын хорооны юун дээр эрхлэх асуудал дээр л байгаа юм байна. Тэгээд энэ ажлын албаныхан энэ дээрээ анхааръя. Дараагийн гишүүн Батбаярын Жаргалан.

Б.Жаргалан: Сайн байцаана уу. ЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 20 шахам мега төсөл гэж томъёологдож байгаа томоохон төслүүдийн танилцуулгууд бас орж ирсэн. Үүнд бол 40 гаруй их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийнэ гэчихсэн байж байгаа. Би бол юу харахыг хүсэж байна вэ гэхлээр эдгээр мега төслүүдийн бүтээн байгуулалт болон түүхий эд нийлүүлэлт, ажиллах хүчний оролцоонд үндэсний ААН-үүд ямар түвшинд, яаж оролцох вэ? Энэ тал дээр тодорхой тоо баримтууд анхан шатын тооцоолол судалгаанууд байна уу? Яагаад гэхээр ЗГ-аас яригдаж байгаа асуудлууд дээр ингээд дэлхийн хэмжээний гүйцэтгэгч нарыг сонгоно, дэлхийн хэмжээний компаниудыг урилгаар оруулж ирнэ л гэсэн юм яриад байгаа. Гэтэл бол бид бол эдийн засгаа тогтвортой өсгөж, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, иргэдийн цалин орлогыг нэмэгдүүлэхийн тулд дотооддоо ажлын байрнууд бий болгох шаардлагатай байна. Дотоодын ААН-үүдийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Тэгэхээр бол ЗГ-аас бол аливаа энэ төсөл хөтөлбөрийн дизайн боловсруулалт дээрээ бол энэ хэдэн хувийнх нь түүхий эд, ажиллах хүч дотоодын зах зээлээс гарах юм, хэдэн хувь нь бол ингээд яг Монголчуудад мөнгөн эргэлт бий болгож очих юм гэдгийг бол тооцоолох шаардлагатай гэж харж ж байгаа. Тэгэхээр энэ тал

дээр бол ажлын хэсгээс бас тайлбар авмаар байна. Тэр 40 их наядын мега төслүүдийн хэдэн, хөрөнгө оруулалтын хэдэн хувь нь дотооддоо шингэх вэ? Цаашидаа яг энэ тал дээр ер нь ямар тооцоо судалгаанууд байна вэ гэдэг талаар асуух гэсэн юм.

Р.Сэддорж: Батжаргалын Жаргалан гишүүний асуултад хэн хариулах уу? 5 номер.

Л.Балчинлуvsан: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Жаргалан гишүүний асуултад хариулъя. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр тэр дундаа яг мега төслүүд гэсэн 14 төслийн жагсаалт оруулж ирсэн. Энэ нь бол та бүхэн мэдэж байгаа хамтарсан ЗГ гэдэг утгаараа хөдөлгөх шаардлагатай том төслүүд, энийгээ дагаад ажлын байр нэмэгдэх, мөн хувийн ААН-үүдээ дэмжих ийм бодлогууд бас давхар явж байгаа. Та бүхэн үйл ажиллагааны хөтөлбөрийн бүрэн концепцыг харвал энэ хүрээндээ бид нар 4 бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд тодорхойлолтуудаа оруулж өгсөн. Хувийн ААН-үүдээ яах яаж дэмжих юм бэ, эдийн засгийн өсөлтөө хангахын тулд, тогтвортой хангахын тулд ямар ямар бодлогуудыг хувийн салбарууд болон төрийн зүгээс яаж дэмжих юм бэ гэдэг бодлогуудад тусгайлан туссан байгаа. Мөн тэр саяын нарийн хэлсэн тооцоонууд бас давхар хийгдээд явж байгаа гэдгийг бас хэлье.

Р.Сэддорж: Жаргалан гишүүнд тодруулга байгаа юу? Байхгүй байна. Дащцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгээд хэдэн асуулт байна. Манай эдийн засаг том зах зээлийг зорих ёстой ААН-үүдийн хувьд ч гэсэн. Тэгэхээр экспорт болбол хамгийн чухал цэг болжээ. Тэгэхээр экспортын чиглэлээр манай өнгөрсөн хугацаанд явж ирсэн экспортын бүтэц болохоор худалдан авагчид маань өөрсдөө манай энэ өртгийн сүлжээний эхэнд нь хүрээд

ирдэг, урьдчилж мөнгө төлдөг, аман дээрээс нь авдаг, мах бэлтгэл дээр нь ордог, самар хураалт дээр нь ордог иймэрхүү байдлаар явж ирсэн. Тэгэхээр өөрөөр хэлбэл бид нар үнэ цэн бий болгох биш, баялаг бүтээх биш, ер нь болбол гаднын худалдан авагчдын л зүгээр ингээд нэг хэсэг болж явдаг. Тэгэхээр энэ талаар мөрийн хөтөлбөр дээр яг дорвитой бодлого юм ерөөсөө харагдаагүй. Тэгэхээр энэ экспортын нэг цонхны бодлого ч гэдэг юм уу энэ чиглэлийн асуудлуудаар ямар юм тусгаж байгаа вэ, ямар юм бодож байгаа вэ?

Тэгэхгүй болбол гадагшаа гараад ирэхээр эсвэл хоорондоо өрсөлддөг, эсвэл ингээд бие биеийнхээ жишээлбэл цаг зарж үнэ цэн бий болгосон зүйлийг нь унагадаг зүйлүүд бас байгаа. Тэгэхээр энэ бид нар экспортыг хөгжүүлнэ гэж ярьж байгаа боловч яг бодит байдал дээр болбол бодитой хийж байгаа юм бол байхгүй. Зам барина, нүүрс гаргана гээд байгаа болохоос яг цаанаа очоод ирэхээр чинь бүтэн шал өөр эдийн засгийн харилцаанд орж байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр ерөөсөө ахисан дэвшсэн юм харагдахгүй байна. Тэгээд энэ талаар бас хариулт авмаар байна.

Дээр нь төрийн өмчтэй холбоотой зүгээр удирдлагуудыг нь ТӨК-удын удирдлагуудыг нь мэргэжлийн багаар гүйцэтгүүлнэ гэж байгаа боловч яг энэ өмч хувьчлалтай холбоотой төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх, төрийн компаниудын хувьчлахтай холбоотой асуудал, дээр нь шинээр жишээлбэл хувийн хэвшилтэй өрсөлдөх компани байгуулахгүй байх талаар яг тийм тодорхой заалт хараагүй. Тэгэхээр энэ талаар бас яг энэ өмч хувьчлал болон цаашидаа энэ төр шинээр одоо жишээлбэл ингээд төрийн компаниуд бий болоод байдаг, судалгаа хийж байгаад л өөрсдөө нэлээн том хөрөнгө оруулалт хийх ийм төслүүдийг жишээлбэл төрийн компаниуд байгуулчихдаг. Энэ чиглэлээр бас хориглосон төр юунд орох уу, орохгүй

гэдэг талаар бас бодлого гаргана гэж түрүүчийн ЗГ-тай бас би ярьж байсан. Гэхдээ мөрийн хөтөлбөр дээр бас тодорхой тийм харагдсангүй.

Дээр нь ЗГ-ын бас нэг чухал ач холбогдол өгч байгаа зүйл нь болохоор зах зээл дэх төрийн оролцоог багасгана гээд байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр энэ зорилтот хөтөлбөр дээр жишээлбэл ДНБ-д эзлэх хувийн хэвшлийн оролцоо гээд үзүүлэлт байдаг. Энэ үзүүлэлтийг жишээлбэл 76,4 ч билүү дээ 2023 оны түвшинд байсан. Тэгээд энийг жишээлбэл энэ зорилтот түвшин хэмжих зүйл дээр бас гол үзүүлэлтүүдийн нэг болгоод оруулж болох уу? Энэ талаар юу гэж бодож байгаа вэ? Хэрвээ оруулъя гэвэл жишээлбэл 2028 он гэхэд энэ түвшнийг хэдэд хүргэх бололцоотой вэ гэж харж байгаа вэ? Ийм асуултууд байна. Тэгээд дээр нь нэмж тодруулж асууя.

Р.Сэддорж: Асуултуудад хэн хариулах вэ? Экспортын нэг цонхны бодлого, төрийн өмчийн хувьчлал, төрийн компаниудыг цаашидаа үүсгээд байх юм уу үгүй юм уу? 5 номер.

Л.Балчинлуvsан: Энхтүвшин гишүүний бас асуултад хариулъя. Экспортыг нэмэгдүүлэх талаар бодлогууд ялангуяа 3 дугаар бодлого буюу эдийн засгийн бодлого хүрээнд нэлээн томъёологдож орж өгсөн байгаа. Тэгэхээр яах вэ гэвэл эхний ээлжид бид нар бол уурхайн гол экспортын гол бүтээгдэхүүн болох бол уурхайн бүтээгдэхүүнүүдийг экспортлох гарцуудыг нэмэгдүүлъя. Энэ хүрээнд зүүн төвийн босоо тэнхлэгүүдийн төмөр замын холболт, авто замын холболтуудыг нэмэгдүүлэх ажлууд төсөл арга хэмжээнүүд энд туссан байгаа.

Мөн дээрээс нь эдийн засгийн коридортой холбогдох Евроази, к...-н орнуудтай холбогдох төсөл, дэд бүтцийн төсөл арга хэмжээнүүд төлөвлөж

өгснөөсөө гадна төрийн бизнес дэх төрийн оролцоог багасгаж, бизнес хөрөнгө оруулалтыг сайжруулах, төр, хувийн хэвшлийн түншилэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлэх ийм гол зорилгуудад нийцсэн арга хэмжээнүүдийг тусгаж өгсөн.

ТӨК-удын хувьд үр ашигтай ажиллаж байгаа компаниудын үйл ажиллагааг менежментийг сайжруулж, үр ашиг муутай байгаа компаниудын үйл ажиллагааг сайжруулах хэмжээнд арга хэмжээ аваад бүүр болохгүй бол тэрийг нь багасгах хэмжээнд ер нь төрийн оролцоог багасгах тийм бодлогууд туссан байгаа.

Р.Сэддорж: Өөр хариулах хүмүүс байна уу? Сайдуудаас хариулах сайд байна уу? Гантөмөр сайд. Гантөмөр сайдын микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Словенийн Ерөнхийлөгч ирчхээд тэнд бас нэг уулзалттай ингээд яагаад байгаа шүү, уучлаарай. Ер нь болбол төрийн оролцоог хязгаарлана гээд угаасаа заачихсан байгаа. Өрсөлдөхгүй гээд хувийн хэвшилтэйгээ өрсөлдөхгүй гэдгийг бол. Нөгөө талдаа одоо бид нарын хамгийн чухал зүйл бол үнэхээр төр хувийн хэвшил 2 хаанаа ингээд үрэлцээд байна гэдгийг богино хугацаанд тодорхойлмоор байгаа юм. Яг тодорхойлолт нь бүрэн гарахгүй байна Энхтүвшин гишүүнээ. Та хэд ч гэсэн энэ дээр жоохон тусалмаар байна. Үнэхээр бодитой хаанаа үрэлцээд, нөгөө хувийн хэвшилээ дарангуйлаад байгаа юм бэ гэдгийг аягүй тодорхой гаргаж өгмөөр байна. Бид нар болбол 2, 3 газар судалгаа захиалчихсан байгаа. Ингээд уулзаад нэг нэгээрээ ярихаар ингээд өөр өөр юм яриад байна. Хуулиа харахаар дахиад өөр байгаад байна.

Хууль хэрэгжихгүй байна уу эсхүл хувь хүмүүсийн харилцааны асуудал байна уу эсхүл төрийн албаны ёс зүйн

асуудал байна уу гэдэг ийм зүйл байгаа юм. Жишээлбэл та бүхэн их тодорхой гаргаж өгмөөр байна л даа. Одоо хэлэлцүүлэг бол манай гишүүдийн гар дээр ирчихсэн. Та бүхэн саналаа өгмөөр байгаа юм. Жишээлбэл татварын шалгалтыг 5 жилд нэг удаа хийнэ гэдэг ч юм уу мөн үү, хүссэн үедээ татварын шалгалт орохгүй, бид нэг санал гаргаад байгаа шүү дээ. Шүүхээр шийдэгдээгүй болбол данс хаахыг зогсооно гэдэг шиг үнэхээр хувийн хэвшилд төрийн зүгээс ирж байгаа дарамтуудыг ширхэгчлэн гаргаад арилгая. Энэ дээр Их Хурал ЗГ-тайгаа хамтарч ажиллах хэрэгтэй.

Их Хурлын гишүүд, Их Хурал маань зүгээр нэг ийм гаднаас ингээд шүүмжлээд байгаа юм шиг битгий байгаач гэж би та бүхнээс хүсмээр байна. Яг энэ өдрүүд бол та бүхний мэдэлд ирсэн шүү. Саналуудаа гаргаад, нарийвчлаад, юмаа нэг бүрчлэн уншаад энэ дээр саналаа тусгаад, гишүүддээ ойлгуулаад, дэмжүүлээд, ингээд ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулж өгөхийг хүсэж байна. Та бүхэн битгий юм хийгээч, битгий санал санаачилга гаргаач гэж ЗГ ерөөсөө хэлэхгүй байгаа. Байгаа зүйл дээр таалагдахгүй байгаа юмыг хасаж болно, дутуу орхисон юм байх юм бол нэмж оруулж болно. Яагаад гэвэл ЗГ-ын баримталсан байр суурийг би юун дээр их тодорхой хэлсэн шүү дээ засгийн юу Их Хурлын чуулган дээр. Бид бол аль болохоор товчлохыг оролдлоо, айхтар дэлгэрэнгүй юм гаргачихаар ингээд хүмүүс болбол энийг нь бүгдийг нь бичээд ороод ирэхээр хүслийн жагсаалт ороод ирлээ гээд ингээд шүүмжлээд байдаг юм. Тийм учраас одоо бол Их Хуралд эрх мэдэл нь байгаа. Энийг энэ тогтоолыг батлах, батлахын тулд үйл ажиллагааны хөтөлбөрт саналаа тусгах тэр боломжийг манай гишүүд ашиглаач, ашиглах хугацаандаа тодорхой нийгмийн.../минут дуусав/

Р.Сэддорж: Энхтүвшин гишүүн тодруулах уу? Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Экспорттой холбоотой саяын хариулсан юун дээр бол яг бас тодорхой хариулж чадсангүй гэж бодож байна. Тэгээд нэлээн бөөрөнхий ерөнхий хариулж байна. Тэгээд яах вэ мэдээж бас нөгөө асуудал шийдэж байгаа сайд нар нь ч хүмүүс нь байхгүй болохоор байж магадгүй байх. Зүгээр экспорттой холбоотой бодлогыг энэ дээр яах вэ энэ мөрийн хөтөлбөр дээр бас оруулчихмаар санагдаж байна. Тэгээд энэ дээр бид нар нэг бодлоготой явахгүй болбол энд жишээлбэл дандаа дотроо дэд бүтэц шугам барилаа ч гэсэн цаанаа гараад өрсөлдөж байгаа. Жишээлбэл түүхий нүүрс дээр жишээлбэл уул уурхайн бүтээгдэхүүн нүүрс дээр аваад үзэхэд гараад манай нүүрснүүд хоорондоо өрсөлдөж байгаа. Нэг нь хямдхан зараад, нэг төрлийн төстэй бүтээгдэхүүнүүд 2 өөр компани тусдаа гаргаад, 3 өөр, нөгөө талын зах зээл нь нэг учраас тэнчээнээ очоод өрсөлдөж байна. Махан дээр ч гэсэн адилхан, худалдан авагчид нь бүгдээрээ ороод ирчихсэн урьдчилгаа мөнгөө өгөөд тэгээд илүү үнэ цэн бий болгож энэ чиглэлээр хэдүүлээ бас юмнууд нэммээр санагдаж байна. Тэгээд яах вэ энэ чиглэлээр бас саналаа оруулъя гэсэн бодолтой байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Гантөмөр сайдын микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Тийм Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь болбол энэ биржээр худалдана гэдэг бол яг ТӨК-удын хувьд хамгийн зөв нь юм байна лээ. Энийгээ бол тууштай баримтлаад явна. Чадвал боловсруулсан бүтээгдэхүүнээ ч гэсэн бид нар адилхан Хятадын гүний бирж дээр худалдах тийм чадварыг өөртөө бий болгомоор юм байна лээ. Тэгэхээр бирж бол газар сайгүй ажиллаж байна. Тэгэхээр бирж дээр худалдаа явна. Уламжлалт нөгөө хэлцэл хийгээд, дундаас нь эрх мэдэлтэй хүмүүс мөнгө иддэг юмыг л бүр мөсөн таслан зогсооё л гэж байгаа юм. Биржийн үнэ бол хөдөлж болно, биржээс

болоод ямар нэгэн байдлаар экспорт удааширах ч юм уу, түргэсэж болно. Тэр бол түр зуурынх. Ерөнхийдөө өрсөлдөх чадвар нь болбол өөрөө тухайн бирж дээр бараа бүтээгдэхүүн нь ямар хэмжээнд зарагдаж байгаагаас хамаараад явах юм байна лээ.

Тэгэхгүй болбол сүүлийн үед сонсогдож байгаа зүйл бол биржийн гадуур тодорхой хувийн жишээ нь Эрдэнэс тавантолгой компанийн тодорхой хувийн нүүрсийг биржийн гадуур зарах юм биш үү. Энэ Монголын талаас нүүрс худалдаж авдаг энэ хүмүүс чинь болбол юу гэдэг юм тодорхой хязгаарлалттай байдаг юм биш үү ч гэнэ үү янз бүрийн яриа надад сонсогдож байгаа. Тэгэхдээ бид нарын барьж байгаа байр суурь бол бирж дээр худалдана энэ бол хатуу. Мэдээж хувийн хэвилийн түүхий эдийг нүүрсний худалдааг бид нар бирж рүү бүгдийг нь чирч ирнэ гэж байхгүй шүү дээ. Энэ дээр болбол зохицуулалт хийхэд их төвөгтэй. Тийм учраас ямар ч байсан ЭТТ гээд энэ ТӨК-ийн экспортын худалдаа болбол, Эрдэнэт үйлдвэрийн зэс ч адилхан бүгдээрээ биржийнхээ үнээр л явна. Их тодорхой л баймаар юм байна лээ. Унавал тэгээд л унана, босвол тэгээд л босно. Яг зах зээлийнхээ үнээр л зарагддаг гэдэг энэ зүйл дээр л байгаа юм.

Р.Сэддорж: Гантөмөр сайдад баярлалаа. Одоо болсон байх. Ер нь тэгээд ААН-үүд амьдрах чадвар гэж сая Гантөмөр сайдын яриан дээр гараад ирлээ. Том, жижиг нь хамаагүй тэр байгууллага ч байсан, хувь хүн ч байсан, айл ч байсан амьдрахын тулд яах ёстой вэ, хоолтой хонохын тулд яах ёстой вэ гэдгийг сая энэ маш зөв асуудал Дашицэрэнгийн Энхтүвшин гишүүн хөндлөө. Дараагийн гишүүн Энхбаярын Батиугар гишүүн. Батиугар гишүүний микрофон.

Э.Батиугар: Баярлалаа. Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе. Эдийн

засгийн өсөлтөө эрчимтэй байлгах нь гадаадын хөрөнгө оруулалт бол нь чухал. Тэгээд Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт дотоодын бүтээгдэхүүнд эзэлж байгаа хувь нь болбол 15-аас 12 хувьтай л яваад байгаа юм. Тэгэхээр бид энийгээ яаж нэмэгдүүлэх юм бэ, ямар аргачлал хайх вэ? 15 хувийн 12 хувь нь бол дангаараа Оюутолгой эзлээд байгаа. Хөгжиж байгаа эрчимтэй хөгжиж байгаа улс орнуудыг харахад болбол эдийн засгийнхаа 40-өөс 60 хувийг нь болбол шууд гадаадын шууд хөрөнгө оруулалт эзэлдэг. Энэ нь өөрөө болбол Монголын ханшны эрсдэл, Монголбанкны валютын нөөц болон цаашаа тэлэх бололцоог нь нээж өгч байгаа юм.

Өнөөдрийн байдлаар төлбөрийн тэнцэл бол 53 сая долларын алдагдалтай, урсгал данс 500 сая долларын алдагдалтай, 200 сая доллар байсан. Энэ бол цэвэр импорттой хамаатай л даа. Эдийн засаг идэвхжиж байгаатай холбоотойгоор. Үр дүнд нь болбол 5 тэрбум доллар байсан Монголбанкны нөөц 4,7 тэрбум доллар болчихсон. Тэгэхээр энийг Эдийн засгийн яамнаас асууя.

2-т нь Эдийн засгийн яамнаас энэ Хөгжлийн банкны статусыг яаж тодорхойлох вэ? Яг экспортыг дэмжиж, импорт орлодог бүтээгдэхүүнүүдээ болон мега төслүүдийг санхүүжүүлдэг байх уу аль эсвэл өнөөдрийн байгаагаар ердөө л өр зээлтэй ноцолдоод л байгаа тийм институт болчихсон байна л даа. Тэгэхээр энийг яаж илүү эдийн засгийн үндсэн тулгуурыг санхүүжүүлдэг тийм институтийн хувиар нь ажиллуулах вэ?

3-д нь болбол ийм байгаад байгаа юм. Экспорт долларын орлоготой компаниуд бүгдээрээ уул уурхайн компаниуд Монголбанканд шууд ченж хийлгээд байгаа юм. Нэг ёсны доллароо, юаниа шууд Монголбанканд авчраад төгрөг болгоод солиод. Энэ нь ямар үр дүн авчирч байна вэ гэхээр 1 дүгээрт Монголбанк шууд М2-ыг бол

автоматаар өсгөөд, үүнийг дагаад төгрөгийн хани идэвхтэй буурах бололцоо нь олгогдохгүй. Мөн зах зээл дээр байгаа банкнуудын дунд байгаа валютын нөөц бас багасаад байгаа юм. Тэгээд 7 хоног болгон 100-аас 150 сая доллар дуудлага худалдаагаар Монголбанкнаас худалдаж авдаг доллароо. Яг өөрсдөд нь болбол яг доллар байхгүй. Үр дүнд нь болбол зах зээлийн хани болбол энэ юу гэдэг юм чангарч өгөхгүй байгаад байгаа юм төгрөгийн хани. Долларын хани болбол чангарах нөхцөл нь байгаад байгаа.

Яагаад гэвэл Монголбанкны албан хани болбол тухайн өмнөх өдрийн банкнуудын хоорондох жигнэсэн дундаж ханшийг шууд л тавьдаг л даа. Тэгэхээр заавал ченж хийхгүй, жинхэнэ зах зээлийн эдийн засаг руу шилжээд, ядаж нэг үе шаттайгаар арилжааны банкнууддаа компаниудын долларын болон гадаад валютын орлогыг нь өгөөд, хэрвээ банкнуудад активынх нь валютын актив нь нэмэгдээд эхэлбэл тэд нар чинь болбол доллароо шууд Монголбанканд зарах тийм бололцоо нь байх л даа.

4-д нь болбол Сангийн яамнаас асуухад энэ ханшийн эрсдэлээ 29 тэрбум их наяд төгрөгийн гадаад арилжааны өрнийхөө ханшийн ханшийн эрсдэлээ ямар менежмент хийх вэ?

Р.Сэддорж: Асуултад хариулья. Гантөмөр сайдын микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Ер нь гаднын хөрөнгө оруулалт бол улс орны хөгжилд аймар чухал байдаг. Тэрийг бүгдээрээ мэддэг. Хөрөнгө оруулагчид зугтаж байгаа, нэмэгдэхгүй байгаа. Тэрийг Монголчууд бид нар бүгд мэдэж байгаа. Учир шалтгаан болбол бид нарын тогтворгүй байдалтай л холбоотой. Худлаа ярьдаг, амласнаа хийдэггүй. Японд очихоороо манайд ирж уран олборло гэж хэлдэг, Ерөнхий сайд нь буцаад Монголд бууж байхад уран олборлохгүй гэдэг хууль баталж байдаг

тийм ээ. Тэгээд нэг тогтвортой байдлын нэг гэрээ хийчихдэг, араас нь улс төрчид нь мөлжсөөд эхэлдэг. Хамгийн сүүлийн жишээ энэ Концессын хууль шүү дээ. Концессын хуулиар баахан амьтантай гэрээ хийнэ гэж хошихируулж гэрээ хийчхээд, хуулиа байхгүй болгочихсон. Тэгээд тэр улсуудыг юу гэж ойлгох вэ? Тэр улсууд Монголыг юу гэж ойлгох вэ? Тэгээд одоо үхсэн хууль амилуулж байна гээд олон юм яриад суугаад байгаа шүү дээ бид нар. Тэгээд тэр улсуудыг одоо зүгээр хая гэж байгаа байхгүй юу. Ингээд хаяад байх юм бол Батишугар гишүүнээ хэн хөрөнгө оруулах юм, хэн ирэх юм, хэн итгэх юм бэ.

Тийм учраас болбол манай парламент юунд анхаарах вэ гэхээр тогтвортой хуулийн орчиндоо их сайн анхаарах хэрэгтэй. Ер нь болбол хууль засагладаг улс болчиход хөрөнгө оруулалт тасрахгүй. Уул уурхайн орон болбол ганихан зүйлийг л шаарддаг улс төрийн орчин чинь тогтвортой байх уу. Бид өнөөдөр хамтарсан засаг байгуулж байгаа үндсэн шалтгаан тэр шүү дээ. Ер нь энэ тогтворгүй байдал, тэгээд энэ гадна, дотнын улс төрийн нөлөөнөөс ангижирч байж бид нар жосоохон амьдрах юм байна энэ улс. Тэгэхгүй бол мөнхийн эрсдэлтэй, мөнхийн баян хоосны дундуур ингээд яг яах гээд байгаа нь тодорхойгүй, ард түмэн итгэлгүй, дэлхийн улс орны хувьд ч гэсэн ямар ч итгэлгүй улс болж хувирч байгаа байхгүй юу.

Аль нэг нь дангаараа 8 жил засаглахад гудамжны улс төрөө дийлэхгүй том төсөл нь хөдөлдөггүй ийм л байдалтай байгаа шүү дээ. Тийм учраас одоо манай гишүүд болбол юунд анхаарах вэ гэхээр тогтвортойгоор хэрхэн сайжруулах вэ гэдэг дээр анхаарч өгөөч. Энэ бол зөвхөн ЗГ-аас хамаардаг зүйл биш. Ийм амласнаасаа ухардаг худлаа ярьсан аягүй олон тохиолдол Монгол Улсад байгаа. Тийм учраас л гаднын хөрөнгө оруулагчид үргээж байгаа юм 1.

2 дугаарт айхавтар ид шидтэй технологи байхгүй. Одоо бид нар Гаицуун сухайт-Ганц модныхоо тэр холболтыг л хийчих хэрэгтэй байхгүй юу. Тэгээд тэрийгээ хийж чаддаггүй улс төржүүлээд байдаг, ингээд явдаггүй. Тийм учраас болбол энэ хилийн гарцыг нэмэгдүүлэхэд бол бидний өнөөдөр энэ уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаар болбол бид нар 4 жилээ бол давчихна. Бид нар тогтвортой уул уурхайг дэмжээд, энийгээ өндөр технологи шингэсэн аж үйлдвэрийн салбар болгож хувиргах юм бол бид нар баталгаатай улс орон болно. Яагаад барууны хөрөнгө оруулагчид Монголыг тойроод байгаа вэ гэхээр ерөөсөө худлаа ярьдагт нь л тэгж байгаа юм. Аль ард түмэнд таалагдах сэдэв гарангуут тэрийг өлгөж аваад ажил хийж байгаа хүнээ балбадаг ийм амьдрал.../минут дуусав/

Р.Сэددорж: Тэргүүн шадар сайдад баярлалаа. Долларын ханштай холбоотой асуудлыг Сангийн яам, Хөгжлийн банкны тухай, 6 номер уу? 6 номерыг өгье. Хэн хариулах гэж байна вэ? Гишүүдийн асуултад анхааралтай сонсож, тэмдэглэж, хариулах хэрэгтэй.

Б.Мөнх-Эрдэнэ: Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын хэлтсийн дарга Мөнх-Эрдэнэ. Гишүүний асуултад хариулъя. Албан валютын ханш одоо 3381 төгрөг байгаа. Монголбанкны зарлаж байгаагаар. Өөрөөр хэлбэл арилжааны банкнууд дээр байгаа жигнэсэн дундаж ханш гэсэн үг. Энэ маань бол сүүлийн 1 сарын хугацаанд болбол огт төгрөгийн доллартой харьцах ханш бол сулраагүй. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 3 хувиар чангарсан байгаа төгрөг долларын эсрэг. Өөрөөр хэлбэл өнгөрсөн сүүлийн нэг жилийн хугацаанд болбол төгрөгийн валютын ханш болбол долларын эсрэг болбол чангарсан буюу төгрөгийн үнэ цэн өсөж байгаа.

Компаниуд болбол ТӨК-уд болбол долларын валютуудаа бол Монголбанканд тушааж байгаа. Хувийн компаниуд болбол банканд тушаах нь нээлттэй байх гэж бодож байна.

Р.Сэддорж: Нэмж тодруулж хариулах хүмүүс байна уу? Сангийн яам үргэлжлүүлж хариулъя.

Б.Анар: Эдийн засгийн хөгжлийн яам Хөрөнгө оруулалтын бодлого Анар. Хөгжлийн банкны асуулттай холбоотой нэмж хариулт өгье. Хөгжлийн банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх нь бол Эдийн засгийн хөгжлийн яам руу саяхан шилжиж ирсэн байгаа. Хөгжлийн банкны Экспорт импортын банк болгосноор бол Хөгжлийн банкны үйл ажиллагааны асуудал бол шийдэгдэхгүй. Ер нь цаашид яг энэ чиглэлийн санхүүжилтийг түлхүү дагнаж олгодог болохын тулд банкных нь өөрийнх нь хууль дээр нь бас тодорхой өөрчлөлтүүд орох зайлшгүй шаардлага бол байгаа.

Эхний ээлжид бол энэ урт хугацаатай, хүү багатай эх үүсвэрүүдийг татах чиглэлээр энэ Хөгжлийн банкны үйл ажиллагааг бол цааши нь жигдрүүлж явуулах ёстой. Мөн засаглалыг нь сайжруулах чиглэл рүү бол анхаарч ажиллах ийм шаардлага бол байгаа.

Р.Сэддорж: Батиугар гишүүн тодруулж асууя.

Э.Батиугар: Гадаад валютын орлоготой компанийн дийлэнх нь л төрийн өмчийн компанийн ЭТТ, Эрдэнэт, ОТ гэх мэтчилэн л байгаа л даа. Тэгэхээр заавал Монголбанканд гадаад валютаа тушаахгүйгээр зүгээр зах зээлийн журмаараа арилжааны банкнуудад үе шаттайгаар тушаагаад энэ зах зээлийн эдийн засгийн идэвхжилтийг нэмэгдүүлэх тийм төлөвлөгөө байгаа юу?

2-т нь Хөгжлийн банк болбол Эксим банк гээд байна л даа. Яг Эксим банк өөрөө шал өөр статустай шүү дээ. Дотоодын компаниудын экспорт гаргаж байгаа, тэгээд гадаад улс оронд санхүүжилтээ олгодог. Харин эсрэгээрээ яах вэ урт хугацааны хямдхан эх үүсвэр татаж болно. Гэхдээ ямар байдлаар бид нар санхүүжилтээ олоод, ямар ямар төслүүдийг яг санхүүжүүлэх вэ гэдэг дээр нь л тодорхой хариулт авмаар байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Тэргүүн шадар сайд Гантөмөр сайдын микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Тэгэхээр Батиугар гишүүний тавиад байгаа асуудал болбол зөв. Хөгжлийн банк бол өнөөдөр банк гэж хэлэхэд хэцүү нэг тийм дампуурчихсан Түц маягийн юм байгаа. Дампуурсан шалтгаан бол босгосон мөнгөө хэрхэн санхүүжилт хийх вэ гэдгээ ерөөсөө ойлгоогүй, төслийн санхүүжилтийг ерөөсөө ойлгоогүй, зарчмыг нь ойлгоогүй. Даахгүй учраас жоохон эх үүсвэртэй байж төслийн бүтнээр нь санхүүжүүлэхийг оролдсон, төслүүдийн 70 хувийг хүргэж санхүүжүүлэхийг оролдсон. Энэ дээр л алдаа гарсан. Өөр Хөгжлийн банкнаас өөр хэн нэгэн эрсдэл үүрээд хамтраад санхүүжүүлж байгаа төсөл рүү л явах хэрэгтэй Батиугар гишүүнээ. Дараалал бол тэгж гарна.

Дараалал болбол өөр банк жишээлбэл Азийн банк ч юм мөн үү, өөр нэг Goldman Sachs юм уу, аль нэг банк тодорхой хувийг нь санхүүжүүлж байгаа бол тэр төсөлд бид нар итгэх хэрэгтэй. Ингэж байж манай Хөгжлийн банк бол санхүүжилт нь баталгаатай, үнэхээр хөгжлийн төлөөх төслөө санхүүжүүлдэг болно. Тэгэхгүй болбол хөгжлийн төслийг бид нар шийддэг, өөр хүн санхүүжүүлдэггүй, тэгээд Хөгжлийн банк нь 70, 80 хувийн санхүүжилт гаргадаг ингээд дампуурдаг. Тийм учраас энэ санхүүжилт дээр таны санаа зовж байгаа туйлын зөв.

Нөгөө талдаа мөнгөний бодлогоо та нар Монголбанкаа дуудаад Эдийн засгийн байнгын хороон дээр олон удаа ярилцах хэрэгтэй, нээлттэйгээр олон удаа ярилцах хэрэгтэй. Тэгж байж шийдэл гарна. 2 талд суучихаад нэгэн рүүгээ чулуу шидэж ерөөсөө болохгүй. Эдийн засгийн байнгын хороо, Монгол банк 2 бол хүн холбоотой 2 байгууллага шүү. Тийм учраас хамтарч сайн ажиллаарай.

Тэгээд эцэст нь Байнгын хорооны гишүүдээсээ хүлцэл өчье. Би тэр Ерөнхийлөгчийн уулзалтад ингээд 11 цагаас заавал орох юм байна. Тэгээд манай энэ газрын дарга нар болбол асуудлаа мэдэж байгаа, асуултдаа хариулаад явчих учраас та бүхнээсээ чөлөө хүсье, баярлалаа.

Р.Сэддорж: Гантөмөр сайдад баярлалаа. Өөр нэмж тодруулах, юу хэлэх хүмүүс байхгүй учраас дараагийн гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Уг нь Тэргүүн шадар сайдаас асуух асуулт байсан юм. Уул уурхай эцэг өвгөдөөс үлдээсэн баялаг. Тэгээд гол нь энэнийг иргэд яагаад эсэргүүцээд байна гэдгийг ер нь судалгаа хийж үзсэн үү Уул уурхайн яам? Одоогийн эрдэс баялаг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. Тэгээд энэ дээр их учир дутагдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр маш сайн судлах хэрэгтэй. Яг яагаад эсэргүүцээд байгаа юм бэ? Тэгвэл энэ Багануур, Эрдэнэт гээд Монгол Улсыг олон жил авч явсан энэ нь яаж ямар зарчмаар явдаг байсан юм гээд нэг аймаар шинэ юм судлаад байх шаардлагагүй байхгүй юу. Тэгээд өргөн хүрээнд ийм судалгаа хийж байж яг иргэд яагаад эсэргүүцээд байгаа юм гэдгийг тогтоох хэрэгтэй. Тэгээд юугаар дэмжих вэ гэдгийг.

Үндэсний баялгийн сангийн тухай хууль дээр эрүүл мэнд, боловсрол, орон

сууц, нөгөөдөх нь хөгжлийн төслүүдийг санхүүжүүл гээд. 3-д нь нэг зүйлийг нэмж оруулах шаардлага байгаа гэж үздэг. Тэгээд энэ дээр би гол нь хариулт авах гээд байгаа юм. Ямар шаардлага байна гэж үзсэн юм гэхээр эндээс иргэдийн, өрхийн, хувийн хэвшлийн бизнес эрхлэх тэр хөнгөлөлттэй зээл, энэ шинэ хоршоо хөдөлгөөн шиг ийм дэмжлэгийг үзүүлэх ийм заалтыг нэмж оруулах. Тэгээд хүн бодно шүү дээ уул уурхайгаас орж байгаа, энэ эрдэс баялгаас орж байгаа орлогоос миний бизнес хийхэд, миний өрхийн аж ахуй эрхлэхэд ийм дэмжлэг үзүүлэх юм байна гээд. Энэ дээр Эрдэс баялгийн яам ямар нэгэн судалгаа байна уу?

2 дугаарт нь Байгаль орчны яамнаас энэ бэлчээрийг зохистой ашиглах асуудал бол аймар чухал. Өмнө нь 20 сая гаруй малтай байхдаа Монгол Улс өвөлжөө, хаваржааны хашааг хоорондоо 5км-ийн зайтай барьдаг байсан шүү дээ. Тэгээд энэ өвөл ямар зуд боллоо. Энэ бол бэлчээр хомсодсоноос шалтгаалсан зуд. Өөрөөр хэлбэл өвсгүй бэлчээргүй болохоор энэ салхийг чинь хорьж хаах юм байхгүй болоод ингээд хатуураад шилэн зуд, мөсөн нь зуд болж байгаа. Тийм учраас энэ дээр 1 дүгээрт өвөлжөө, хаваржааны доорх газар гүний худгийн цооног хоорондын зайг доод хэмжээг стандартаар тогтоох талаар хийсэн судалгаа Байгаль орчны яаманд байна уу?

2 дугаарт энэ өвөлжөө, хаваржааны газрыг зарж арилждаг зүйл хэрээс хэтэрлээ. Олон мянган адуутай айл очоод нэг айлын өвөлжөө, хаваржааг авчихдаг. Тэгээд тэр хавийн бэлчээрийг талхалдаг. Тэгээд өмнөх нийгмийн үед чинь адуу чинь энэ сумын захад байдаг байсан шүү дээ. Энэ дунд ингээд бусад малтай холилдоод байж байдаг зүйл байхгүй. Тэгэхээр энэ дээр энэ хоорондын зайг тогтоох талаар болон энэ өвөлжөө, хаваржааны газрыг бусдад шилжүүлэхийг хориглох, зөвхөн өвлүүлдэг байх энэ талаар хийсэн

судалгаа ер нь Байгаль орчны яаманд байдаг уу? Яагаад гэвэл энэ хүрээлэн буй орчин бэлчээр гэдэг чинь аймар чухал шүү дээ. Хамгийн чухал зүйл. Бидний оршин амьдрах гол ногоон эх орон маань, эх дэлхий маань. Тэгээд энийг би бас 2 дугаарт нь асууя.

3 дугаарт нь эргээд Эрдэс баялгийн яамнаасаа энэ ашигт малтмалын томоохон ордуудад техник, эдийн засгийн үнэлгээ, байгаль орчны үнэлгээнээс гадна энэ нийгмийн үнэлгээ гэдэг зүйл хийдэг үү? Тэнд ажиллах уурхайчин залуус, тэдний гэр бүл, тэр амьдрах орчны талаар болон ер нь цаашидаа ийм хотхон байгуулах, нийгэм, соёлын үйлчилгээ үзүүлэх энэ чиглэл.../минут дуусав/

Р.Сэддорж: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Дугаартай микрофон дээр очиж суух уу?

Э.Батболд: Сайн байцаана уу. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Батболд. Гишүүний асуултад хариулъя, нэгмөсөн хариулчихъя даа 2 асуулт байсан. Манай дээр яг одоохондоо тийм судалгаа хийгээгүй байна гишүүнээ. Бид нар мэдээж энэ судалгааг хийх гээд ажлын хэсэг гаргах гээд яриад явж байгаа. Нийгмийн болон юуны яагаад эсэргүүцээд, уул уурхайг эсэргүүцээд байдаг, ард түмэн эсэргүүцдэг тухайн судалгаа хийх гээд явж байгаа. Одоохондоо ийм судалгаа алга.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүн байна уу? Бэлчээрийг бол Бадамсүрэн гишүүн уучлаарай бид 2 чинь уг нь ярьсан юм. Яах вэ нөгөө энэ Улсын Их Хурлын Тамгын газраас ингээд шахаад байдаг гэнэ. Байгаль орчны байнгын хороон дээр та нэг ороод хэлчхээч гэж байна. Тэр протокол их чухал. Тэгэхээр 11 цагаас эхэлж байгаа, таныг бас тийшээ ороод нэг гялс энэ асуудлаа хэлчхээрэй. Одоогийн юун дээрээ энэ Байгаль орчны яамнаас хариулах юмнууд байвал. Байнгын хорооны эрхлэх асуудлын

хүрээнд хамаарах асуудал байвал 2 номерын микрофон.

Э.Баттулга: Гишүүний асуултад хариулъя. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээр болбол яг энэ бэлчээр ашиглалттай холбоотой заалт болбол байгаа. 3.1.2.3 дээр энэ хөдөө аж ахуй, газар тариалангийн бүс нутагт байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлж, нөхөн сэргээх, хамгаалалтын зурвасыг нэмэгдүүлэх, байгальд түшиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ гэсэн ийм ерөнхий заалтын дотор малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэн сүргийн зохистой бүтцийн харьцааг бүрдүүлж, бэлчээр ашиглалтын ачааллыг тэнцвэржүүлнэ гэсэн ийм зорилт болоод орчихсон байж байгаа.

Таны асуусан энэ нөгөө бэлчээрийн даацтай холбоотой судалгаа надад хамгийн сүүлд байгаа нь болбол энэ байгаль орчны төлөв байдлын тайлан байгаа Монгол Улсын. Энэ дээрээс болбол бэлчээрийн даацын тооцоо болбол нийт нутаг дэвсгэрийн 50 гаруй хувьд нь бол өвөл, хаврын бэлчээрийн даац хүрэлцээтэй байхаар, харин 50 хувьд нь болбол хэтэрч байхаар ингээж ЦУОШГ-ын судалгаа гарсан байна.

Р.Сэддорж: Гишүүн тодруулах уу? Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

М.Бадамсүрэн: Энэ бол манай Байнгын хороонд хамааралтай л даа. Энэ бэлчээрийн асуудал чинь. Энэ иргэдийн малчдын амьжиргааны асуудал байхгүй юу. Малчдын орлого, эдийн засаг цаашидаа энэ яаж энэ ганц маллаж байгаа өөрийн эрхэлж байгаа энэ аж ахуйгаасаа орлого олох вэ, эдийн засгийн хувьд яаж баталгаатай байх вэ гэдэг асуудал. Тийм учраас энийг би Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газар буруу зөвлөгөө өгч байна гэж бодож байна. Энийгээ бас хэлье. Тэгээд энийг бас Байнгын хорооны даргаас асууя. Яг ингээж болж байгаа юм уу?

2 дугаарт нь энэ судалгаа байгуулах, судалгаа хийх ажлын хэсэг Уул уурхайн яамны энэ дээр чинь энэ ажлын хэсэг чинь байгуулагдвал би бас оролцоно шүү. Тэгээд яагаад гэвэл энэ Дорнод аймагт газрын тосны олборлолт 95 хувь нь явдаг байхгүй юу. Тийм учраас энэ зовлон бэрхшээлийг Дорнодчууд хамгийн сайн мэднэ. Нэг их мэргэн үзэгдээ биш. Тийм учраас энэ бид нарын зорилго болбол энэ улс орны цаашидын хувь заяаны асуудал учраас энэ зүйл дээр заавал энэ дээр бас оролцож, санал бодлоо хэлж явна шүү.

3 дугаарт нь Байнгын хорооны даргаас бас тодруулга байна. Энэ саяын энэ томоохон эдийн засгийн энэ асуудлуудаар хүрээлэн буй орчны, иргэдийн амьжиргаатай холбоотой энэ асуудлуудаар Байнгын хорооноос бас ажлын хэсэг байгуулж өгөөч гэсэн ийм санал байна. Та энэ дээр бас боломжтой юу хариулт өгнө үү? Баярлалаа.

Р.Сэддорж: Өмнөх асуултуудад хариулах хүн байна уу? Энэ бол бас Бадамсүрэн гишүүний хэлээд байгаа бол зөв байхгүй юу. Энэ бол энэ малчдын эдийн засагтай холбоотой, амьжиргаатай холбоотой асуудлууд учраас бас манай Байнгын хороо анхаарах ёстой асуудал. 1 номер уу? 1 номерын микрофон.

Ш.Мөнхцэрэн: Гишүүний асуултад хариулья. ЗГХЭГ Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Мөнхцэрэн байна. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үнэлгээг бол тогтоод хуулиар бол хийдэг. Олон жил бол 20 жилийн хугацаанд бол зөвхөн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийж явсан. Өнгөрсөн онд бол ЗГ-аас бол байгаль орчны болон хууль дээр бол нийгмийн болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийж хийнэ гэж бол заасан байдаг. Үүний дагуу бол ЗГ-аас бол журмыг батлаад нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх журмаа бол

гаргасан. Байгаль орчны яам болон хөдөлмөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалаа бол боловсруулж байгаа. Үүний дагуу бол нийгмийн нөлөөллийн үнэлгээг албан ёсоор хийдэг болох тогтолцоог бол оруулж ирж байгаа.

Р.Сэддорж: Бадамсүрэн гишүүний тэр ажлын хэсэг байгуулж болох талаар бид нар судалж үзье. Тэгээд таны саналыг хүлээж авлаа. Ажлын албаныхан энэ талаар ажилдаа ороорой. Ингээд Одонгийн Цогтгэрэл гишүүн энэ үг хэлэхээс татгалзаж байгаа. Энэний оронд Батсүмбэрэл гишүүнийг нэмье. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Сайн байцаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Мөрийн хөтөлбөр бол ер нь бол маш үнэ цэнтэй бичиг баримт. Энэ бол мөрөөдлийн жагсаалт байх ёсгүй? Маш бодитой, маш үндэслэлтэй тийм төслүүд, тийм заалтууд бол энд орж ирэх ёстой гэж ингэж бодож байна. Эрчим хүчтэй холбоотой мөрийн хөтөлбөрийг харахаар нийтдээ 11 иирхэг 2710мвт-ын ийм хүчин чадалтай эх үүсвэрийг барина гэсэн ийм төлөвлөгөө орж ирсэн байна л даа. Тэгэхээр энэ хэр үндэслэлтэй тоо вэ? Эдгээр эх үүсвэрүүдээс хэдийнх нь ТЭЗҮ зураг төсөл буюу бэлтгэл ажил хийгдсэн, хэд нь хийгдээгүй тийм эх үүсвэрүүд байгаа вэ гэсэн ийм 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуулт нь болохоор Мандалговь дээр 2000мвт-ын нарны цахилгаан станц, нар салхин эх үүсвэр барина гэсэн ийм төлөвлөгөө байна. Тэгэхээр энэ 2000мвт гэдэг чинь бас маш том тоо. Яг манай эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадал 1500 гаруй байгаа. Тэгэхээр тэнд энийг дамжуулах шугам ч байхгүй байгаа. Тэгэхээр энэ тоо бодитой тоо юу?

3 дугаарт нь болохоор мөн Өмнөговьд 3000мвт-ын нар, салхины эх үүсвэрийг барьж экспортлоно гэсэн ийм заалт орж ирсэн байна. Тэгэхээр энэ бас хэр үндэслэлтэй тоо вэ? Энэ 3000 гэдэг тоо хаанаас гарсан юм бэ? ТЭЗҮ нь хийгдчихсэн юм уу? Хэрвээ хийгдээгүй бол ингэж тоо тавьж орж ирэх нь бас хэр зохимжтой юм бол гэсэн асуулт байна.

Дараа нь болохоор Улаанбаатар шинэ Хархорумын чиглэлийн 500 киловольтын шугамын төслийн бэлтгэл ажлыг хангана гэсэн ийм орж ирсэн байна л даа. Тэгэхээр одоо бид нарын ашиглаж байгаа хамгийн өндөр хүчдэл бол 220 киловольт байгаа. Түүний дараа 300 киловольт, 330, 400 киловольт гээд олон төрлийн хүчдэлүүд байдаг. Тэгэхээр энэ хүчдэлийн түвшинийг сонгоно гэдэг нь өөрөө болохоор маш үндэслэлтэй, маш тооцоо судалгаатай ийм гарч ирэх ёстой. Гэтэл энэ хүчдэлүүдийг алгасаад бүүр бүр 500 киловольтын шугам гэж ингэж орж ирж байгаа нь бол бас их гайхалтай харагдаж байна л даа. Тэгэхээр энэ бас хэр үндэслэлтэй ийм тоо байдаг юм бэ? Яагаад гэхээр нэгэнт л ийм тоо тавьчихсан бол тэр энэ дээр зураг төсөл хийгдэнэ, ТЭЗҮ хийгдэнэ гэх мэтчилнээр ингээд хөрөнгө оруулалт хийгдээд явах учраас бид нар маш үндэслэлтэй юман дээр хөрөнгө оруулалтаа зарцуулж байх ёстой л доо. Тэгэхээр энэ ийм асуултад хариулж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Асуултад хариулъя. Эрчим хүчний асуултууд байна тийм ээ?

М.Энхцэцэг: Тийм.

Р.Сэддорж: 1 номерын микрофон Тавинбэх дарга.

Н.Тавинбэх: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нүүрсээр ажилладаг технологитой эх үүсвэрүүдийн талаар асууж байна. Энэ

эх үүсвэрүүдийг бид их олон эх үүсвэр санал байгаа. Хувийн хэвилийн болоод төрийн хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөсөн. Энэ дотроос бид эрэмбэлж байгаад хэрэгжих хамгийн магадлалтай нь бас таны саяын асуудаг хэрэглээний өсөлтөд тулгуурлаж энэ төслүүдийг сонгож авч, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан гэдгийг хэлье. Энэ төслүүдийн дийлэнх нь болбол бэлтгэл ажил бүрэн хангагдсан ийм төслүүд байгаа.

Жилд дунджаар цахилгаан эрчим хүчний хэрэглээ 8 орчим хувиар өсөж байна. Энэ болбол 100-аас 150 мвт гэсэн үг. Энэ маягаараа явбал 2028 онд гэхэд 1000, 2700мвт, 2030 он гэхэд 3300 орчим мвт хүрэхээр ийм хэрэглээний тааз гарч байгаа. Энэтэй харьцуулбал энэ ашиглалтад оруулахаар ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан ашиглалтад оруулахаар тусгачихсан эх үүсвэрүүдийн хүчин чадал бол үндэслэлтэй. Та мэргэжлийн хүн. Нөгөө талд нь бас одоо ашиглагдаж байгаа эх үүсвэрүүд болбол бас тодорхой хэмжээгээр ашиглалтаас хасагдах ёстой, үйлдвэрлэл явуулахаа болино гэсэн үг. Тэгэхээр энийг тооцож ингэж төлөвлөж оруулсан байгаа.

Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хувьд болбол ЗГ-ын мөрийн хөтөлбөр төсөл боловсруулах үед болбол Эдийн засаг, хөгжлийн яамтай бас зарчим зөрүүтэй саналууд байсан. Одоо ЗГ дээр нэгэнт дэмжигдээд гараад ирсэн учраас хэлэх юм алга. Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн талаар болбол Эдийн засгийн хөгжлийн яаман дээр илүү мэдээлэлтэй байгаа. Энэ дээр тодруулж хариулах байх. Нэмж болно.

Улаанбаатар шинэ Хархорумын хувьд болбол бид нар бэлтгэл ажил хангана гэж байгаа. Хүчдэлийн түвшин нэмэгдэх нь бол муу зүйл биш. Ялангуяа хэт өндөр хүчдэл рүү шилжих нь болбол дамжих дамжуулах сүлжээний мөрөөдөл. Мэдээжийн хэрэг хэт өндөр

хүчдэлд шилжих нь сайн боловч хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаардсан ажил. Энэ цаг үед бол санал нэг байна. Монгол Улсын хэмжээнд 330 киловольтын габридтай хийцтэй 220 киловольтын шугам хамгийн өндөр нь ашиглагдаж байгаа. Тэгэхээр энэний хүчдэлийн түвшин дээр ч гэсэн бид нар бас бэлтгэл ажил хангах хүрээнд эргэж ярилцана гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа гэдгийг хэлье. Хариулт боллоо.

Р.Сэддорж: Манай Байнгын хорооны хурал дээр Монгол Улсын сайд, 20 минутын хот үндэсний хорооны дарга Эрдэнэбүрэн сууж байгаа, сайд сууж байгаа. Хариулт болсон уу Энхцэцэг гишүүн, тодруулга байна уу? Тодруулга Энхцэцэг гишүүний микрофоныг өгье.

М.Энхцэцэг: 2 асуултад Эдийн засгийн хөгжлийн яам хариулна гээд тэгсэн хариулаагүй байна л даа. Нэг нь болохоор тэр Мандалговь дээр 2000мвт гээд нар салхины эх үүсвэр барина гээд. Энэ бол ямар ч үндэслэлгүй юм шиг харагдаж байгаа. Тэгэхээр энэ дээр бас тайлбар авах хэрэгтэй байгаа.

Мөн говийн бүсэд 3000мвт-ын нар салхины эх үүсвэр бариад экспортолно гэсэн. Тэгэхээр энэ дээр Эдийн засгийн хөгжлийн яамнаас хариулт авахыг хүсэж байна.

Р.Сэддорж: Эдийн засгийн хөгжлийн яам 6 номер. Мандалговийн 20 мянган мвт-ын.

М.Энхцэцэг: 2000мвт гэсэн байгаа.

Р.Сэддорж: Өмнөговь аймгийн 3000мвт тайлбарлаарай.

Б.Анар: Эдийн засгийн хөгжлийн яам Анар. Энхцэцэг гишүүний асуусан эхлээд нөгөө ТЭЗҮ-тэй холбоотой асуултад хариулъя. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт 149 орчим төсөл туссан. Үүнийх нь ойролцоогоор 40

орчим төсөл нь бол яг бэлэн ТЭЗҮ-тэй төслөө хэрэгжүүлээд явах боломжтой ийм төслүүд бол байна. Яг тэргүүлэх чиглэлийн 14 төсөл туссан байгаагаас үүний 8 төсөл нь бол яг бэлэн ТЭЗҮ-тэй, бусад нь бол яг ТЭЗҮ-үүд нь бол одоогоор яг хийгдэж байгаа төслүүд байна.

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт бол 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх төслүүд тусдаг. Тэгэхээр заавал бүх төслүүд нь бас ТЭЗҮ нь бэлэн байх албагүй. Тодорхой үе шаттайгаар санхүүжилтийнхээ төслийн санхүүжилтийнхээ зарчмаар эх үүсвэртээ тааруулаад тухай тухайн үед нь ТЭЗҮ нь бэлэн болсон төслүүд нь түрүүлээд хэрэгжээд явах байх гэсэн ийм бодолтой байна.

Сэргээгдэх эрчим хүчний хувьд бол яг нарийн тоотой асуудлуудыг бол уул нь ЭХЯ хариулсан нь зөв байх. Эдийн засгийн хөгжлийн яам ер нь ЗГ-аас барьж байгаа бодлого юу юм бэ гэхээр цаашидаа энэ цэвэр ногоон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг нэмэгдүүлье. Зөвхөн заавал дотоодын хэрэгцээндээ ашиглахаасаа гадна боломжтой бол гадагшаа экспортлох бодлого баримталъя гэсэн ийм л бодлогыг баримталж байгаа юм. Тодорхой яг хүчин чадал боломжтой эсэх байрилын талаарх бол мэдээллийг бол ЭХЯ тодорхой тэрийг нь хариулсан нь зөв байх.

Р.Сэддорж: Тодруулгад хариулж хариулах уу ЭХЯ? Энэ бас олон жил яригдсан л асуудал л даа. Тэгээд нэг тийш нь нэг зоригтойхон ишийдчихмээр л байгаа юм даа. 1 номерын микрофоныг өгье.

Н.Тавинбэх: Эрчим хүчний ирээдүй бол сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр гэдэгтэй маргахгүй. Гэхдээ Монгол Улсын хувьд энэ ногоон цэвэр технологид шилжих шилжилтийг бол нямбай хийх ёстой. Мэргэжлийн салбарын яамны хувьд бол бид бодитой

зүйл ярих ёстой. Маш олон компани дотоодын болоод ялангуяа Хятадын гаднын компаниуд Монгол Улсын нутаг дэвсгэрт сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барьж, экспортод эрчим хүч гаргая гэдэг ийм саналыг тавьдаг. Монгол Улсын хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс түлхүү илэрсэн нөөцтэй нь бол нар салхины эх үүсвэр байгаа. Би ойлгомжтой болгохын тулд энгийн ярьж байна. Нар салхины эх үүсвэрийн хувьд бас дутагдал бий. Эх үүсвэрээсээ шалтгаалаад тогтвортой үйлдвэрлэл явуулж чаддаггүй.

Тэгэхээр энэ шалтгаанаас болоод маш олон улсын Монгол Улс ч биш, маш олон улсын эрчим хүчний хангамжид хүндрэл гарч байгаа. Манай улсад ч гэсэн хүндрэлтэй байгаа учраас бид өнгөрсөн хугацаанд зарим үед нар салхины хувьсах эх үүсвэрүүд дээр бол хөрөнгө оруулахад бол хязгаарлалт тавьж ирсэн. Маргаантай бас гомдол саналтай байгаа.

Экспортын төслүүдийн хувьд бол ЭХЯ бас нямбай хандахыг хүсэж байгаа. Саяын нэр дурдаж Энхцэцэг гишүүний асуусан 2 төсөл дээр болбол бид болбол бас шүүмжлэлтэй хандсан. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодорхой нэр зааж байриил зааж оруулж ирсэн учраас бидэнд бол ний нуугүй хэлье мэдээлэл бага байна. Тийм. Энэ болбол хоёулаа нэг газар ингэж салгаж тавихыг нь болбол ойлгомжгүй байгаа. 2 дугаарт нь ийм их хэмжээний хувьсах эх үүсвэрийг үйлдвэрлэсэн эрчим хүчийг Монгол Улсын системд шингээх боломж байхгүй.

Р.Сэддорж: Баярлалаа. Дараагийн гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Энэ юуны талаар асууя. Бүсчилсэн хөгжлийн талаар асууя. Улаанбаатар хотыг 20 минутын хот гээд концепц оруулчихсан яваад байдаг. Энэ ажил маань

бодитойгоор хэзээ эхлэх вэ? Эрдэнэбүрэн сайдаас энэ дээр бас хот дээр хотын даргатай та хэр уялдаж ажиллаж байна вэ? Ялангуяа энэ гэр хорооллыг орон сууцжуулах асуудал, тэр дотроо Улаанбаатар хотод бол 3 том голомт байна. Баруун талд, зүүн талд, хойд чиглэлд Сэлбэ дагасан. Энэ Сэлбэ дагасан гэр хорооллыг орон сууцжуулах ажлын томоохон эхлэл тавигдчихсан. 2250 айлыг төрийн санхүүжилтээр чөлөөлөх ажил нэлээн эрчимтэй явж байна. Энэ ажлыг нэлээн хүчтэй явуулаад үр дүнд нь орон сууцжих ажлыг хийх шаардлагатай байна. Энэ ажил хэр урагштай явж байна вэ? Энэний цаад энэ 20 минутын хотын бодлого концесс хэр урагштай явж байна гэдэг тал дээр хариулт хүсэж байна.

Эдийн засгийн яамнаас дараагийн асуулт байна. Бид энэ сонгууль дээр бүсүүд болж сонгуульд ороцлоо. Энэ их зөв алхам. Улс орны ирээдүйд хэрэгтэй юм байгаа. Тэгэхээр энэ бүсчилсэн хөгжлийг дагуулаад энэ сумуудыг нэгтгэх асуудлыг ярьж байна уу? Баахан хоорондоо 20км, 30км-ийн зайтай сумууд байна. Дотор нь хүн ордоггүй шахуу том соёлын ордууд байна. 35км-ийн зайтай 2 сумд 600 хүүхдийн суудалтай сургуулиуд байна. Энэ орон нутгийн хөгжлийг та хэд хэрхэн төсөөлж байна вэ? 20 дугаар зууны дэд бүтэц, 20 дугаар зууны машин механизм, 20 дугаар зууны хөгжлийн концептой уялдчихсан хөдөө орон нутгийг 21 дүгээр зууны эдийн засгийн хөгжилтэй нийлүүлэхгүй бол болохоо байлаа. Яг бодит амьдрал дээрээ сумаа манаж үлдэж байгаа хөөрхий хэд минь гэж бодож ярьдаг байдал руу оччихоод байдаг.

Гэхдээ бодит амьдрал дээрээ энэ сумуудыг нэгтгэхгүй бол эдийн засгийн хувьд ч, томоохон төсөл хөтөлбөрийн хувьд ч урагшаа явахгүй байдалтай байна. Тэгэхээр яг Монгол Улсад 330 сум суурин хэрэгтэй байна уу? 21 аймаг бодитойгоор хөгжлийн загварчлал болж чадаж байна уу? Тэгэхлээр энэ 21

аймгийг хэрхэн бүсийн хөгжилтэй уялдуулж цөөлөх вэ? 330 сум сууринг хэрхэн цөөлж, эдийн засгийн одоогийн орчин үеийн интеграцид оруулж нэгтгэх вэ? Энэ дээр Эдийн засгийн яам судалгаа хийж байна уу? Ингэхгүй бол бас нөхцөл байдал 20 дугаар зууныхаа хөгжилтэй уялдаад яваад байна шүү гэдгийг хэлээд асууя. Тэгээд тодруулна.

Р.Сэддорж: Эрдэнэбүрэн сайд.

Р.Эрдэнэбүрэн: Энэ өдрийн мэнд хүргэе. 20 минутын сайд болбол өөрөө нэг их учиргүй бодлого шийдвэр гаргаад л, тендер зарлаад давхиад байдаг бас сайд биш юм байна лээ. Илүү салбар хоорондын уялдааг хангах, ялангуяа манай хороо болбол 7 сайд, хотын дарга байдаг. Тэгээд энэ хүмүүсийнхээ энэ яамнуудынхаа бас хоорондынх нь уялдааг хангаж ажиллах тийм үүрэг функцтэй ийм сайд.

Мэдээж энэний өмнө, энэ ЗГ-аас өмнөх сайдын үед бас их ажил хийгдсэн байна. Дэлгэрсайхан сайдын үед 20 минуттай холбоотой. Гол үндсэн шийдэлд хүрч байгаа зүйл нь хүрсэн зүйл нь юу вэ гэхээр энэ хотын түгжрэлээс гарах, ер нь энэ утаанаас салах, ер нь хоттой холбоотой шийдэлтэй гол хамгийн чухал асуудал бол Богд уулын урд тал руу гарч энэ Улаанбаатар хотыг задлах явдал юм байна гэдэг ийм шийдэлд хүрсэн байсан. Тэгээд энэ шийдлийг бол үргэлжлүүлж хэрэгжүүлэх ийм зорилготой, бодлоготой ажиллаж байгаа.

Хотын даргатай маш ойрхон нягт ажиллаж байгаа. Сэлбэ төв бол өөрөө яг энэ 20 минутын концепцын дагуу хийгдэж байгаа бараг Улаанбаатарт анхны төсөл гэж ингэж үзэж байгаа. Тэгээд тэр саяын энэ тодотголоор ч гэсэн ялангуяа энэ Сэлбэ төвтэй холбоотой дэмжиж байгаа газар чөлөөлөлттэй холбоотой юун дээр нэлээн хэмжээний санхүүжилт юмнууд нь тавигдаад ингээд явж байгаа.

Мэдээж энэ хотын асуудал бол зөвхөн нэг сайдын ч асуудал биш. Ялангуяа Их Хурлын гишүүд болбол тал талаас нь дэмжиж сайн ярьж өгөх хэрэгтэй байгаа юм. Одоо бид нар Нямбаатар даргатай дараагийн юу болбол хийх гэж байгаа ажил бол энэ гудамжаар энэ янз бүрийн мотор суррон унасан, ер нь явган явж чадахаа больсон ийм байдалтай болсон байгаа Улаанбаатар. Тэгээд энийг яаж цэгцлэх вэ гээд дахиад нэг хөтөлбөр зарлах гэж байна. Ингээд цаашаа үргэлжлүүлээд явна.

Тодотголоор болбол та бүхэн харж байгаа байх. Хамгийн их анхаарч байгаа юм болбол энэ 20 минутын хот болоход ялангуяа тэр Улаанбаатарыг задлахад энэ ЗГ-ын бодлого болбол гол анхаарлаа хандуулж байгаа. Тэгээд ийм учраас цаг алдахгүй ялангуяа тэр бид нарын ярьж байгаа тэр туннел, гүүр энэ тэр болбол өөрсдөө хийж чадахгүй зүйлүүд бас их байгаа. Тэгээд энэ дээр зөвлөх үйлчилгээ авах эд нар гээд ажлуудаа эхлүүлэхийн тулд тодотгол дээр бас нэлээн хэмжээний багагүй хөрөнгө мөнгө тавиад ингээд ажлаа эхлүүлээд явж байна. Тийм учраас энэ 20 минутын концепц энэ үйл ажиллагаа бол эхэлсэн, эхэлж байна гэж хэлж болно.

Р.Сэддорж: Эдийн засгийн хөгжлийн яам бүсчилсэн хөгжлийн талаар 6 номер.

Д.Эрдэнэбаяр: Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр. Асуултад хариулъя. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд батлагдсанаас хойш энэ жил 23 жилийн дараа шинэчлэн баталсан. Энэ хугацаанд 100 орчим эрдэмтэд орон зай, эдийн засгийн талаар судалгаа хийж, Монгол Улсын байгалийн баялаг болон байгалийн дагалдах түүхий эд, хүн амын өнөөдрийг хүртэл явж ирсэн нутагшил суурьшлын ерөнхий схем зэрэг нийт 330

сумыг 119 шалгуур үзүүлэлтээр тооцож, орон зай, эдийн засгийн загвар болон эдийн засгийн загваруудаар тооцоолол хийсний үндсэн дээр 21 аймгийн төв дээр нэмэх нь 69 иргэд, ААН ажиллаж амьдрах хамгийн таатай тээвэр логистикийн сүлжээг үүсгэх хамгийн ашигтай байршиллууд, 2 хөршийнхөө гол аж үйлдвэрийн бүс, тусгай бүс, хотуудтай холбогдох оновчлолыг болбол хийсэн.

Ингээд 21 аймгийн төв дээр нэмэх нь 69 буюу нийт 90 байршилыг 100-аас 150км дотор байгаа иргэд, ААН-ийн бараа, түүхий эдийг татаж, анхан шатын боловсруулалт хийх, эцсийн боловсруулалт хийх, улмаар гадаад зах зээл дээр гарах ийм байршиллуудыг тооцож гаргасан. Тэгэхээр сумуудыг бол Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр юу гэж тусгасан гэхээр ирэх 30 жилийн хугацаанд эдийн засгийнх нь төвлөрлийг харж байж шийдвэрлэе уян хатан байдлаар. Захиргаадалтын аргаар буюу дунд хугацаанд шууд сумуудыг нэгтгэх асуудлыг авч үзэхгүйгээр цаашидаа энэ тээвэр логистикийн сүлжээ, орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, хүн амын нутагшил, суурьшлын оновчтой бүтэц маань ирээдүйд Монгол Улсын хамгийн оновчтой эдийн засгийн орон зайг бий болгосны үндсэн дээр эдийн засгийнх нь хүч хөшүүргээр шийдэх нь зүйтэй юм байна гэдгээр 90 таталцлын бүсийг Улсын Их Хурлаар баталсан байгаа. Тэгэхээр цаашид болбол энэ зүйлийг нэлээн сайтар ажигласны үндсэн дээр шийдэх нь зүйтэй юм гэж ингэж үзсэн байгаа.

Р.Сэддорж: Баярлалаа. Тодруулга байна уу? Батсүмбэрэл гишүүний микрофоныг өгье.

Н.Батсүмбэрэл: Энэ Эдийн засгийн яамнаас тодруулаадахъя. Ер нь жоохон зоригтой ормоор байгаа юм энэ сумуудыг нэгтгэх асуудал. Тэгээд хараад байхад манай төрсөн сум, манай аймгийн

сум гэдэг байдлаар ханддаг юм шиг байгаа юм. Бодит амьдрал дээр 100 жилийн ойгоо хийж байгаа бид нар олон сумыг харлаа шүү дээ. Хөгжлийн ямар дүр зурагтай байна вэ, 21 дүгээр зуун гарчхаад байдаг ямар бид нар хэрэгцээ шаардлага байна вэ. Тэгэхээрээ сумуудыг эдийн засгийн тооцооллоор нь нэгтгэх зураглалыг Эдийн засгийн яам гаргамаар байгаа юм.

Монгол Улсад 330 сум суурин хэрэгтэй байна уу, 150 сум суурин хэрэгтэй байна уу гэдгийг тооцооллын хувьд гаргахгүй бол аймгийн төвийнхөө хажууд 20км-ийн зайтай сум байгаад байдаг. Энэ хажууханд байгаа Сэргэлэн сумыг хар л даа. Сургуульд нь анги дүүргэлт байхгүй, тэгсэн мөртөө сургууль байгаад байдаг. Олон хүнтэй Зүүнхараа гээд сум байж байдаг, цөөхөн мянга хүрэхгүй хүнтэй говийн сум байж байдаг адилхан Үндсэн хуулийн зохицуулалттай, адилхан засаг захиргааны нэгжийн зохион байгуулалттай ийм байдлыг бол бид нар тэвчээд яваад ирчихсэн. Энэ байдлыг бас нэг өнөөдрийн эдийн засгийн хөгжил цаашидын зураглалтайгаа холбогдуулж хийх ёстой шүү. Энийг Эдийн засгийн яам хийх ёстой гэж бодож байна, харж байна. Энийг та бүхнийг хийгээд, саналыг танилцуулаарай гэж протоколд оруулж байна. Тэгээд эдийн, Байнгын хорооны дарга энийг тусгайлж Сэддорж даргаа энийг нэг ярьж тэгэх үү энэ орон нутгийн хөгжлийн асуудлыг. Хөгжлийн яам нэг юу яах хэрэгтэй байна, оруулж ирэх хэрэгтэй байна.

Тэгээд Эрдэнэбүрэн сайд бол нэлээн бас ажил руугаа орох нь зөв байх. Хот бол Дундговьос өөр шүү бодит амьдрал дээр. Тэгээд хэдүүлээ энэ хотын хөгжлийн асуудал ярих хэрэгтэй байна, үер ус болж байна, хотын энэ түгжрэлийн асуудал байна, хотын сайдын хүлээлт өндөр байгаа шүү гэдгийг бас танд.../минут дуусав/

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн асуулт асуусангүй үг хэллээ. Протоколд бүх юм тэмдэглэж авсан. Орон нутгийн хөгжлийн асуудлаар олон жил яригдсан тулгамдсан асуудлыг хөндөж байгаа нь маш зөв зүйтэй. Энэ бол олон удаа яригдсан, олон жил яригдсан асуудал. Энэ дээр манай Байнгын хороо санал санаачилгатай ажиллаж, энэ асуудлыг 126 гишүүн анхаарлаа хандуулж явах эрэмбээрээ нэлээн дээгүүр асуудлын нэг үү гэдэг бол нэг. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Саналыг бичгээр өгөх ёстой. Бичгээр өгсөн үү? Энхцэцэг гишүүний микрофоныг өгье.

М.Энхцэцэг: Би зарчмын зөрүүтэй 2 санал гаргая гэж байгаа. 1 дүгээрт нь болохоор энэ санал яг мөрийн хөтөлбөрийн төсөл дээр ЭХЯ-наас ирчихсэн байсан. Тэгээд яг эцсийн хувилбар дээр хасагдчихсан байсан. Тэгэхээр энэ бол маш чухал. Эрчим хүчний салбарт реформ хийхийн тулд бид нар салбарын эрх зүйн орчин, Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох дүрэм журам, эрх зүйн актуудыг шинэчлэх, зохих өөрчлөлтүүдийг оруулах гэсэн ийм заалтыг бол оруулах зайлигүй шаардлагатай. Энэ салбарт бид нар маш олон зорилтуудыг тавьчихсан байгаа.

Хоёрдугаарх заалт болохоор мөрийн хөтөлбөр дээр 3.3.37 дээр Сонгино Дарханы 220 киловольтын шугамыг барьж, шугамыг барих төслийн эхлэлийг эхлэх эхлэлийг хангана гэгчихсэн байсан. Тэгэхээр энийг миний санал бол 220 Сонгино Дарханы 220 киловольтын шугамыг барьж эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг дээшлүүлнэ гэсэн байдлаар оруулах нь зүйтэй. Ямар үндэслэлээр вэ гээд тэгэхээр 1 дүгээрт

энэ шугамын бэлтгэл ажил бол аль хэдийн хангагдсан буюу зураг төслийн ажил бол аль хэдийн хийгдчихсэн. 2 дугаарт нь болохоор энэ Улаанбаатар Дархан хоёрыг холбож байгаа гол шугам бол 208 гээд нэг хэлхээтэй, насжилт өндөртэй ийм найдваргүй шугам байдаг. Тэр утгаараа энэ шугам бол нэлээн олон тэг зогсолтын гол үндсэн шалтгаан болж байсан. Тийм учраас.../үг тасрав/

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүн саналаа бичгээр өгчих. Эндээс шууд санал хураачихъя.

М.Энхцэцэг: Тэгье.

Р.Сэддорж: Аваад, наашаа өгчих. Миний бас хувьд бас нэг санал оруулсан. Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.1, 3.3.1 дэх заалтад шинээр 2 дэд заалтыг нэмнэ, нэмье. Нэг тайлбар хэлэхэд бол Эрдэнэтийн үйлдвэрийн уурхайгаа бид бол бүрэн гүйцэт судалж амжаагүй байгаа. Ийм учраас 1 дүгээрт Эрдэнэтийн овооны Оюут ордын нөөцийг тооцоолон ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад бүрэн бэлтгэнэ.

2 нь 2.Эрдэнэтийн стратегийн ордын талбайн хүрээнд эрэл хайгуулын ажлыг дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаан ашиглан дараагийн шинэ Эрдэнэтийн хэмжээний ордыг нээж, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлнэ гэсэн энэ 2 заалтыг оруулж байна. Зарчмын зөрүүтэй санал дээр.

Энэ сүүлийн 2 заалтаар санал хураалт явуулъя. Дараа нь Энхцэцэг гишүүний санал дээр. Санал хураалт. Энэ зарим нь ажиллахгүй байна, минийх ч гэсэн. Энэ хурууны хээнүүд юу болчхов, дахиж хураах уу? Ийм горимын саналтай байна. Эрдэнэтийн уурхайгаа бүрэн судалгаа хийе гэхэд бол зөвшөөрөхгүй гишүүн байхгүй байх саалийн үнээгээ. Техник ажиллаагүй учраас саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураая. Горимын санал 70 хувиар

дэмжигдсэн тул санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Горимын санал Цэнгүүн гишүүн. Ажиллаагүй юу? Цэнгүүн гишүүний микрофоныг өгье.

С.Цэнгүүн: Сая ажилласангүй миний төхөөрөмж.

Р.Сэддорж: Горимын санал гаргах уу? Санал хураалтыг. Батнайрамдал гишүүний микрофоныг өгье. Цэнгүүн гишүүний саяын санал чинь бол ажиллаагүй гэсэн горимын санал гэсэн үг шүү дээ тийм ээ.

О.Батнайрамдал: Дарга минийх горимын гэхээсээ илүүтэйгээр сая 2 зарчмын зөрүүтэй саналаа жоохон тайлбарлаж өгөөч гэж, сонсож амжаагүй шууд санал хураалт явахаар яг юун дээр санал өгч байгаагаа ойлгосонгүй явчихлаа.

Р.Сэддорж: Эхлээд горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураа. Санал 55 хувиар дэмжигдэж санал хураалт хүчингүй боллоо.

Би гаргасан саналаа тайлбарлая. Батнайрамдал гишүүн бол Уурхайн дэд сайд байсан хүн. Энэ саналыг бас сонсох нь зөв зүйтэй байх. Эрдэнэтийн овооны 1 дүгээрт Эрдэнэтийн овооны Оюут ордын нөөцийг тооцоолон ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад бүрэн бэлтгэнэ. 2-т нь Эрдэнэтийн стратегийн ордын талбайн хүрээнд эрэл хайгуулын ажлыг дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаан ашиглан дараагийн шинэ Эрдэнэтийн хэмжээний ордыг нээж, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлнэ гэсэн ийм 2 заалт зарчмын зөрүүтэй санал оруулсан.

Өөрөөр хэлбэл Эрдэнэтийн уурхай маань энэ ордоо нийтэд нь судалгаа хийж, хайгуул хийж дуусаагүй байгаа гэсэн үг. Энийг нь төр дэмжиж, нэг мөр дуусгахгүй бол болохгүй гэсэн ийм л саналаар олон уурхайчдын санал нэгдсэн

л ийм санал байгаа. Болно. Асуулт асууж болно. Бадамсүрэн гишүүн. Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

М.Бадамсүрэн: Гол нь яг хамрах хүрээ нь аль юм бэ? Одоо байгаа суурьшлын бүсдээ нөлөөлөх юм уу эсвэл нөлөөлөхгүй юм уу? Яг аль орчинд нэмж эрэл хайгуул хийх гэж байгаа юм бэ гэдэг энэ жоохон мэдээлэл нь бүрхэг болохоор гишүүд асуугаад байх шиг байна л даа.

Р.Сэддорж: Ер нь бол энэ хайгуулыг бол хангалттай хэмжээнд л хийх хэрэгтэй. Тэгээд энэ бол бүх тэр суурьшлын бүс бүх юмаа тооцсон ийм хайгуул хийнэ. Санал хураалт явуулъя. Бүгдээрээ идэвхтэй оролцоорой. Энэ зарим нь миний ч гэсэн заримдаа уншигдахгүй байна. Бямбасүрэн гишүүний төхөөрөмжийг шалгаж өгнө үү. 2 гарынхаа хурууг ээлжилж уншуулбал, хугацаандаа амжаад ээлжилж уншуулбал зарим нь орчхоод байгаа юм. Эрчим хүч, Уул уурхайн яамнаас хүн байна, Уул уурхайн яамнаас хүн байна уу? Энэ Эрдэнэтийн энэ саяын хайгуулыг дуусгах ажил бол Уул уурхайн яаманд бол олон жил бас яригдсан л асуудал. Асуулт, хариулт байхгүй юм байна. Санал хураалтаа л явуулах юм байна. Болсон уу? Санал хураалт. Энэ болохгүй байна. Үгүй ээ энэ ажиллахгүй байна. 60 хувь дэмжигдсэн байна.

Дараагийн санал Энхцэцэг гишүүний санал. Эрчим хүчний салбарын санал байна. Шууд унших уу, энэ заалтыг нь унших уу? 3.3.3. Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал гэсэн заалтад дэд заалт нэмэх. 3.3.3.2. Эрчим хүчний салбарт реформ хийх, салбарын эрх зүйн орчин, Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох дүрэм журам, эрх зүйн актуудыг шинэчлэн зохих өөрчлөлтийг оруулна. Дараагийн заалт нь, өөр юм уу? Энэ заалт дээр хураах юм байна. Санал гаргасан Энхцэцэг гишүүн. Санал хураалт. Санал 70 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал. 3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал заалтад өөрчлөлт оруулах. 3.3.3.37.Сонгино-Дарханы 220квт-ын шугамыг барьж, эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг дээшлүүлнэ гэсэн заалт байна. Санал гаргасан Энхцэцэг гишүүн. Энхцэцэг гишүүн саналаа тайлбарлая. Энхцэцэг гишүүний микрофоныг өгье.

М.Энхцэцэг: Мөрийн хөтөлбөр дээр энэ болохоор энэ төслийн бэлтгэл ажлыг хангана гэсэн байдлаар орж ирсэн байсан юм. Тэгтэл 1 дүгээрт энэ төслийн бэлтгэл ажил аль хэдийн хангагдсан, зураг төсөл нь бол хийгдчихсэн ийм төсөл. 2 дугаарт нь болохоор одоо Улаанбаатар Дархан хоёрыг 208 гээд нэг хэлхээтэй, маш өндөр насжилттай ийм шугам холбодог. Тэр утгаараа энэ шугам маань нэлээн хэдэн тэг зогсолтын үндсэн шалтгаан болж байсан 200. Тийм учраас Сонгино-Дархны энэ 2 хэлхээтэй 220-ийн шугамыг барьж, Улаанбаатар Дархан хоёрын холболтыг сайжруулж, системийн найдвартай ажиллагааг сайжруулах нь шаардлагатай. Тэгэхээр бэлтгэл ажил нь хангагдчихсан учраас барина гэдгээр оруулах өөрчлөлт тийм зарчмын санал оруулж байгаа юм. Тийм барилга угсралтын ажлыг хийлгэх л гэсэн утгатай оруулж байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Санал тайлбарлаж дууслаа. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Батсүмбэрэл гишүүнийг нэмээрэй. Түрүүний санал хураалтад миний юу ажиллаагүй учраас тэрийг бас нэмээрэй. Ингээд санал 60 хувиар дэмжигдлээ.

Энхтүвшин гишүүний санал. Төслийн 3.2.2 нэмэх. 3.2.2.14.экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд нэг цонхны бодлогоор дэмжинэ гэсэн ийм заалт байна. Саналаа

тайлбарлах уу? Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтүвшин: Манай экспортын гол зах зээл маань Хятад байгаа. Тэгээд Хятад маань өөрөө бас төвлөрсөн, засаглалын хувьд бол онцлогтой учраас нэлээн олон асуудлууд нэгдсэн байдлаар очиж ярихгүй болбол орон нутгийн зохион байгуулалтууд нь Төв засаг тэгээд энэ бүтцүүд нь өөр байдаг. Тэгэхээр бид нарын хувьд бол экспортод нэлээн гарах сонирхол, хэмжээгээ нэмэгдүүлэх сонирхлууд байгаа. Уул уурхайн бүтээгдэхүүнээс гадна сая жишээлбэл эрчим хүчний асуудал ярьж байна. Энэ эрчим хүчний асуудал дээр ч гэсэн нэг цонхны бодлогоор очиж, асуудлуудаа гадаад бодлогын хувьд бол уялдаж ярих учраас хоорондоо тэнчээ жишээлбэл үл ойлголцсон байдлаар бас очиж үнэ цэнээ унагах ч юм уу, зах зээлээ тэр мэдлэг мэдээллээ буруу, зөв ойлгох ийм асуудлууд гарч ирж магадгүй учраас, дээр нь одоо явж байгаа бас махны, ноолуурын, энэ самрын экспортууд дээр ч гэсэн хоорондоо Монгол компаниуд өрсөлддөг, Хятадын зах зээл дээрээ биш Монголын нутаг дэвсгэр дээр ингээд өрсөлддөг.

Тэгэхээр хамтарч илүү үнэ цэн бий болгох байтал ингээд энэ боломжуудаа алдаад байдаг учраас илүү энэ supply chain-аа бүтэн том зургаар эцсийн хэрэглэгч хүртэлх зургаараа харж, тэр хилийн цаана болж байгаа энэ процессууд дээр бас нэгдэж ажиллах ийм зайлигүй шаардлага байгаа. Тэгэхээр энийг болбол зарим төр засгийн зүгээс бодлогоор оролцож, дэмжих тийм зайлигүй шаардлагууд байгаа. Ялангуяа тэр зах зээлийн дэд бүтцүүдэд нэвтрэхэд бас саад бэрхшээлүүд байдаг. Тэгэхээр энэ чиглэлээр Засгаас нэлээн дэмжлэгүүд байх шаардлагатай байгаа. Тэгээд энэ утгаар нь энэ экспортын бодлогыг нэг цонхны бодлогоор дэмжих ийм заалтыг оруулах саналтай байна. Та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье.

Р.Сэддорж: Асуулт, хариулт байхгүй л юм байна. Санал байхгүй л юм байна. Энхтүвшин гишүүний саналаар санал хураалт явуулъя. Санал 65 хувиар дэмжигдлээ. Энд явж байна уу?

Тогтоолын төслийн 2 дугаар заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Асуулт, хариулт байхгүй байгаа тул шууд явна биз дээ. Санал гаргах гишүүн байна уу? Асуулт уу? Сая алх тогтсоны дараа юу? Алдаржавхлан гишүүн асуулт асууя. Энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр. Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Тогтоолыг нь нэг бүтэн сонсоодохъё Сэддорж дарга.

Р.Сэддорж: Гишүүдэд тараачихсан байгаа даа, өргөн мэдүүлээд. Тийм тараачихсан байгаа учраас та асуултаа асуухыг хүсэж байна. Шууд, Бадамсүрэн гишүүний санал бол ТББХ руу шууд оччихсон байгаа юм байна шүү. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төслийн 2 дугаар заалттай холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Гаргасан санал байхгүй учраас дараагийн заалт руу оръё.

Тогтоолын төслийн 3 дугаар заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. 3 дугаар заалт. Асуулт, хариулт байхгүй байна. Гишүүд асуулт, хариулт авч дууссанд тооцъё.

Тогтоолын төслийн 3 дугаар заалттай холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? 12-нд өргөн мэдүүлчихсэн юм байна. Бүх гишүүдэд тараачихсан юм байна. Ингээд зарчмын зөрүүтэй санал байхгүй байна гэж ойлголоо.

Тогтоолын төслийн 4 дүгээр заалттай холбогдуулан асуулт асуух

гишүүд нэрсээ өгнө үү. Бадамсүрэн гишүүн юм уу, үгүй юу? Дагаж мөрдөх хугацааны тухай заалт байсан. Бадамсүрэн гишүүн саналаа буцаагаад авах уу? Тэр нэг юу дарагдохсон байгаа юм уу? Асуулт асуух гишүүн алга байна. Санал гаргах гишүүн алга байна.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа. Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг ТББХ-ны хуралдаанд хэн унших вэ? 2 хүн гараа өргөх юм, эхнийх нь үү, эмэгтэй нь унших уу? Энхцэцэг гишүүнийг ТББХ-ны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг уншиж танилцуулна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

11.52 цаг

Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Дараагийн асуудалдаа оръё. Төсвийн ажлын хэсгээ оруулъя. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Д.Баярсайхан СЗХ-ны дарга, Б.Батдаваа ҮСХ-ны дарга, Т.Жамбаажамц СЗХ-ны Ажлын албаны дарга, Н.Тавинбэх ЭХЯ-ны ТНБД, С.Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч,

Н.Мандуул НЗД-ын Санхүү, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Б.Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Ц.Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Н.Уранцэцэг Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч хаана суугаад байна, Уранцэцэг хаана байгаа юм бэ? Б.Дашням Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Э.Цолмон Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Б.Энхжин Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Үндэсний аудитын газраас Н.Наранчимэг Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Сангийн сайд ирэхгүй юу? Төслийг Сангийн сайд танилцуулна. Яасан, Сангийн яамныхан Сангийн сайдыг дуудах уу? Юу хажууд ХЗБХ-н дээр яг танилцуулгаа уншиж байгаа юм байна, одоо орж ирнэ гэсэн байна. Орлож унших хүн бол байхгүй биз дээ. Уг нь Сангийн сайд л танилцуулдаг юм байна. Завсарлага гэж байхгүй юм байна. Үгүй ээ ингээд л дууслаа шүү дээ одоо удахгүй, тийм. Баталсан дарааллаар л хэлэлцэнэ. Баталсан дарааллаас гажиж болохгүй л юм байна. Тийм. Сангийн сайд ирж байна уу, дөхөж байна уу? Шууд асуулт, хариултдаа орохгүй гараад ирэх үү? Сангийн сайд дөнгөж сая уншиж дууссан гэж байна. Сангийн яамныхан сайдыг яаралтай оруулж ирье.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны

төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцүүлэгт төслийн талаарх хууль санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Сайдын микрофоныг нээнэ үү. 3 номер.

Б.Жавхлан: Баярлалаа. Өнөөдөр 9 Байнгын хороогоор дамжиж орох ёстой. Яг одоо бараг 3 Байнгын хороо давхацчихаад байгааг гишүүд ойлгоорой. Тийм.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль, тогтоомжийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Хурдтай хөгжлийн төлөөх зориг, хамтарсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэсэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа. Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлуудыг шийдэх эдийн засгийн өсөлтийг 5-аас 6 ба түүнээс дээш хувьд инфляцыг нэг оронтой тоонд, зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх, хурдтай, зоригтой эрс шийдвэрүүдийг гаргаж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах

багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийслэлийн Их, Бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, өөдөө тэмүүлэх Монгол буюу *go Mongolia*, ган татлагат гүүр, Хөшигийн хөндийн туннел, Хөшигийн хөндийд төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох шинэ сэргэлтийн 5 тойрог, авто замын төсөл, Шинэ Хархорин төсөл, Шинэ Зуунмод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг ЗГ-ын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах, ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

2 дугаарт гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж, санхүүжиж буй бүтцийн хөгжил, шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн тодотголд тусгалаа.

3 дугаарт 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, либералчлах, хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх шилжилтийн үеийн зардлыг тусгаж байна.

4 дүгээрт Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар ЗГ-ын бүтцийн тухай, ЗГ-ын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан. Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн, шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон, мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн

тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийлээ.

5 дугаарт эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон. Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуульд хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн Аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Ерөнхий аудитор байна уу? Загджав гуайн 4 номерын микрофоныг нээнэ үү.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэн дэвшүүлье. Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь төсвийн

ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн 3 намаас хурдтай хөгжлийн төлөөх зориг гэрээ байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.4-д заасан төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын ЗГХЭГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна. ЗГ-аас өргөн мэдүүлсэн 24 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт нийтдээ 450,6 тэрбум төгрөгийн өөрчлөлт орсон байна. Анхаарал тавьсанд баярлалаа. Танилцуулж дууслаа.

Р.Сэддорж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүн байна уу? Соронзонболд гишүүнээр нэрсийг авлаа. Батнайрамдал гишүүн асуулт асууя. Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт ер нь амин сүнс нь бол цаашидаа явах томоохон мега төслүүд гэж харж байгаа. Ер нь эдийн засгийг нэг хүнд ноогдох ДНБ-ыг бас 6 мянгаас цаашаагаа 2 дахин тэлэх ч гэсэн ер нь гол үндэс нь бол томоохон мега төслүүд байна. Тэгэхээр мега төсөл гэхээр санхүүжилт яригдана л даа. Санхүүжилтийн схем, маш их мөнгө босгоно гэсэн үг. Хэдэн тэрбум доллароор бас яригдана гэсэн үг. Тэгэхээр энэ том мега төслүүдийг хэрэгжүүлэх дээр бас яах вэ нэг талаасаа бас төсөв дээр хэтэрхий том дарамт ирэх вий гэж харж байгаа юм л даа. Тэгэхээр ер нь мега төслүүд бол бүгдээрээ л Монгол, гадаад гэлтгүй дандаа project finance буюу санхүүгийн төслийн санхүүжилтээр явагдана гэсэн үг.

Тэгэхээр ЗГ энэ 14 мега төслийн бараг 14 дээр нь ч юм уу ямар нэгэн байдлаар 20-оос 30 хувиар ч юм уу өөрийн equity finance буюу өөрийн хөрөнгийн санхүүжилт бас гаргана. Тэгэхээр төрийн зүгээс аваад үзэхээр яг санхүүжилт ялангуяа энэ мөнгө босгох дээр санхүүгийн схемээ зөв зурах дээр бас ганцхан төсвөөр бас харж болохгүй л дээ. Тэгэхээр энэ төсөв дээр хэт их дарамт ирчих вий гэх үүднээс нь асууж байгаа юм л даа. Яагаад гэхээр энэ том төслүүдийг бүгдийг нь төсвөөр санхүүжүүлнэ гэж байхгүй, ойлгож бас болохгүй.

Төсвөөс гадна төрд бас нэг байгаа зүйл юу вэ гэхээрээ мэдээж татвараа дагаад төсөв, нөгөө талаасаа төрийн эзэмшилд том хувьцаат компаниуд байгаа. Төрийн өмчийн asset-ууд гэсэн үг. Тэгэхээр энэ жишээлбэл Эрдэнэс Монгол байна. Эрдэнэс Монгол бол төрийн өмч, төрийн хамгийн том уул уурхайн яг орлого бүрдүүлэгч asset-ууд байна. Тэгэхээр тэдний ноогдол ашигаар бас цаашидаа энэ томоохон төслүүдийг, ялангуяа equity investment-н өөрийн хөрөнгийн санхүүжилтийг бас энэ

төсвийн, энд хэр уялдуулж байгаа юм болоо гэж бодоод байна л даа.

Яах вэ асуулт ер нь бол төсөв дээр хэт их дарамт ирчих вий. Яагаад гэхээр энэ мега төслүүдийг бид нар төсвөөр санхүүжүүлдэг гэдэг хэрвээ ойлголтоор явах юм бол аягүй буруу гэж бодоод байна л даа. Тэгээд ер нь бол томоохон мега төслүүдийг бол цаашид Эрдэнэс Монгол ноогдол ашигаараа заавал санхүүжүүлэх бас нэг том эх үүсвэр бол гэж харах ёстой. Эрдэнэс Монголыг Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар ч гэсэн хуримтлалын санд 34 хувийг өгөөд, үлдсэн ноогдол ашгийг бол Эрдэнэс Монгол тухайн томоохон төслүүд рүү санхүүжүүлэх боломжтой гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар гаргасан. Тэгэхээр энийг бас энэтэйгээ хэр уялдуулж та харж байгаа юм бол? Ер нь энэ оны төсвийн тодотгол гэлтгүй 25, 26 он дээр томоохон мега төслүүдийн санхүүжилтүүд бас яригдана л даа ер нь.

Р.Сэддорж: Хариулт Сангийн сайд Болдын Жавхлан, 3 номерын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Тантай ер нь 100 хувь санал нийлж байна. Яг бидний энэ төлөвлөж байгаа, бодож байгаа дагуу л ярьж байна яг таарч байна. Бид цаг хугацааны хувьд ер нь бид нэг өдөр ч гэсэн чухал байна гэдгийг бид яриад байгаа.

Тийм учраас энэ 24 оны энэ гуравхан сар ч гэсэн тэгээд бид нарт маш чухал байгаа учраас ядаж бэлтгэл ажил хангах түвшинд эхэлье гэж байгаа юм. Тэрнээс биш яг бүтээн байгуулалт эхлэхэд бол яг таны наад ярьж байгаа асуудал үүсэх юм байгаа юм. Тэгэхээр ямар санхүүжилт, ямар схемээр явах вэ гэдэг бол дараагийн асуудал. Таны хэлсэн дээр би бүүр яг тодотгоод санаа нийлж байгаа зүйл юу байна вэ гэхээр цаашаага болбол төсвийн хөрөнгө

оруулалтаар явахгүй, нэг төгрөг ч явах боломж байхгүй, төсөв ч дийлэхгүй төлбөрийн тэнцэл ч дийлэхгүй.

Энэ жил нэг ингээд 370-аас 480-аад тэрбум төгрөг ингээд бэлтгэл ажилдаа энэ хагас жилдээ төлөвлөж байна. Яах вэ нэг дундын амжихгүй бол дундын дансандаа хадгалж байгаад ч хамаагүй бэлтгэл ажлаа энэ мөнгөөрөө нэг хийчих юм болбол гадаадын шууд хөрөнгө оруулалт байна уу, төр хувийн хэвшлийн түншилэл байна уу, таны саяын ярьж байгаа дотоод asset-уудаа ашиглаад equity finance хийнэ үү, ямар ч хэлбэрээр байж болно тийм ээ, тэр бүх юмаа яаралтай гаргаж ирээд бид нар нэг ярих юмтай болох ёстой байхгүй юу бэлтгэл ажлаа өөрсдөө хангачих юм бол. Өөрсдөө ядаж даалгавраа гаргаж нэг ширээний ард хэлэлцээр хийх хэмжээнд оччих хэрэгтэй байгаа юм.

Тэр ажлуудаа энэ жилээ дуусгаж аваад, тэгээд бүтээн байгуулалтын ажлыг аль болох гадаад хөрөнгө оруулалтаар гадаад эх үүсвэрээр хийх хэрэгтэй. Бид дотоод эх үүсвэрээрээ хийх юм бол төлбөрийн тэнцэл дийлэхгүй. Төлбөрийн тэнцэл дийлэхгүй. Энэ сүүлийн жилүүдэд нэлээн өсөлт нэлээн гарч байгаа учраас одоо ингээд төлбөрийн тэнцэл дээрээс энэ жилээс ингээд ер нь нэлээн сөрөг дарамтууд, импортууд нэмэгдээд эхэлнэ. Тэгэхээр дотоод эх үүсвэрээр ялангуяа төсвөөр хийх юм бол бид дийлэхгүй болж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ удаа бол бид нар тодотголоо өргөн барьж байна ингээд бэлтгэл ажлаараа хангагдаж байна.

Цаашаага ямар схемээр, ямар санхүүжилт явах вэ, гадаад талаараа явах уу, дотоод талаараа явах уу гээд энэ юмнууд болбол 25 оны төсөв дээр бол нэлээн тодорхой яригдана. Гэхдээ тодорхой юм нь бол юу вэ гэхээр дотоод эх үүсвэр буюу төсөв дээрээсээ бол цаашаа үргэлжлүүлэх боломж бол байхгүй. Тэгээд бодлогын хувьд энэ аягүй буруу болоод явж байна. Тийм.

Ноогдол ашиг болон тэр баялгийн сан дээрээс хөрөнгө оруулалтын сан гээд тэр бол ийм бас эх үүсвэрийнх нь нэг боломж байхгүй юу. Ер нь нэг ингээд 10-аад эх үүсвэр байна. Төсөв дээрээсээ бэлтгэл ажлаа хангачихна, төр хувийн хэвшлийн түншилэл, гадаадын шууд хөрөнгө оруулалт, ингээд дотоодын төрийн ААН-үүд томоохон боломжууд юу байна тэндээсээ холимгоор хийж болно тийм ээ. Эсвэл баялгийн сан, хуримтлалын сан эд нараасаа хөрөнгө оруулалтууд хийж болно. Ингээд маш олон ийм. Хөгжлийн банкны асуудлууд байж болж байна гэх мэт олон эх үүсвэрүүд байгаа. Энэ дээрээ бол нэгдсэн.../минут дуусав/

Р.Сэддорж: Тодруулга авах уу? Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

О.Батнайрамдал: Ойлголоо харин тийм. Тэгэхээр ер нь дахиад буцаад мега төсөл хэрэгжих үү, үгүй юү гэдэг нь ер нь бол тэгээд л мөнгө босох үгүй юу гэдгээс л шалтгаална гэсэн үг л дээ. Тэгэхээр мөнгө босгох нь санхүүгийн схемээ зөв зурах нь явж явж хамгийн чухал болоод байгаа юм.

Тэгээд бас зүгээр нэг санал нэмээд хэлэхэд мэдээж ТӨК-уд байна. Бас нэг яг энэ нэлээн зоригтой энэ хамтарсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр орж ирсэнтэй холбогдуулаад бас ЗГ нэг ёсондоо энэ том мега төслүүдийг явуулахын тулд бүх арга чаргаа мөнгө босгох тийм ээ мөнгө хаанаас босгож болох вэ, санхүүжилт хаанаас ч босгож болох вэ арга чаргаа хайна гэсэн үг л дээ. Тэгэхээр 1 бас урьд өмнө нь нэг олигтой хийгдэж байгаагүй гэхдээ бас цаашидаа ер нь зоригтой шинэчлэл хийж болох нэг зүйл нь төрийн өмч дээр бол маш олон asset-ууд буюу компаниуд зүйлүүд байгаа. Тэгэхээр тэд нарыг бас хувьчлах хэлбэрээр томоохон хэмжээний мөнгө босгох бас боломж байдаг. Тэгэхээр энэ дээр бас зоригтой томоохон

хувьчлалуудыг зүгээр нэг ил тод болгох гэхээсээ илүүтэйгээр бас энэ бол нөгөө мөнгө босгох маш том арга хэрэгсэл байдаг л даа. Ер нь олон улсын жишигийг аваад үзсэн ч гэсэн.

Төр өөрөө өөр дээр эзэмшиж байгаа asset-уудаа аваад үзэх юм бол энэ бас хэдэн их наядоор яригдана гэсэн үг. Тэгэхээр нэг их тийм ил тод байдал хангах гэхээсээ илүүтэйгээр буцаад том мега төслүүдийг санхүүжүүлэхийн тулд заримыг нь зайлшгүй зарах ч юм уу, merging... компанийн хоорондын нэгдэл, хувьчлал зайлшгүй хийгдэх шаардлага бас үүснэ гэж харж байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Санал хэллээ гэж ойлголоо тийм үү? Одонгийн Цогтгэрэл гишүүн үг хэлье. Асуулт асууя.

О.Цогтгэрэл: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. ЗГ-аас төсвийн тодотгол, дагалдах хуулиуд орж ирж байна л даа. Энэ дотор бас нэлээн ингээж ярилцах олон зүйлүүд гарч АН-ын бүлэг дээр бас саналууд нэгтгэгдээд явж байна. Хэдийгээр намууд хамтарч хамтарсан ЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө тэнд үндэслэсэн мөрийн хөтөлбөр орж ирж байгаа ч гэсэн энэ дотор байгаа зарчмын зөрүүтэй тэр тусмаа бас бид нарын өмнөх байр сууриуд ер нь бид нарын явж ирсэн зам, барьж байсан бодлого, мөрийн хөтөлбөр олон зүйлтэй нийцэхгүй байгаа зарим зүйлүүдийг бас үнэхээр байр сууриудаа илэрхийлэхээс өөр бас аргагүй.

Жишээ нь би энд өчигдөр АН-ын бүлгээр яригдсан 6 зүйл бүхий тодорхой шаардлагыг төсвийн ажлын хэсэгт хүргүүлэхэд би бэлэн болчихсон байна. Зүгээр энэ тухай бас энэ дээр ингээд мэдээлэл хийчихье. Жишээ нь 1 дүгээрт нь Төсвийн хуулийг дагалдаж орж ирж байгаа Төсвийн тогтвортой байдлын хуулийг өөрчлөх өөрчлөлтүүд байгаа. Төсвийн тусгай шаардлагуудыг өөрчилчихсөн маш олон 4-ийн 3-ыг нь өөрчилчихсөн байна уу? Энэний зөвхөн

нэг нь гэхэд зөвхөн нэг нь тэр төсвийн суурь тэнцэл гэдэг ойлголт оруулж ирээд, суурь тэнцэл гэдэг ойлголт төсвийн алдагдал гэдэг, төсвийн алдагдал 2 хувиас хэтрэхгүй байх ёстой гэдэг тэр төсвийн хязгаарыг үндсэндээ тойроод өр нэмэх, зээл нэмэх бололцоог бол энэний цаана бүрдүүлж байгаа юм. Төсвийн алдагдал 2 хувиас хэтрэхгүй байна гэдгийг тойрохын тулд төсвийг ашигтай мэт харагдуулах бичилт хийх л ийм л арга аргачлал энэний цаана явж байгаа шүү дээ.

Жишээ нь дараагийнх нь тэр төсвийн худалдан авалттай холбоотой томоохон бүтээн байгуулалт гээд шууд худалдан авалттай холбоотой. 2, 3-хан сарын өмнө бид нар ногоон автобусны гэрээг шууд худалдан авалтын гэрээгээр хийчихлээ гэж бүгдээрээ нийгэм даяараа, тэрнээс өмнөх нь шууд худалдан авалт хийхийн тулд нууцад оруулж байгаад нүүрсийг оффтейк зарчихлаа гэж нийгэм даяараа юу болж энийг нээлттэй, ил тод, өрсөлдөөнт энэ нөхцөлийг хангах ёстой гэж нийгэм даяараа юу болж билээ? Гэтэл энэ бүгд хамаагүй. Намууд нийлчихээр энэ бүгд хамаагүй шууд гэрээ хийе. Энийг чадавхад суурилсан гэнэ үү, маш субъектив. Тэгээд өөрснөө хэнтэй ажиллах гэж байгаагаа бараг өөрснөө сонгон шалгаруулаад, өөрснөө урилгаа хүргүүлээд, тэгээд урилга хүргэсэн хүмүүстэйгээ хэлэлцээрээр хийчих юм байна.

Энийг дагаад чадавх гэдгийг яаж тодорхойлно гээд хуулиасаа давсан нэг журам л гарна энэний цаана, хуулиасаа давсан нэг журам гарна. Зүгээр л үзэмжийн л гэсэн үг. Гэтэл хуучин байгаа хуулийг хурдлуулах тэр нөхцөл бололцоо олон зүйлүүдийг бид нар хангахгүйгээр тэрэн дээрээ арга зам эрэлхийлэхгүйгээр зүгээр л гуравхан сарын дараа бид нар нийтээрээ орилж байсан тэр өрсөлдөөнгүй, ил тод бус, хаалттай, энэ хаалттай зүйлийн цаана авлига яадаг билээ. Энэ зүйлүүдийг ингэж энэ чигээр нь өөгшүүлж орж ирж байгаа энэ

дагалдаж орж ирж байгаа олон олон зүйл, заалтууд байна. Тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэдэг мэргэжлийн байгууллага ч гэсэн дүгнэлтээ илэрхийлсэн байна лээ. Тэгэхээр бид бүгдийн хувьд энэ дээр бас байр сууриа.../минут дуусав/

Р.Сэддорж: Дараа нь яах юм байна, нэмэх юм байна. Сангийн сайд Болдын Жавхлан хариулт хэлье. Дараа нь Цогтгэрэл гишүүн.

Б.Жавхлан: Ингээд улс төр гээд байх юм болбол цаашаагаа ер нь явах юм уу даа. Сая Цогтгэрэл даргын хэлсэн 2 зүйл дээр би хоёулан дээр нь ер нь огт санал нийлэхгүй байна. Зүгээр ойлгоё гэж хүсэхгүй байна л даа, ойлгоё гэж хүсэхгүй байна. Энэ 4 жил ингээд нэг тал талынхаа эрсдэлийг тооцоолж байгаад, хөгжиж болох ямар боломж байна тэрэн дээрээ л санал нийлчихвэл энэ хамтарч байгаагийн л ид шид тэгж гарна шүү дээ. Огт ойлгохыг хүсэхгүй байгаа юм байна гэж л би ингэж хараад байгаа юм.

Төрийн, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр бид 14 жил гол суурь зарчмууд дээр бол хөдөлгөөгүй юм. Ковидын үед нэг удаа, өмнө нь бас нэг удаа баримтлах шаардлагыг тухайн үеийн ковидын тодорхойгүй маш өндөр нөхцөл эрсдэлтэй нөхцөлд 1, 1 жилээр хойшлуулж байсан л асуудал байгаа. Энэ удаа бол хөгжсө гэж байгаа, юм хийе гэж байгаа. 14 жилийн өмнө тавьж байсан энэ хязгаар энэ юмнууд 14 жилийн дараа ганцхан манай улсад ч биш энэ ковидын дараах шинэ хөгжлийн эрин эхэлж байгаа үед олон улс өөрөө өөрсдийнхөө онцлогт тааруулж ингэж маневр хийж байгаа.

Тэр алдагдлын хязгаар, өрийн хязгаарыг хөдөлгөх гээд байна, байхгүй болоод байна гэдэг чинь шал худлаа тайлбар шүү. Та бол өөрөө маш сайн мэдэж байгаа. Бизнесмен хүн энэ хэмжээний нарийн ширийн тоонуудыг

бол маш сайн ойлгож байгаа. Тэр битгий хэл одоо үүсчихсэн байгаа нөхцөл байдал чинь харин ч бүүр 2 хязгаар нь бүүр байхгүй болчихоод байгаа юм шүү. Энийг ЗГ олж хараад энийг янзалъя. Гэхдээ мөн дараагийн 4 жил энэ хөгжлөө дэмжье, хамтарсан ЗГ-ынхаа энэ 4 жилийг дараагийн урт хугацааны том хөгжлийнхөө суурийг баттай тавьж авъя гэдэг ийм л санал оруулж ирж байгаа шүү дээ. Өр нэмэх гээд байна гэх юм өрийн хязгаарт 60 хувь хэвээрээ байж байгаа шүү дээ. Таазыг нь хязгаарлачихсан хэвээрээ байж байгаа.

Нэрлэсэн үнэ гэдгийг та ойлгож байгаа байх гэж бодож байна. Доороос нь бид нар ингээд доош нь татаж дардаг тоо ерөөсөө байхгүй болж байна гэсэн үг. Одоо гүйцэтгэл 40 байгаа бол нэрлэсэн үнээр тооцохоор шууд 45 болоод олон улсын жишигээр орчихно.

Дээрээс нь жил болгон суурь тэнцлээ 2 хувьтай гаргаад, дотоодын нутаг дээр энэ 2 хувь шүү. Энэ чинь бараг 1,9 их наяд болж байгаа. Үүгээр тухайн жилийнхээ зээл үндсэн өрүүдээ төлөөд явах гээд ийм 3 том түгжээ хийгээд, ямар ч эрсдэлгүйгээр ингээд тэнцлээ бариад ингээд цаашаагаа, дээрээс нь мөн энэ хөгжлийн санхүүжилтүүдээ хийгээд явах ийм боломжит хувилбарыг оруулж ирж байхад энийг ингээж буруу талаас нь мушгиж, улс төр хийж, ямар зорилготой юм бүү мэд ингээж хийх дээр нь би сайн ойлгож өгөхгүй л байгаад байна.

Төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль ч гэсэндээ шууд гэрээ гэж үг хаана байгаа юм бэ? Таны ойлгож байгаа чинь л тэр хэмжээнд байхгүй юу, наадах чинь.../минут дуусав/

Р.Сэддорж: Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Жавхлан сайд та харин энэ гишүүдийг бас ингээж буруу мэдээллээр ингээж өөрийгөө хаацайлж

ингээж хэлж болохгүй шүү дээ. Өрийг хязгаарласан 2 л үндсэндээ төсөв дээр 2 л заалт байгаа. Нэг нь 60 хувь, нөгөөдөх нь төсвийн алдагдал 2 хувиас хэтрэхгүй байна. Алдагдал гэдэг чинь өр зээлээр санхүүжүүлэх хэмжээ тэрний цаана явж байгаа. Гэтэл та төсвийн 60 гэдгийг лоозон майн мэт хэлээд, тэр 2 хувь дотор чинь тэр байгаа зайг та устгах гэж л байгаа шүү дээ. Төсвийн алдагдал 2 хувиас хэтрэхгүй гэдэг үгийг та авч хаяж байгаа шүү дээ. Өр зээлээс санхүүжнэ гэдэг дүнг нь та хасчхаад, төсөв ашигтай байна гэдэг зохиомол үг оруулж ирж байгаад, төсвийн алдагдлыг хэмжээ хязгааргүй нэмэх боломжийг л та бүрдүүлж байгаа шүү дээ. Тэгээд бусдыг тэнэг гэж бас ингээж хэлж болохгүй шүү дээ.

2 дугаарт нь тэр шууд худалдан авалтын авалт дээр ч гэсэн тэр тодорхой л байгаа шүү дээ. Чадавхад суурилсан арга гэнэ үү? Чадавх гэдэг үгийг хэн яаж, энэ хууль дээр чинь тодорхой заачихсан өгүүлбэр алга. Одоо энийг дагаад нэг журам л гарна. Тэр тусмаа тэрийг оролцогчийг өөрснөө сонгоод, урилга явуулаад нээлттэй биш. Хэнтэй хамтарч ажиллахаа зааж байгаад, үгүй ээ энэ чинь л яг бид нар 1 сарын өмнө, 2 сарын өмнө, 3 сарын өмнө нүүрсний хулгай, ногоон автобусны хулгай гээд ганцхан л энэ л байсан юм шүү дээ. Шууд худалдан авалтын цаана л авлигын асуудал, ил тод бусын асуудал, хардлага сэргээг олон зүйл энэний цаана л байсан юм шүү дээ. Худлаа юм уу энэ ямар.

Р.Сэддорж: Жавхлан сайд хариулах уу? Тайлбар Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүнээ би танд ингээд л зөндөө л хэлдэг юм. Та ерөөсөө ойлгохыг хүсдэггүй юм уу эсвэл ойлгогчхоод ингээд зориуд ингээж яриад байдаг юм уу? Өнгөрсөн 6 сарын 5-нд та бас яг энд, яг энэ зааланд шүү сууж байсан, сууж байгаад тэр Төсвийн

тогтвортой байдлын тухай хуулийг өөрчилсөн. АН-ын гишүүдээс ч гэсэн оролцсон шүү. Таны яриад байгаа тэр 6.1.2 буюу алдагдлын хязгаар чинь одоо 1 сарын 1-нээс байхгүй болчихоод байгаа шүү дээ. Яагаад та нар тийм юм хийсэн юм бэ? Та оролдсон, та кноп дарсан байна лээ. Өнөөдөр тэр хязгаар чинь бүүр байхгүй болчихоод байгаа шүү. Тэрийг буцааж оруулж ирж байгаа. Та 6 сарын 5-нд тэр протокол хараарай. 4 хүн гарын үсэг зурж санал оруулж энэ тэр санал хураалгасан байна лээ. Зарчмын зөрүүтэй санал гаргаад. Тэрэнд, 2 хувийг тэгж ярих юм бол та байхгүй болгочоод байгаа шүү. Тэрийг нь бид нар буцааж оруулж ирж байгаа, буцааж оруулж ирж байгаа. Шаардлагатай бол та хоёулаа яг энэ асуудлаар хоёулхнаа сууж байгаад бүүр мэтгэлцэж болно шүү. Таныг тийм зүйл, таныг тийм зүйл.../үг тасрав/

Р.Сэддорж: Хариулт хэлж дууслаа. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн. Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

М.Бадамсүрэн: Төсвийн тодотгол дээр энэ нийслэлийн түгжрэлийг бууруулах хөгжлийн асуудлаар томоохон зүйлүүд хэрэгжүүлэхээр, хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд тодотгол дээр гол нь энэ л орж ирж байна л даа. Гэхдээ ер нь цаашид бол хөдөөгийн хөгжлийг дэмжиж байж хотын төвлөрөл буурна л даа. Тийм учраас хөдөөд илүү хөрөнгө оруулалтыг бол цаашид хэрэгжүүлэх ёстой. Энэ үүднээсээ бүсчилсэн хөгжлийг дэмжих хүрээнд бүс болгонд 10 тэрбум төгрөгөөр ТЭЗҮ хийх, тэгээд энэ ажлыг шуурхай хийх, зохион байгуулах шаардлагатай. Энд бид бас мэдээж оролцоно.

Тэгэхээр цаашидаа энэтэй холбоотой юу хэлэх гэж байна гэхээр энэ манай зүүн бүс рүү явсан нэг авто зам байгаа. 12-оос 16 онд энэ Алтанхуягийн ЗГ-ын үед гэрээ байгуулсан. Тэгээд бас л

яаж гэрээ байгуулсан юм мэдэхгүй энэ Хөгжлийн банк л байгуулсан. Тэгээд энэ зам чанаргүй болчихоод байхад энэ дээр санхүүжилтийг нь олгочихсон нь л хамгийн гол буруу асуудал байгаа юм. Тэгээд Тамын 50км, 27км гээд. Яах вэ энийг Дэлхийн банкаас санхүүжүүлэхээр Улсын Их Хурал шийдвэр гаргасан тэрэнд бол талархаж байгаа. Гэхдээ энэний худалдан авалт эхлээгүй байгаа. Хэзээ сонгон шалгаруулалт дуусах вэ гэдгийг 1 дүгээрт ЗТЯ-наас асууя.

2 дугаарт 27км зам бас эвдрэлтэй Хансун зам гээд компани гүйцэтгэсэн. Түүрүүчийнх нь бол Чайна жо инженеринг гээд. Тэгээд энэ 38,1 тэрбум төгрөг энд шаардлагатай байгаа гээд ийм төсөв магадлал гарчхаад байгаа юм. Тэгээд энийг ер нь хэзээ санхүүжүүлэх боломжтой вэ?

2 дугаар асуулт, 3 дугаарх нь энэ Зам, тээврийн сайдын багц дээр энэ төсөв өөрчлөгдөж байна. 125,8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа гээд 20,4 хувиар. Энд нөгөө ТЭЗҮ замын энэ ажлууд орж байгаа байх гэж бодож байна. Гэхдээ энэ дээр хөрөнгө оруулалт, их засвар гэгчихсэн байгаа юм. Тэгээд энэ их засварын ажил дээр нь энэ манай энэ алдарт 27км замын ажлыг хийх үү? Яагаад гэхээр би зүгээр ямар юм хэлэх гээд байна вэ гэхээр дүгнэж хэлэхэд мэдээж шинэ хөгжилд тэмүүлсэн хөрөнгө оруулалт хийх нь зөв. Гэхдээ хуучин өмнө 10 жилийн өмнө барьчихсан, тэгээд төр өөрөө хяналтаа тавьж чадаагүй, ашиг сонирхлын зөрчилд өртсөн байж болзошгүй ийм нөхцөлд энэ замын улмаас хохирсон хохирлыг энэ зүүн бүсийн иргэд одоо хүртэл энэ хохирлыг даван туулж, олон хүний амь нас, эд хөрөнгө хохирч байгаа ийм л дүр зурагтай байгаа л даа. Тэгэхээр энийг яаралтай яаж шийдэх вэ? Иргэд бол асууна шүү дээ. Шинэ хөрөнгө оруулалт хийх нь зөв. Гэхдээ өмнө нь энэ зүйлийг яаж залруулах вэ 1.

2 дугаарт энд яаж хариуцлага тооцох вэ, энд алдаа гаргасан албан тушаалтнуудад яаж хариуцлага тооцох вэ, энийг яаж улсыг хохиролгүй болгох вэ? Цаашид ийм алдаа яаж гаргахгүй байх вэ гэдэг энэ хамгийн чухал асуудал байгаа. Тийм учраас энэ Булганы, Дорнод аймгийн Булган сумын нутагт байгаа энэ 27км Хансун зам гээд компанийг гүйцэтгэсэн энэ замыг засахгүй бол одоо зорчих боломжгүй л дээ, дандаа хажуугаар нь явна. Бороо ус ихтэй. Тэгээд ер нь нэг л зүйл байгаа шүү дээ. Ингээд төсвийн хөрөнгөөр зам тавьчихаад байдаг. Тэгэхэд тэрний хажуугаар иргэд яваад байгаа байхгүй юу. Тэгээд энэ бол хэн ч байсан уурлана. Тэгэхээр энэ зүүн бүс нутгаас сонгогдсон гишүүд бол энэ дээр бүгд 100 хувь санал нэгтэй байгаа байх гэж бодож байна. Энэ дээр Сангийн сайд ямар дэмжлэг үзүүлэх боломжтой вэ гэдгийг асууя.

Р.Сэддорж: Үг хэлэх дээр Алдаржавхлан гишүүн, Энхтүвшин гишүүн нарыг нэмье. Асуулт асуух дээр уучлаарай, энэ дээр нэмээрэй. Жаргалан, Соронзонболд гишүүн нарын араас. Энхтүвшин. Хариулт ЗТЯ, хариулт. Тусдаа, тусдаа. ЗТЯ-наас хариулт хэлэх хүн байна уу? Асуултад хариулах хүн байна уу ЗТЯ? Жавхлан сайд. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Таны хэлсэнтэй 100 хувь санал нийлж байна. Тэр хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил маш чухал шүү, маш чухал. Ер нь бид нар хөдөөгөөс хот руу шилжиж байгаа нүүдлийг хөдөөд нь барьж авах нь бас их хамгийн том чухал асуудал байгаа юм. Хотоо задлахтайгаа зэрэгцээд. Тийм учраас энэ бүсчилсэн хөгжил гэдэг маань тэрэнтэй ч уялдаж гарч ирж байна суурь ойлголт нь. Дэд бүтцийн хувьд эрчим хүчний эх үүсвэрүүдийг орон нутаг руу мөн 5 цагариг тэр тээвэр логистик энэ зам, тээврийн хөгжлийн бодлого маань ч өөрөө яг энэ рүү чиглэж байгаа ийм асуудлууд байгаа. Тэгээд ингээд

задлаад яг төслүүд ярих юм бол маш олон юмнууд байгаа.

Тэрэн дотроос та хэд хэдэн төсөл тэр тамын 50 байна. Уг нь энэ жил бид нар 100 сая долларыг Дэлхийн банкнаас тавьсан юм. Тэгээд гүйцэтгэл нь маш муу гарлаа, бараг эхлүүлчхээж чадсангүй. Тэгэхээр үлдсэн хугацаанд уг нь нэг санхүүжилтээ эхлүүлчих нь аягүй чухал байгаад байна. Энэ дээрээ уг нь ЗТЯ-наас байсан бол илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх байсан болов уу гэж бодож байна.

Тэгээд энэ удаад тодотгол орж ирж байгаа учраас таны саяын ярьсан тэр Булганы 27км-ийг сайн мэдэж байна. Тийм учраас тун удахгүй 9 сарын 1, хэдхэн хоногийн дараа 25 оны төсөв өргөн барина. Түүн дээр яам нь ямар бодлогын саналууд ирэх нь вэ? Төсвийн ямар боломж гарах нь вэ? Тэгээд л тэр хэмжээнд л ороод явна. Тэгэхдээ ер нь орон нутгийн зам болбол маш чухал тавигдана. Ер нь ингээд тодотгол хийж байх явцад гишүүдийн ярьж байгаа энэ хандлагыг харахад ер нь 25 онд энэ жижиг төсөв хөрөнгө оруулалтуудыг ер нь тэвчихвэл яасан юм гэсэн тийм зоригтой саналууд их гарч байна. Энд би их баярлаж байгаа. Үнэхээр яг хэлсэндээ ингээд байгаад 25 оны төсвөө яг энэ чиглэлээр бодлогоор дэмжээд явбал ЗГ бол ингэж оруулж ирэхэд бол бэлэн байгаа гэдгийг хэлье. Тийм.

Р.Сэддорж: Тодруулга байна уу? Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье. Бадамсүрэн гишүүн, гишүүний микрофон.

М.Бадамсүрэн: 1 дүгээрт ЗТЯ-наас энэ талаар заавал хариулт авмаар байна Байнгын хорооны даргаа. Энэ их олон иргэдийн эрх ашигтай холбоотой асуудал л даа. Тэгээд тэр үеийн ЗГ-ын буруу байгаа, тэр тухайн үеийн яамны. Гэхдээ энийг бол төр хариуцах ёстой. Тэгэхээр энэ дээр би аягүй ноцтой асуудлуудыг асууж байгаа байхгүй юу. Энийг нэг мөр болгох ёстой. Манай

иргэд, сонгогчид бол үүнийг л дайсан. Яагаад ийм байдал үүсэв гээд. Тийм учраас энийг би заавал асуух ийм саналтай байна.

2 дугаарт нь энэ замын хувьд бол бүсчилсэн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд ирэх оны төсөв дээр мэдээж том бүс дамнасан энэ зүйлүүдийг илүү түлхүү дэмжих байх л даа. Тэгэхээр энэ чинь 3 аймгийн нутгаар явж байгаа л зам байхгүй юу. Тэгээд энэ маань өөрөө аялал жуулчлал, тэгээд энэ зүүн бүсийн иргэдийн зорчдог зам, тэгээд ингээд эвдэрчхээд бараг 10 жил ингээд энийгээ засдаггүй. Тэгээд ийм сонин нөхцөл байдалтай учраас энийг бас тэргүүлэх эгнээнд авч үзээч. ЗТЯ бол дэмжинэ гэж байгаа. Дэмжсэн ч учраас ингээд магадлалын дүгнэлт, зураг төсөв нь ингээд хийгдчихсэн бүх юмыг баталгаажуулчихсан байгаа. Энийг тодруулъя. ЗТЯ-наас хариулт авмаар байна.

Р.Сэддорж: Зам, тээврийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд Дэлгэрсайхан сайдыг дуудаж байна. Яамныхан сайдыг дуудъя. Өөр хариулт хэлэх хүн байна уу? Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Би мэргэжлийн яамнууд нь орж иртэл торгоож байхаас. Бид 2000 оноос хойш Мянганы зам энэ томоохон төсөл эхэлснээс хойш 2 жилийн өмнө Завхан аймгийн Загастайн даваагаар давуулж, Улиастайтай холбоод бүх аймгуудаа Улаанбаатар нийслэлтэйгээ холбочхож байгаа юм. Ингэсний үр дүнд 8000 гаруй бид улсын стандарт бүхий ийм хатуу хучилттай замтай болж байгаа юм. Энийг дагаад урсгал засвар, их засвар гэдэг маш том дараагийн бас сорилт гарч ирж байгаа байхгүй юу. ЗТХЯ-наас гаргасан тооцооллоор бид нар бараг жилдээ энэ засварууд нийлээд 1 их наяд болж ирж байгаа. 1 их наяд гаруй болж ирж байгаа байхгүй юу.

Энэ дотроос 2 том засвар одоо яг тулчхаад байгаа нь Дорнодын тэр тамын 50 гэж байгаа 50км зам мөн урагшаагаа говийн бүсийн аймгууд руу явж байгаа, Улаанбаатар хотоос гараад л ямар яаж эхэлдэг билээ бүгдээрээ мэдэж байгаа 100-гаад километрийн асуудал байгаа юм. Энэ 2 дээр их томоохон засварын дүнгүүд тулчихсан. Энэ жил ингээд уг нь шууд төсөв дээрээс бас ачааллаа арай багасгаад бид Дэлхийн банкны урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл рүү явуулаад оруулсан боловч хаана хаанаа хариуцлагагүй байдлууд гарч байна. Ингээд гүйцэтгэл муу гараад байгаа юм. Тийм учраас ирэх жилийнх дээр болбол хамгийн түрүүнд энэ тулчихсан байгаа энэ их засварын ажлууд болбол ер нь тавигдаж таарна, тавигдаж таарах байх. Тэгэхээр энэ бол яг бодлогын нэгд байгаа.

Ер нь болбол шинэ гэхээсээ илүү энэ хуучин засваруудаа яаралтай хийж дуусахгүй бол энэ хийгдээгүй байгаа засварууд чинь жил болгон улам эрсдэлд ороод, улам эвдрэл нь нэмэгдээд, төсөвт өртөг нь улам нэмэгдээд байдаг ийм аюултай. Ийм бас том бодлогын сорилт бидний өмнө гарч ирээд байгаа. Тийм учраас цаашидаа энэ том улсын стандарт бүхий энэ замуудаа хэсэгчилж, орон нутгийн АЗЗА-нууд руу өгч тоолууртай болгодог ч юм уу ийм байдлаар төр, хувийн хэвшлийн түншлэл рүү шилжүүлэхгүй болбол дан ганц төсвөөрөө энэ урсгал зардал, их засвар 2-ыг бол.../минут дуусав/

Р.Сэддорж: Зам, тээврийн сайд ирэх боломжгүй юм байна. ТНБД нь өвчтэй байгаа юм байна. Тийм учраас Бадамсүрэн гишүүн чуулган дээр та яг энэ асуудлаа сайдад асуулт тавьж, хариулт авахыг хүсэж байна. Мөн бичгээр болно биз дээ. Ингээд дараагийн гишүүн Батбаярын Жаргалан гишүүн. Сайнзориг гишүүнийг нэмье.

Б.Жаргалан: Улаанбаатар хотын асуудал бол Монголчуудын хувьд бол нэн

тулгамдсан асуудлуудын тоонд зүй ёсоор орж байгаа. Агаарын бохирдол, хөрсний бохирдол, түгжрэл гэх мэтчилэн Монголчуудын амьдралын чанарт хамгийн ихээр нөлөөлж байгаа асуудал бол энэ хотод байгаа. Тэгэхээр энэ Улаанбаатар хотын асуудлыг хамтарсан ЗГ-ын зүгээс хэрхэн яаж шийдэх гэж байна вэ гэж асуухаар ерөнхийдөө бол энэ хотыг задлах, дагуул хотоо хөгжүүлэх, тэр нөгөө энэ төсвийн тодотгол дээр тавиад байгаа тэр томоохон дэд бүтцийн ажлуудыг хийх замаар шийднэ гээд байгаа юм.

Тэгэхдээ яах вэ тэглээ тэглээ гээд ер нь бол энэ үндсэн хотод чинь бол нийт иргэдийн олонх нь амьдарна. Нэн ялангуяа манай хойд талын гэр хорооллуудын асуудал бол байсаар байна. Тэгээд энэ асуудлыг хэрхэн яаж шийдэх гэж байна гэхээр энэ нөгөө нэг дэд төвүүдээ яриад байгаа юм. Сэлбэ дэд төв гэх мэтчилэн. Тэгэхээр энэ Сэлбэ дэд төв дээр жишээлбэл сая бол төсвийн тодотгол дээр 584, 84 тэрбумаар газар чөлөөллөө гээд ороод ирж байгаа. Дээрээс нь нөгөө энэ дэд төвийн тэр станцуудынх нь хөрөнгө оруулалтад гэх мэтчилэн олон улсын байгууллагуудын санхүүжилтээр ч гэсэндээ зөндөө олон хэмжээний мөнгө тавигдсан байж байгаа. Тэгэхээр хотын захиргаанаас энэ Сэлбэ дэд төв дээр ер нь бол хэр хэмжээний хөрөнгө оруулалт тавигдсан байгаа вэ? Ер нь хэр хэмжээний хөрөнгө оруулалт хийгдээд явж байгаа вэ? Үүний хүчинд хэдэн яндан устах вэ, хэдэн нүхэн жорлонгоосоо бид салах вэ, хэдэн хүний амьдрал ахуй сайжрах вэ гэдэг нэг ийм асуулт байна.

Тэгээд ер нь цаашидаа бол ийм өгөөж маш их чухал тийм ээ. Маш их хэмжээний өндөр өртгөөр бид нар бас энэ асуудлуудаа шийдэхээсээ илүү ийм төвлөрсөн бус, бие даасан тийм шийдлүүдийг илүү чухалчлах нь зөв санагдаад байгаа юм. Тэгэхээр энэ нөгөө үйл ажиллагааны төлөвлөгөө бөгөөд тодотголд орж ирж байгаа зүйлүүд

дээр нэг тийм төвлөрүүлэх гээд байгаа бас нэг тал ажиглагдаад байна.

2 дугаарт ЗГ-ын нэг цэгийн үйлчилгээний цогцолборт гэдэг Номтын аманд баригдах тэр байгууламжид 676,3 тэрбум төгрөг төсөвлөсөн гэж байна. Тэгээд энэ онд 100 тэрбумыг шууд тавьчихаж байгаа юм байна. Энэ цогцолборын ТЭЗҮ бий юү, тэгээд зураг ч юм уу эсвэл ямар нэгэн юм харж болох уу? Нөгөө нэгэнтээ 100 тэрбум төгрөгөөр тавиад эхэлж байгаа юм чинь. Тэгээд энэ асуултыг ЗГХЭГ-аас асуухаар байна.

Мөн малчин хоршооны зээлийн хүүгийн зардал гээд 126,7 тэрбум ороод ирж байгаа юм. Тэгэхээр энэ малчин хоршооны зээл авсан хэдэн зээлдэгч байгаа вэ? Тэгээд нийт хэдэн төгрөгийн зээл олгогдсон юм бэ? Тэрний зээлийн хүүгийнх нь энэ татаас гэж ойлгож байгаа. Энэ дээр нь яг ямар мөнгө тавигдаж байгаа юм бэ гэдгийг бас асуух байна. Баярлалаа.

Р.Сэддорж: 4 номерын микрофоныг өгье.

Н.Мандуул: НЗД-ын нэгдүгээр орлогч Мандуул байна. Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол хотын энэ яг энэ гэр хорооллыг орон сууцжуулах тал дээр бол нийслэл хот энэ жил нэлээн томоохон ажил төлөвлөөд, урьд жилүүдэд бас энэ газар төлөвлөлтийн ажил дээрээ бас их гацдаг байсан юм байна лээ. Тэгээд энэ жил бол 500 гаруй тэрбум төгрөг зөвхөн энэ газар чөлөөлөлт дээр зориулж төсөвлөсөн байгаа. Ингэснээрээ бол бид Сэлбэ дэд төвийн 158 га газрын 2206 нэгж талбарыг чөлөөлөөд, тэгээд түүн дээр нь орон сууц, тэгээд яг энэ 20 минутын хот концепт дээрээ төвлөрөөд 40 хувь нь ногоон байгууламж, сургууль, цэцэрлэг нь хүртээмжтэй, төрийн үйлчилгээ нь ойрхон ийм яг жишиг хороолол болгохоор ингээд ажлыг нь эхлүүлчихсэн явж байна.

Яг тоогоор ярих юм бол энэхүү Сэлбэ дэд төвийг гэр хорооллыг нь орон сууцжуулснаар бид 2033 яндан байхгүй болно, 1838 жорлон нүхэн жорлон байхгүй болно. Тэгээд жилдээ 7035 тонн нүүрс сайжруулсан түли түлэх ийм хэрэгцээ байхгүй болно. Үүнд бол нийтдээ 2230 гаруй иргэн, өрхүүд, ААН-үүд хамрагдаж байгаа. Тэгээд Нийслэлийн хувьд энэ жилдээ газар чөлөөлөлт дээр ингээд нэлээн томоохон төсөв тавьснаараа яг хуулиараа бол бид орон сууцын барилга барьсан, тэгээд түүнийгээ бол зарж борлуулахгүй, зөвхөн тэр орон сууцаа цаашидын газар чөлөөлөлт дээр ашиглана. Тэгэхээр ирэх жилүүдэд бол энэхүү газар чөлөөлөлтийн төсөв маань бага болоод явна гэсэн тийм хүлээлттэй байгаа.

Р.Сэддорж: Дараагийн хариулт хэлэх хүмүүс. Шинэ хоршооны талаар. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Тэр Хэрэг эрхлэхээс асуусан асуултад бас нэмэлт мэдээлэл өгчихье. Тэр шинэ байгууламж маань одоогоор урьдчилсан тооцоо хийгдсэн байгаа, зураг барилгын барилга эхлүүлэх бол бэлтгэл ажил нь болбол хараахан хийгдээгүй. Тэгэхээр энэ маань худалдан авах ажиллагаанд түлхүүр гардуулах нөхцөлөөр хийгдээд, энэ жилдээ зураг төсөв, бэлтгэл ажил нь хангаад ингээд дамжаад энэ 100 тэрбум төгрөгөө ашиглаад барилгын ажлыг эхлүүлэх ийм төсөв байгаа гэсэн үг. Тийм. Ингээд батлагдчихвал ингээд бэлтгэл ажил руугаа шууд ороод явна гэсэн үг.

Малчин шинэ хоршоо тоонууд асуусан. Би харж байгаад хэлэхгүй бол болохгүй байна гэж. Ингэж байна 8 сарын 12-ны өдрийн байдлаар нийтдээ 442, 42 тэрбум 66 сая төгрөг гарсан байна. Үүнд хамрагдсан малчны тоо нь 12885, хоршооны тоо нь 3467, одоо банкнууд дээр судлагдаж байгаа дүн нь 66 тэрбум байна шинээр. Үүнд хамрагдах

малчдын тоо 911, хамрагдах хоршооны тоо 252 байна гэж байна. Энэ аймаг тус бүрээр нь та сонирхож байвал аваарай надаас.

Р.Сэддорж: Жаргалан гишүүнд тодруулга байна уу? Жаргалан гишүүний микрофоныг өгье.

Б.Жаргалан: Энэ Сэлбэ дэд төвтэй холбоотой асуудал дээр яах вэ ийм их хэмжээний хагас их наядаар газар чөлөөлчхөөд, тэгээд маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийчхээд 2000 яндан устгаж байна гээд бас ярьж байж бол болохгүй байх. Яах вэ ер нь цаашидаа бол энэ ингээд нөгөө эхлэл тавигдаж байна ч гэдэг юм уу тийм ээ дараа дараагийн газар чөлөөлөлтийн суурийг тавина ч гэдэг юм уу тиймэрхүү байдлаар үзэхгүй бол бид нарын харин энэ нөгөө нэг ийм нэгж утгаар нь тооцоод үзэхлээр энэ өртгүүд чинь бол маш өндөр болоод байна л даа.

Тэгээд би нөгөө газар чөлөөлөлтийн асуудал дээр анхаарал хандуулаад байгаа нь юу вэ гэхээр энэ бас нэг ийм Засаг их хэмжээний ийм мөнгийг газар чөлөөлөлтөд зарцуулаад эхлэхээр Улаанбаатар хотын бас ийм газрын үнэ ханиш, газрын зах зээлд бас их нөлөөлнө. Тэгэхээр нөгөө хэлэлцээрүүдээ яаж хийж байна вэ тийм ээ, яг тэрийгээ бас яг зах зээлийнх нь зарчим руу аль болох нөгөө ойртуулсан байдлаар явуулахгүй бол дараа нь ингээд нөгөө нэг ийм Улаанбаатар хотынхоо газрын үнийг бүүр хэт хөөрөгдөөд, тэгээд дараа нь ингээд янз бүрийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжгүй болчих вий дээ гэсэн бас нэг ийм болгоомжлол байна. Яагаад гэхээр анх удаа шахуу бас ийм их хэмжээний хөрөнгө оруулалтаар газар чөлөөлөх үйл ажиллагаа бас ийм далайцтай байдлаар хэрэгжиж байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр бас их анхаарвал сайн байна гэж хэлэх байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Жаргалан гишүүн нийтлэг чухал л асуулт асууж байна. Тэгээд яах вэ Улаанбаатар хотынхон бол мэрийж л байгаа байх. Тэгээд гишүүнийхээ хувьд хөнгөн болон хүнсний үйлдвэрүүдийн үйлдвэрүүдэд энэ гэр хороололд дахин төлөвлөлтийн газрыг өгөөд, тэр гэр хорооллын дунд ийм соёлтой компаниудыг төв оффисыг ч юм уу, үйлдвэрийн өргөтгөлийг оруулж очих нь бол маш зөв шүү дээ. Жишээ нь Апу компани үйлдвэрийн өргөтгөлөө барихаар бол тэнд 30 айлтай тохироод газрыг нь өгөөд тэр хавийн бүх хүмүүс ажилд ороод, гэртэйгээ ойрхон ажилтай болгоод тэгээд соёл нь тэнд хамт очоод ингээд явчих юм болов уу гэсэн ийм бодолтой байдаг юм. Тэгээд ерөөсөө л газ, энэ газын талаар судалж байгаа байлгүй. Газаа яаралтай нэвтрүүлээд газ хэрэглэх айллууд гэр хорооллоор их байгаа шүү дээ. Энэ дээр нийслэлийнхэн маань анхаараарай гэж хэлье. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Төсвийн тодотголтой холбоотой нэг асуулт байгаа юм. Энэ Спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад 3 тэрбум төгрөгийн нэг татаас байгаа. Энэ татаасны зориулалт юу вэ гэж 1 дүгээр асуулт. Хэрвээ энэ аялал жуулчлалын ч юм уу салбарын ААН-үүдийг дэмжих чиглэлээр явж байгаа бол эдгээр тэр дэмжлэгийнх нь гүйцэтгэл нь ямар байгаа вэ? Хэчнээн ААН хамрагдчихсан байгаа юм бэ? Тэгээд зээлийн багц нь хэд байгаа юм ч гэдэг юм уу тиймэрхүү мэдээлэл авмаар байна.

Р.Сэддорж: Асуултад Сангийн сайд Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Соронзонболд гишүүнээ наадах чинь одоо яг нөгөө тодотгол дээр байгаа тоонууд биш учраас би танд албан бичгээр хүргүүлье. Тийм.

Р.Соронзонболд: Соронзонболд гишүүнд албан бичгээр хүргүүлэхээр боллоо Сангийн сайдаас. Болсон уу Соронзонболд гишүүн? Жуковын Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Би нөгөө чуулган дээр асуусан юмаа л асуух гээд байгаа юм. Барилгын яамны сайдаас би асуусан шүү дээ. Солонго 1, 2 гээд хороололд тийм ээ. 150 тэрбум төгрөг төсөвт суучихсан байгаа байхгүй юу. Тэгээд 5000 айл гэж байгаа. Энэ Хүннү 2022 гэдэг маш том хотхон чинь 2000 айл байдаг байхгүй юу. Тэрнээс 2,5 дахин тийм том хотхон сургуульгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд та нар Барилгын яамныхан намайг тэгэж ярьснаас хойш энэ нийслэлтэйгээ уулзаж, сургууль цэцэрлэгийн асуудлыг хөндөж байна уу? Та нар ер нь тэнд санаа зовж байна уу? Тэнд одоохондоо зураг дээр байгаа учраас асуудал хүндрэхгүй байгаа юм. Яг хүмүүс байрандаа ороод эхлэх юм бол 5000 хүүхэд хаашаа явах нь мэдэгдэхгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд энийг Барилгын яамныхан юу гэж бодож байна вэ?

2 дугаарт нь энэ улсын төсвөөс барилга барьдгийг ер нь цаашидаа боливол яасан юм бэ? Яах вэ энэ олон улсын гэрээ байж магадгүй. Гэхдээ ер нь тэгээд төсвийн хөрөнгөөр орон сууц барьдаг ийм юу бараг байхгүй байх. Би лав сонсоогүй л юм байна. Тэгээд энийг ер нь цаашидаа ер нь дэмий юм биш үү л гэсэн ийм бодолтой байгаа. Тэгээд энэ дээр ингэж 2-т хариулж өгөөч.

Энэ аудитынхан байгаа юу? Энэ биеийн тамир спортын салбарт энэ аудит энэ юутай холбоогүй л дээ. Тэгэхдээ та хэд маань аудит энэ тэр хийж үзэхгүй бол сая энэ нэг олимп болоод бөөн хэл ам болж байна шүү дээ. Бид нар өгсөн санхүүжилт дээрээ араас нь та хэд маань аудит хийж үзээрэй л гэж хүсэж байна.

2-т нь тэр Олимпын хороо гэж нэг ийм дарга нар гадагшаа явуулдаг тийм ТББ юм байна лээ шүү дээ. Тэр чинь ерөөсөө Монголын үндэсний олимпын төлөө биш, хэдэн дарга нарыг гэр бүлтэй нь очиж, олимп үзүүлдэг л тийм байгууллага болчихсон. Нэг том баяны хүүхэд даргыг нь хийдэг тийм байгууллага байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь та хэд маань энийгээ ингээд нэг хянаж үзээд, тэр биеийн тамир, спортын салбарт оруулсан хөрөнгө оруулалтаа нэг аудит хийж үзвэл яасан юм бэ гэсэн ийм санал байгаа шүү. Зүгээр энэ бол төсвийн тодотголд хамаагүй. Гэхдээ та хэд маань нэг бодож үзээрэй. Монголын ард түмэн яриад байгаа байхгүй юу. Би биш. Тэгэхээр энийг бас та хэд маань анхаарч үзээсэй гэж хүсэж байна. Би тэр Барилгын яамны хүнээс хариулт сонсьё.

Р.Сэддорж: Дугаартай микрофон дээр очоорой. 1 номер дээр очъё, 1 номерын микрофоныг өгье. Микрофоныг нь нээгээрэй.

С.Төмөрхүү: Гишүүний асуултад хариулъя. Солонго 1, 2 хороолол бол БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хийгдэж байгаа хороолол. Зүгээр хороолол дээр бол өнгөрсөн онд ажил нь эхэлсэн нэлээд асуудлууд гарч ирж байгаа. Ялангуяа газрын төлөвлөлттэй холбоотой, зарим хэсэг дээр нь авто замын магистрал давхацсан, өөр хувийн хэвшлийн орон сууц баригдсан энэ тэр асуудлууд бий. Хорооллын үндсэн ажлууд бол цаг хугацааны дагуу явагдаж байгаа. Сургууль, цэцэрлэгийн асуудлууд, нийгэм, ахуйн барилга байгууламжийн асуудлуудыг бол Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам Нийслэлтэйгээ хамтран дараа дараагийн жилүүдэд шийднэ гэсэн ийм төлөвлөгөөтэй яриа хэлцэл, судалгааны түвшинд асуудлууд явагдаж байгаа.

Р.Сэддорж: Тэр Хүннү гээд 5 мянга хэдэн зуун айл билээ тэрний

талаар ярихгүй юм уу тайлбар? Би Солонго 1, 2 хорооллын талаар гэж ойлгосон. Тодруулга Жуковын Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Энэ ингэмээр байна шүү дээ. Үгүй ээ би чиний оронд байсан бол ийшээ гараад л энэ хотын орлогч 1 дүгээр орлогч дарга байна, энэтэй уулзаад л тэнд нэг газар өгөөч, бид нар хөрөнгө оруулалтынхаа төлөвлөгөөнд оруулъя гээд ажилламаар л байгаа байхгүй юу. Тэрэн дээр л яг ажиллахыг хүсэж байна. Наадах чинь барилгын ажил нь аягүй эрчтэй явж байгаа, тун удахгүй хаалга тогших гээд байгаа байхгүй юу тэр зовлон чинь. Тэгээд хүүхэд гэрт сургуульд хүргэж өгдөггүй хүмүүс энэ зовлонг нь мэддэггүй юм л даа. Гэрээсээ хол явах чинь хамгийн том асуудал шүү дээ. Хүүхэд өглөө эрт босно, заавал хүн хүргэж өгнө. Тэгэхээр энийг л би шийдээд өгчхөөч. Одоо энийг хол яваагүй байгаа дээр нь та хэд маань нийслэлтэйгээ ярьж байгаад, уулзаад ингээд шийдээд өгчхөөч. Наадах чинь 5 мянган айл гэдэг чинь аймаар том тоо байхгүй юу даа. Нэг ч цэцэрлэг байхгүй. Үгүй ээ бүүр арай дэндүү. Энийг л бүүр анхаарлаа хандуулаач, тэр сайддаа хэлээрэй. Би өчигдөр бас гуйсан шүү. Та хэд биелүүлэхгүй бол би очиж тэр барилгын талбай дээр очиж суулт хийнэ шүү. Та хэд энийг яаралтай биелүүлж өгөөсэй гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Санал гэж ойлголоо. Зам, юу Барилгын яамны хэн билээ та? Төмөрхүү. Тэгээд юмнууд дээрээ сайн анхаараад, хариултаа энэ гишүүдийн асуултад бичгээр болон бусад хэлбэрээр өгөхийг хүсэж байна. Дашицэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Нийслэлээс болон аудитаас 2 асуулт байна. Нийслэлээс болохоор ер нь бол юу орж ирж байгаа нийслэлтэй холбоотой том төслүүд болохоор яг түгжрэлийг сааруулахтай холбоотой заалтууд байна. Тэгэхээр яах вэ нийт том зургаар нь гаргаж ирж

юмнуудаа жишээлбэл авто замын ачааллын үзүүлэлтүүд нь Жайкагийн судалгаагаар болохоор 2023 онд 1,7-гоос 2,2, 1 байх ёстой үзүүлэлт маань ийм давчихсан байна гэсэн судалгаа гарсан байсан. Тэгэхээр энэ саяын энэ тус тусдаа байгаа салангид байгаа төслүүдийг хэрэгжүүлснээр бид нарын зориод байгаа үзүүлэлтүүд чинь яаж буурах юм бэ? Тэгэхээр яах вэ зүгээр зургийг нь харахаар тус тусдаа километрийг нь заачихсан, тэр чинь уг нь техникийн судалгаагаараа хэдэн километрээ хаагуур гарах юм, тэгээд эд нар нь хоорондоо яаж уялдах юм гэдэг мастер төлөвлөгөө юм байгаа юу үгүй юу? Уг нь тэгж байгаад салаалмаар юм шиг зүгээр ингээд бизнесийн утгаар харахаар тэгж харагдаад байгаа. Тэгэхээр тус тусдаа юм шиг, тэгээд нөгөө 1км чиглэлүүдийг нь тогтоочихсон, урьдчилаад тогтоочихсон болохоор бас жоохон тодруулах хэрэгтэй юм уу гэж бодсон. Тэгээд энэ авто замын ачаалал маань яаж буурах юм бэ энэ төслүүд хэрэгжсэнээр гэдэг нэг асуулт байна.

Аудит дээр нэг асуулт байна. Улсын Их Хурлын сонгуульд намууд орохдоо мөрийн хөтөлбөр дэвшүүлдэг. Тэгээд мөрийн хөтөлбөр дээр заасан заалтууд яг ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээр орж ирэхээр байхгүй болчихоод байгаа юм. Жишээлбэл МАН-ын мөрийн хөтөлбөр дээр би сонгуульд орохдоо жишээлбэл ДНБ-д яг төсвийн зарлагын дээд хэмжээг 25 хувь байлгана, гадаад өрийг 40 хувь байлгана гээд биччихсэн байгаа байхгүй юу. Би энийг нь тэгээд ярьж явсан юм. Тэгээд одоо ингээд юу 2 сар хүрэхгүйн дараа ингээд ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр гээд ороод ирэхээр тэрнээсээ өөр юм оруулаад ирэхээр аудитынхан яаж харж байгаа юм бэ? Эсвэл боломжгүй юмыг ингээд тусгаад ороод, өмнө нь нэг юм ярьчихаад сар хагасын өмнө одоо ингээд өөр болоод ирэхээр аудит яаж харж байгаа юм бэ?

Уг нь бусад улсуудын ЗГ дээр тэр заалтыг нь тухайлсан заалтыг нь авч оруулдаг болохоос яг ингээд нэмж, хасаад ч юм уу өөрчилж оруулдаггүй тэгж санагдаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр боломжгүй юмыг ингээд хэлчихсэн байсан байна уу? Энэ талаар бид нарын хувьд болбол тойрогт хүмүүстэй ярихад бас ярьж байсан юмнаас зөрчихөөр, ялангуяа эдийн засагтай холбоотой саяын гол гол эдийн засгийн бодлогын зарчмууд нь өөр болчихоор. Энэ мөрийн хөтөлбөрөөс бид хэд бизнесийн хүрээнд бол ярьж байсан юм болохоор ер нь бол хувийн хэвшилээ нэлээн дэмжиж явах нь. Төр нэлээн өөртөө хэцүү даалгавар тавьж байгаа юм байна. Төсвийн зарлагыг 25 хувьд барина гэдэг бол маш хэцүү байхгүй юу. Тэгэхээр ийм юм тавьж явсан байна, тэгээд энэ нь өөрөөр хэлбэл хувийн хэвшилээ дэмжих гээд байгаа юм байна, гадаад зээл авахгүй байгаа юм байна, мөнгөө нэмж хэвлэхгүй, инфляцаа нэг оронтой тоонд, зээлээ нэг оронтой тонн байлгана гэсэн заалтууд тавиад ингээд ярьж явсан.

Гэхдээ яг ингээд үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр дээр ингээд өөр болоод ороод ирэхээр Аудитын газар юу гэж харж байгаа юм бэ? Би яах вэ боломжтой бүтсэн юмаа ярьж байгаа бол асуудаггүй л дээ. Ингээд юм нь ингээд өөрчлөгдөөд ирэхээр ер нь аудит энэ дээр ямаршуу байдлаар ханддаг юм бэ гэж асуумаар байна.

Р.Сэддорж: Хариулт 4 номер. Аудитынхан түрүүний асуултад бас хариулсангүй шүү дээ Алдаржавхлан гишүүний асуултад. Тэрийгээ хамтраад хариулчихаарай дараа нь.

Н.Мандуул: Гишүүний асуултад хариулъя. Тийм ээ энэ тодотголоос эхлээд ер нь ирэх жилүүдэд яг нийслэл дээр бол энэ томоохон бүтээн байгуулалтын хэд хэдэн том төслүүд төлөвлөж байна. Үүн дээр бол Туул голыг дагасан хурдны зам мөн түүнчлэн Go Mongolia гүүр, тэгээд туннел, тойрог

зам, метро, дүүжин тээвэр гэх мэтчилэн. Бид хэд яг энэ трасс нь бас яг тодорхой болоогүй байгаа учраас яг нарийн түгжрэлд хэрхэн нөлөөлөх талаар бол бас нарийн тоо бол байхгүй байна. Гэхдээ яг бүтнээр нь бүгд хэрэгжих юм бол түгжрэл 30-аас 50 хувиар буурна гэсэн тийм ерөнхий тооцоо бол байгаа.

Эдгээр том төслүүдийг бид бас хэрэгжүүлэхдээ өмнөх алдаануудаасаа суралцаад, тэгээд хамгийн гол нь яг олон улсын стандартад нийцчихсэн тийм хэлбэрээр явуулъя гэсэн байдлаар РМС буюу прожект менежмент компаниудтай хамтарч хяналтыг нь хамтран хийж ингэж явуулна гэсэн тийм төлөвлөгөөтэй байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Аудит 2 номер.

Я.Самбууням: Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Самбууням байна. Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Бид 2021 онд болбол МҮОХ-ны гүйцэтгэлийн аудит хийсэн байгаа. Энэ тайланг танд хүргүүлье.

Энэ оны хувьд болбол энэ Парис 2024 олимпод зарцуулсан зарцуулалтыг болбол 2024 оны Соёл, спортын сайдын төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар үзэх болно. Ингээд энэний тайланг болбол танд бас жичид нь хүргүүлье.

Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заагдсаны дагуу болбол бид нар улс төрийн намын мөрийн хөтөлбөрийг болбол баталгаажуулж, СЕХ-нд хүргүүлдэг байгаа. ЗГ-ын мөрийн хөтөлбөрт болбол бид нар аудит хийх эрх зүйн зохицуулалт байхгүй. Энэ удаагийн энэ төсвийн тодотгол дээр орж ирж байгаагийн хувьд болбол ганц улс төрийн намын биш 3 намын хамтарсан мөрийн хөтөлбөрт туссан энэ ЗГ-ын мөрийн хөтөлбөр байгаа учраас энд болбол бид аудит хийдэггүй.

Зүгээр 4 жилийн эцэст болбол ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт бидэнд нь болбол аудит хийдэг ийм зохицуулалт байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Тодруулах зүйл байгаа юу? Байхгүй байна тийм ээ. Батсүмбэрэл гишүүнийг энэ асуулт, хариулт хамт яваад байгаа шүү. Гишүүд нөгөө асуулт, хариулт хамт хэлээд байгаа учраас Батсүмбэрэл гишүүнийг нэмье. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Би хэдийгээр бас Эдийн засгийн байнгын хорооны гишүүн биш. Тэгэхдээ бас энэ дээр хамгийн чухал бас өнөөдрийн ЗГ-ын дэвшүүлж байгаа зорилтуудыг хэрэгжүүлэх суурь реформууд энэ Байнгын хороон дээр яригддаг. Тийм учраас бас орж ирж бас үгээ хэлье гэж байгаа юм. Ер нь бол энэ Төсвийн тодотголыг бол дэмжиж байгаа. Энэ зөвхөн Улаанбаатар хотын асуудлыг ишидэх гээд байгаа зүйл биш юм байгаа юм. Яах вэ үүгээр яригдаж байгаа томоохон төслүүд бол өнөөдөр бас Улаанбаатар хотын энэ нягтаршил ихтэй хэсгүүд дээр аюултай ачаа бараа бас хот дундуураа гардаг энэ нөхцөл байдал бол дэд бүтцийн хувьд бол бүрдчихээд байгаа. Үүнээс урьдчилан сэргийлэх Туулын хурдны зам ч байдаг юм уу, цаашидаа энэ Дарханаас орж ирж байгаа замыгаа шууд Хөшигийн хөндий, цаашилаад Дундговийн замтай холбох. Энэ уул уурхай, нефтийн, газрын бүтээгдэхүүнүүд шууд хот дундуур орохгүйгээр гарах энэ бололцоонуудыг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтуудыг бас эхнээс нь тавьж байгаа нь бас 1 дүгээрт энэ Улаанбаатар хотын гэлтгүй энэ бол амьдарч байгаа иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг бас хангах томоохон хөрөнгө оруулалтын суурь эхлэлүүд тавигдаж байна гэж бас ойлгож байгаа.

2 дугаарт энэ томоохон төслүүдийн цаана бол энэ Төв аймгийн сэргэлтийн асуудал бас яригдана. Энэ

Төв аймгийн Зуунмод хотын бүтээн байгуулалтын ажлууд эрчимжих, эндэх газрын үнэ цэн өсөх, энд хөрөнгө оруулалтууд орж ирэх энэ таатай нөхцөлүүд бүрдэнэ. Төв аймагт бол Хөшигийн хөндийг дагаад томоохон бүтээн байгуулалтууд хэрэгжих нөхцөлүүд бол бүрдчихээд байна. ЗГ бас өнгөрсөн хугацаанд би бас тоог нь андуурч байж магадгүй 500-гаад тэрбум төгрөгийн бас дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг Хөшигийн хөндий рүү үе шаттайгаар оруулж байгаа. Энийгээ бодох юм бол энэ өнөөдрийн төсвийн тодотголоор орж ирж байгаа энэ бүтээн байгуулалтууд бол үүнийг дэмжсэн ийм хөрөнгө оруулалтууд орж ирж байна гэдэг зүйл дээр бол би ойлгож дэмжиж байгаа юм.

Жавхлан сайдаас нэг асуулт байгаа. Түрүүн сая Бадамсүрэн гишүүн бас асууж байна. Энэ тамын 50 ч гэдэг юм уу. Ерөнхийдөө бүс нутгаараа хөгжих асуудлыг зөвхөн татварын бодлого гэхгүйгээр буцаад энэ татварын орлогыг хуваарилалт дээр бас хийж болох уу? Жишээ нь Өмнөговь аймаг бол бас тодорхой хэмжээний мөнгөтэй, орлого бүрдчихээд байхад Дундговь нь жишээ нь орлого байхгүй. Тэгэхдээ Дундговийн замаар бол жинхэнэ Өмнөговийн ачаа бараа, хүн мал явж байгаа. Тэнд нэг автобусанд нэг уурхайн бүтэн shift явж байгаа байхгүй юу ээлж. Энэ өөрөө эргээд том эрсдэл. Тэгэхээр энийг жишээ нь замыг барих асуудлыг Өмнөговь, Дундговь аймаг зөвшилцөж, иргэдийн хурлууд нь зөвшөөрсөн тохиолдолд бас энэ хуваарилалтыг бас уялдуулж болох уу гэдэг асуудал дээр бас Жавхлан сайдаас би асуумаар байгаа юм. Энийг зүгээр энэ удаад хөндөөгүй ч цаашидаа бас энэ байдлаараа бүс нутгаараа хамтарч асуудлаа шийдэх гарц, гаргалгаа байж болох уу гэдэг дээр бас хариулж өгөөч гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт яах вэ энэ чадавхыг суурилсан худалдан авалтын ажлыг, 1

минутаа гүйцээгээд аваад нэгмөсөн асуучихъя гэж бодож байгаа юм. Хүмүүс шүүмжлээд шууд худалдан авалт гэж андуураад байна. Би яах вэ зүгээр яг л хэлмээр байгаа юм. Манай энэ залуу гишүүд бас юмаа уншаасай, битгий бас энэ хэт улс төр хийж попордог хүнийг дагаж, ерөөсөө нэг ийм юманд битгий өнгөц хандаасай.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут гэж, хариултаа авсны дараа тодруулгын 2 минут байгаа юм байна. Жавхлан сайд хариулах уу? Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Энд нэг хэд хэдэн ойлголт байна. Сайнзориг гишүүн Монгол Улс өөрөө бид нэгдмэл улсын төсвийн болон хөгжлийн бодлоготой явдаг гэдгийг сайн мэддэг хүн. Яах вэ бид бүсчилсэн хөгжлийн ийм загвар луугаа шилжиж байна. Тэглээ гээд бүсийн төсөв гэж бас байхгүй. Төсвийн бодлоготой болбол энэ нь биш шүү.

Дээрээс нь 6 аймаг байгаа юм. Өмнөговь, Орхон, Дорноговь, Дархан, Сэлэнгэ гээд ийм 6 аймаг. Монгол Улсад төсөвт төвлөрүүлдэг томоохон ААН-үүдийнх нь 40 хувийг нь Татварын ерөнхий газраас буцааж эндээс улсаас хуваарилж тавьдаг. Тэгээд илүү гарсныг нь бараг буцааж авдаг гээд бараг нэг илүү илүү ийм үйлдлүүд хийгддэг нэг ийм шинэ зохицуулалт Нэгжсийн тухай хуулиар ийм юм орчихсон юм. ЗГ дээрээс бол энийг өргөн бариагүй л дээ.

Тэрэн дотроос юу гэдэг юм аймаг хооронд төсөв шилжүүлнэ гэдэг ойлголт бүүр байхгүй, бүүр байхгүй. Орхон-Уул аймгийн Эрдэнэт үйлдвэртэй холбоотой энэ баялаг бол ард түмний баялаг, Орхончуудын баялаг биш, хойд бүсийн баялаг биш. Өмнөговь аймгийн байгалийн баялаг бүс нутгийн баялаг биш, нэг аймгийн баялаг биш, энэ Монголын ард түмний баялаг юм байгаа юм. Тэгэхээр орлого төвлөрүүлдгээрээ улсын төсөв

дээрээ нэгдсэн байдлаар төвлөрүүлнэ. Харин буцаагаад зарцуулалт хуваарилалт хийхдээ таны ярьсан сая тэр Дорноговийн зам нь дамжин өнгөрч Өмнөговьд очиж байгаа бүс нутгийн ийм өндөр ач холбогдолтой зам болбол Өмнөговьд хуваарилах биш Монгол Улсын нэгдсэн төсвөөс чиглэлийн яамных нь бодлогын дагуу хуваарилах энэ процессоороо л явагдах юм байгаа юм. Тэрнээс аймаг хооронд дундаа сууж байгаад 2 аймгийн иргэдийн хурал нийлж сууж байгаад ингээд найрлаж байгаад хоорондоо төсвөө шилжүүлдэг гэдэг тийм ойлголт бол байж болохгүй юм тийм. Баярлалаа.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн 2 минут тодруулга.

П.Сайнзориг: Жавхлан сайдаа би бол ойлгож байна. Тийм тэгээд газрын баялаг бол нийт ард түмний өмч учраас магадгүй өнөөдөр Өмнөговь аймаг дээр ААНОАТ-ын 30 хувийг буцаалт дээрээ энэ 40 тийм ээ, энэ буцаалт дээрээ энэ асуудал нь Өмнөговьчуудад бас нийгэм, эдийн засгийн хувьд асуудал чухал байна гэж үзвэл би жишээ авч байгаа шүү. Одоо бас Сэддорж дарга бас ойлгож байгаа байх тойргийн гишүүн, гэж байгаа бол энэ 40 хувиас нь багасгаж төвлөрүүлээд улсын төсөв дээрээ үлдээх үү эсвэл хаана нь шилжүүлэх вэ гэдэг зүйлийг шийдэж болохгүй юм уу?

Тэгэхгүй ингээд яг үнэндээ хэлэхэд бас зарим аймаг нь бол мөнгөтэй, наадмын далбаагаа бариад ч юм уу ингээд л явж л байгаа байхгүй юу. Тэгтэл Дундговийн замаар чинь яг Өмнөговийн ачаа бараа, аюултай ачаа бараа яваад байдаг. Улсын төсвөөс тэрийг хийнэ гээд явахаар яг эрэмбийн хувьд алслагдчихаад байдаг. Тэр орон нутагт хуваарилж байгаа ААНОАТ-ын тодорхой хувиар нь бас шийдлүүд байж болох уу гэдэг зүйлийг би зүгээр судалж үзээсэй. Энэ удаад хөндөж байгаа юм биш шүү. 1 дүгээрт ийм байгаа юм.

2 дугаарт энэ чадавхад суурилсан энэ худалдан авах ажиллагааны асуудлыг бас энэ шууд худалдан авалт биш гэдэг зүйлийг хэлмээр байна. Бид хэд худалдан авах ажиллагааны олон төрлүүдийг ерөөсөө хуульчилж ирээгүй орхигдуулсан. Зөвхөн бага үнийн дүнтэй энэ зүйлүүд дээр төвлөрч ирээд, энийгээ л зөвхөн тендер гэдэг зүйлээр ойлгоод байх шиг байна. Гэтэл өнөөдөр яг энэ бага үнийн дүнтэй саналыг тулгуурлаж энэ тендер сонгон шалгаруулалт явж байгаа нь цүнхний компаниуд орж ирэх, эргээд энэ төслүүдийг гацаах, энэ шалгараагүй компаниуд нь шалгарсан компани дээр шантайж хийж шүүхдэх, ажлыг удаашируулах шантайж тавьдаг, тодорхой хувиудыг нь хүртэл нэхдэг ийм практикууд гарч байгаа шүү дээ.

Дээрээс нь үүгээр бол томоохон төслүүдийг хийх ямар ч бололцоогүй юм байна лээ. Тэгэхээр энэ зүйлүүдийг нь бодолцож, харин юу гэдэг юм ямар ч төрийн зохицуулалтууд эрсдэлүүд угаасаа байгаа. Энэнээс бид хэд урьдчилан сэргийлж, ил тод болгох, эргээд энэ томоохон төслүүдээ явах энэ Улсын Их Хурлын хяналтыг нь бүрдүүлэх үүднээс магадгүй төсөв хэлэлцэхээр тэр хөрөнгө оруулалтын жагсаалт дээр чадавхад суурилсан байдлаар энэ, энэ төслийг явуулна гэдгээ тухайлан заагаад ороод ирвэл Улсын Их Хурал нь ингээд батлаад явдаг байдлаар тодруулаад зохицуулаад явж болох зүйлүүд байна. Тэгэхээр энэ зүйлүүдийг бас.../минут дуусав/

Р.Сэддорж: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Сайнзориг гишүүнд баярлалаа. Тэр Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулийг их зөв тайлбарлалаа 1 дүгээрт.

2 дугаарт тэр татварын асуудлыг ер нь яах вэ таны санааг би ойлгоод л байна. Яг хоёулаа очих цэг нь бол санаа нийлээд байгаа юм. Одоо ингээд нэг зарим нэг түрүүний хэлсэн

зургаахан аймаг дээр энэ том стратегийн ордууд байдаг. Тэгээд нэгжийн хууль, татварын хууль энэ татварын хууль 2 энэ дээр зөрөөд байгаа байхгүй юу Сайнзориг гишүүнээ. Сайнзориг гишүүнээ би танд мэдээлэл өгөөд байна шүү дээ. Татварын хууль, нэгжийн хууль 2 чинь зөрөөд байгаа юм энэ дээр.

Нэгжийн хуулиараа болохоор 40 хувийг нь буцааж тавина гээд, буцааж төвлөрүүлэхийг нь бол Татварын хууль дээр давсан орлого буюу суурь зардлынх нь 70 хувийнх нь аль бага дүнгээр нь аймагт нь үлдээгээд, бусдыг нь татдаг ийм татварын хуультай байхгүй юу. Тэгэхээр нэг сонин 40 хувийг нь хуваарилаад байгаа юм шиг мөртөө татварын хуулиараа буцаагаад шууд автомат татчихдаг ийм зохицуулалттай явж байгаа юм.

Тэгэхээр яах вэ миний цаашидаа шийдэл болбол нэгэнт энэ чинь ард түмний баялаг учраас 40 хувийг нь орон нутагт буцааж төвлөрүүлж ингэж төөрүүлэхгүйгээр улсын нэгдсэн төсөв дээрээ хуучнаараа төвлөрүүлдгээрээ төвлөрүүлээд, харин буцаагаад хуваарилалтаа Төсвийн хуулийн дагуу хуваарилдаг л ийм л буцаад болчихмоор байгаа юм. Зөвхөн стратегийн ордууд дээр шүү. Тэр стратегийн орд гэдгийгээ харин жагсаалтаа Их Хурал дээр батлаад, бүгдээрээ олон нийтийн өмнө, ард түмний өмнө энийгээ ил аль аль талдаа хүлээн зөвшөөрөөд жагсаалтаа гаргачихмаар юм байна лээ.

Р.Сэддорж: Сүүлийн хэдэн өдөр ингээд юу яалаа, Жавхлан сайдаас олон хүн асуусан. Говийн бүс нутаг чинь 7 Их Хурлын гишүүнтэй. Тэр Их Хурлын гишүүнийг үг хэлэх, асуух асуултыг бол би бусад зургаагаа бол мэдэхгүй. Тэгээд хариулт бол над руу харж байгаад хэлээд байгаа юм энэ Сэддорж сайн мэднэ дээ гээд л. Тэгээд бол яах вэ ерөнхийдөө бол олон жил ярьсан энэ татварын сая 40 хувийг шилжүүлдэг аймаг руу

шилжүүлдэг асуудал бол ард түмнийг бол баярлуулж байгаа. Буцаагаад татахаар нь бол гонсойлгож байгаа. Тэгээд энэ тэр уурхай байгаа газрын байгаль орчин доройтож байгаа, бэлчээргүй болж байгаа, тоосжилтод өртөж байгаа ард түмэнд юу ч үлдээхгүй буцаагаад татна гэхээр бол ард түмэн бол ёстой ойлгохгүй. Тэгээд энэ дээр Жавхлан сайд 25 оны төсөв дээр бас бодож байгаа байлгүй.

Цахилгаан станцыг бол та энийгээ шийднэ гэж хэлсэн. Тэгээд бусад асуудлуудыг бол шууд Монгол Улс нэг улс гэдгийг мэдэхгүй хүн гэж байхгүй шүү дээ. Тэгээд тэр зовсон ядарсан ард түмнийг алтыг нь аваад авдрыг нь бас үлдээгээд, ингээд тэн дээрээ бас нэг бас бодолтой байвал. Тэгээд орон нутагт ямар боломжууд байна гэдгийг сайд та хэлээд өгчихвөл энэ Их Хурлын гишүүд бас тайвширах байх. Бонд гаргаж болох уу? Тэгээд нийслэл болж байгаа юм чинь сүүлийн 2 жил улсад төвлөрүүлсэн аймаг бонд гаргаж болох бол энийг нь сайхан хэлээд өгчихвөл тэр гишүүд тайвширах байх.

Сайнзориг гишүүнтэй бол би гишүүнийхээ хувьд бол бас яг хуулиар ингэж үг, үсэгчлэн орохгүй ч гэсэн тэр бүс нутаг руу чиглэж байгаа тэр замын засварын ажил дээр тэрийг нь шийдээд өгвөл энэ маш л зөв л санаа яваад байгаа юм. Тэгээд бас сайд та бас тэр цаад уулзах үзүүр нь бол нэг байна. Тэгээд арга замаа хэдүүлээ ярилцъя гэж байгаад баярлалаа. Тэгээд би бол хувь хүний, гишүүнийхээ хувьд үгээ хэллээ. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Тэр нөгөө аудитын нөхрөөс асууя. Энэ эдийн засгийн үр өгөөжийн тухай яриад байгаа нь их зөв байна. Эдийн засгийн татаас ихтэй, ач холбогдол муутай 20 дугаар зууны хөгжлөөр үлдчихсэн энэ сумуудыг татан буулгах хэрэгтэй байна, нэгтгэх хэрэгтэй байна аймгуудыг. Ер нь бол Монгол Улсад 330 сум суурин хэрэгтэй

юм уу, 150 байвал яадаг юм. 21 аймаг хэрэгтэй юм уу хөгжлийн төвөө дагасан 10 аймаг хэрэгтэй юм уу? Энэ дээр эдийн засгийн талаас нь аудитын дүгнэлт хийсэн юм байгаа юу? Энэ дээр хариулт өгөөч 1.

2-т нь Жавхлан сайдаас асууя. Тэр 6 сарын 5-ны хуулийн өөрчлөлтийн асуудал яригдаад байгаа, маш ноцтой асуудал шүү. Бид нар таазгүй болчихсон, шалгүй болчихсон. Тэгээд тааз, шалгүй болно гэдэг бол хязгааргүй боллоо гэсэн үг. Тэгээд тэр 6 сарын 5-ны асуудлыг хэн өргөн барьсан юм, хэрхэн хэлэлцсэн юм, хэн дэмжсэн юм, энэ асуудлыг ил болгож өгөөч. Бидэнд мэдээлэл өгчих. Одоо энэ сая сууж байгаад харсан нөхөр Цогтгэрэл ямар байр суурьтай байсан юм тэрийг мэдмээр байна шүү дээ. Ийм асуудал байна.

Тэр Барилгын яамны нөхөр байх шиг байсан тийм ээ. Улаанбаатар хотод хөгжлийн асуудал бол гэр хорооллыг орон сууцжуулах асуудал шүү. Тэгээд энэ ажлыг хиймээр байгаа. Тэгээд бодвол тэр Барилгын сайд бол дээр нэг уулзалт дээр бол юмаа ойлгохгүй явж байна лээ. Тэр нөхөртөө сайн хэлэх хэрэгтэй. Улаанбаатар хотыг бол барилгажуулж байж, шороо тоосноос нь, жорлонгоос нь, яндангаас нь салгана, өөр арга байхгүй. Гэрэл, камертай болгох энэ тэр. Тэгээд энийг та нар яаж хийх гэж байна вэ? Хотын дарга ганцаараа зүтгээд байгаа зайлуул хараад байхад ерөөсөө бүх юм руу орж байна. Тэнд үер болно гүйгээд оччихсон байна. Тэнд байшин барина яваад очно. Тэр барилгын сайдад энэ хот хамаагүй юм уу тэр нөхөр хаана явна вэ?

Тэгээд сураг сонсоод байхад нэг баахан халаа сэлгээд л яриад байгаа сурагтай байгаад байгаа. Төрийн албан хаагч нар бол төрд тангараг өргөсөн, амьдралынхаа төлөө зүтгэж байгаа хүмүүс. Энийг анхаарч ажиллаарай.

Тэгээд Барилгын яам хотын Сэлбэ хороололтой хэрхэн ажиллаж байна вэ? 2250 айлын газрыг нь чөлөөлж, 2250 жорлонг буулгаж, 2250 янданг буулгаж, энэ Улаанбаатар хотод бас нэг хойд бүсийн утаа жорлонгийн бохирьг цэгцэлье гээд хотын дарга яваад байгаа юм. Энийг Барилгын яам дэмжиж байгаа юм уу, дэмжихгүй байгаа юм уу? Ил гараад энийгээ дэмжиж байна, дэмжихгүй байна мэдэгдэх хэрэгтэй шүү. Энийг би Байнгын хорооны энэ хурал дээр сонсьё гэж бодож байна тэр ТНБД-ын үүрэг гүйцэтгэгчээс. Тэгээд тэр сайддаа хэлээрэй, энийг тэр сайдад заавал хэлэх ёстой шүү. Ер нь дэмжээд байгаа юм уу, дэмжихгүй байгаа юм уу? 20 минутын хотын сайд сая орж ирээд гарна лээ. Би түрүүн хэлсэн Дундговиос өөр шүү энэ Улаанбаатарын хотын асуудал бол. Тэгээд битгий хөдөөгөөр сэтгээд байгаарай.

Р.Сэددорж: Хариулт. Сангийн сайд Жавхлан сайд.

Б.Жавхлан: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Тийм ээ тэр асуудал ер нь их эмзэг асуудал болчихоод байгаа юм. Төрийн төв хэвлэл дээр гараад мөн төрийн энэ вебүүд дээр гараад л бид нар энэ мэдээллийг сонссон юм. 6 сарын 5-нд яг эд нөгөө буужигнаад сонгууль эхлэхийн өмнөхөн нэлээн олон хуулиуд нэг дор батлагдсан тэр үеэр л гараад явчихсан байна лээ. Яг хүний зүгээр хувь хүний ёс зүйн хувьд тэр энэ тэгчихсэн ингэчихсэн гэж зарлаад байх нь зүгээр зохимжгүй байна. Уучлаарай гишүүнээ. Та өөрөө эрх бүхий хүн. Энийг Улсын Их Хурлын Тамгын газраас асуухад бол дор нь л гаргаад өгөх байх. Улсын Их Хурлын гишүүн хэн ч байсан гэсэн хууль өргөн барих эрхтэй, хамтрах эрхтэй. Тэгээд гишүүд энийг хамтраад өргөн барьсан юм байна лээ.

Зүгээр тэнд нэг эмзэглэж байгаа миний 2 асуудал байгаа юм. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэдэг болбол энэ ЗГ-ын хувьд бол маш том

суурь хууль. Сангийн яам энэ төсвийн бодлогын хувьд бол үндсэндээ Үндсэн хууль нь. Энэ дээр маш том бодлогын ийм өөрчлөлт оруулах гэж байж ЗГ-аасаа Сангийн яамнаасаа ядаж санал авчихсан болбол одоо тэр улсууд хэлэх үгтэй байхгүй юу. Бид нар ч гэсэн хэлэх үгтэй. Гэтэл яг энэ өөрчлөлтийг бид нараас санал аваагүй, санал авахаар ирсэн 3 хуудас материал дотор нь яг тэр заалт нь байгаагүй, өргөн барихдаа цоо шинээр өргөн барцулаад, яг тэрэн дээр ЗГ-аас санал аваагүй ингээд явуулчихсан. Санал авхуулах гээд ирсэн зүйлүүд дотор нь тэр нь байгаагүй хэдий ч нэг ч саналыг нь ЗГ-аас зөвшөөрөөгүй. Бид дэмжихгүй гээд санал явуулсан байхгүй юу ЗГ дээрээ хуралдаад бид шийдээд. Гэтэл ингээд зүтгүүлсээр байгаад оруулаад ирсэн.

Дараагийн миний эмзэглээд байгаа асуудал Төсвийн тогтвортой байдлын зөвлөл байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энийг мэдээгүй байна гэж байхгүй. 2 заалт нь 2 хязгаар нь байхгүй болчихоод байхад дараа нь харин энийг нь засах гээд оруулж ирсэн ЗГ-ын саналыг дүгнэлт гаргаад ингээд явчихсан. Өөрөөр хэлбэл нөгөө 6 сарын 5-нд орсон өөрчлөлтийг огт байхгүй юм шиг тэрэн дээр нэмж өргөн барьсан төсвийн тодотгол дээр дүгнэлт хийгээд явчихсан байгаа байхгүй юу. Тэр орсон өөрчлөлтийнх нь суурин дээрээс нь харсан болбол ЗГ-ын өргөн барьсан энэ хувилбар чинь сайжруулж орж ирж байгаа байхгүй юу, хамаагүй илүү сайжруулж орж ирнэ. Нөгөө 2 хязгаарыг чинь буцаагаад оруулж ирж байгаа ийм зохицуулалтууд байгаа юм. Тэрийг одоо тэгээд хууль, эрх зүйн зөрчил, эрх зүйн техникийн алдаа ч гэдэг юм уу ийм байдлаар яриад эхэлнэ. Тэр нь ч дүүрч, ямар ч байсан яаралтай энийгээ буцааж тавьж, засвараа хийх нь Монгол орны нийтлэг эрх ашигт нийцнэ л гэж ингээж харж байгаа юм. Тийм баярлалаа.

Р.Сэддорж: Аудит 2 номер.

Я.Самбууням: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Самбууням Үндэсний Аудитын газар. Төсөв захирагчийнх нь хувьд болбол сумдын үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд болбол бид жил бүхэн аудитыг хийдэг. Гэхдээ энэ сумдын ач холбогдлоор нь болбол эрэмбэлж ингэж нэгтгэх, нийлүүлэх талаар болбол аудит хийж байгаагүй. Энэ нь болбол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулиараа болбол тусдаа статустай зохицуулалттай байх. Баярлалаа.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн тодруулах зүйл байгаа юу? Барилгын яам 1 номер. ТНБД үүрэг гүйцэтгэгч Төмөрхүү.

С.Төмөрхүү: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Барилгын яам Улаанбаатар хотыг орон сууцжуулах, гэр хорооллын иргэдийг ая тухтай амьдрах чиглэлээр мэдээж нийслэл хоттойгоо болон 20 минутын хот сайдтай, сайдын ажлын албатай бол нягт хамтран ажиллана. Энэ чиглэлээр мөн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт хашаандаа сайхан амьдаръя хөтөлбөр, гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцад барьсан тохиолдолд үзүүлэх дэмжлэгийн талаар, мөн орон сууцын, Орон сууцжуулалтын тухай хуулийг Улсын Их Хурлын намрын чуулганд хэлэлцүүлэхээр мөн бэлтгэж өргөн барихад бэлэн болгоод байгаа. Таны хэлсэн саналыг сайддаа уламжилъя.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн тодруулга.

Н.Батсүмбэрэл: Аудит сая тэр сумдыг ач холбогдлоор нь, аймгуудыг эдийн засгийн үр өгөөжөөр нь орчин үеийн эдийн засгийн шаардлагаар нь дүгнэлт гаргаж болох уу, тэгээд энийг хийх үү? Аудит энэ дээр тодорхой хариулт өгмөөр байна. Нэг бөөрөнхий дөрвөлжин ч юм шиг, дугуй ч юм шиг юм яримааргүй байна. Тодорхой юм яримаар

байна. Гурвалжин бол гурвалжин, дөрвөлжин бол дөрвөлжин нэг.

2-т нь Жавхлан сайд 3 сонгогдсон хүн бас адилхан гишүүн. Тэгээд энийг ер нь гаргаад тавих хэрэгтэй. Тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хүн байна уу, энэ дээр хариулах хэрэгтэй. Тэгээд энэ яагаад өрийн таазгүй болгочихдог юм, яагаад шалгүй болгочихдог юм бэ, эдийн засгийн эрсдэлүүдийг яагаад нэмэгдүүлээд байгаа юм энэ асуудлыг ярих хэрэгтэй шүү дээ. Хөнжил дотроо хууль хулгайлдаг бол сонгууль дундуур хууль хулгайлчихсан байна. Хэн хулгайлсан юм бэ? Санаачилсан хүн нь. Хэн дэмжсэн юм бэ? Яагаад улс орноо хохироогоод байгаа юм бэ?

Өөрөөр хэлбэл 100 төгрөгийн орлоготой өрх 300 төгрөгийн өртэй болбол гадаад улс орны нэр хүнд яах вэ? Яагаад ийм хохиролтой юм хийгээд байгаа юм бэ нэг. Энийг тодорхой хэлж өгөөч. Тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд яриад байгаа нөхдүүд хариулт байвал хариулчихмаар байна.

Барилгын яам тэр хотын даргын асуудлыг дэмжмээр байна. Нямбаатар дарга ганцаараа явж байна шүү. Тэгээд Барилгын яам хажууд нь хань бараа болоод тэр хот 20 минутын хотын сайд тэр танай сайд чинь хэн билээ дээ, тэр нөхөр 3, хоёр явах хэрэгтэй шүү дээ. Тэгээд хамт яваад тэр 2250 айлыг дэмжээд 5000 болгодог ч юм уу яадаг ч юм тийм ээ. 2250 айлыг чөлөөлж 12 мянган айлын орон сууц барих юм байна лээ шүү. Сэлбэ хорооллыг дагаж тэр Дэнжийн мянга, Зурагт, Чингэлтэй, Хайлааст, Дамбадаржаа, Сэлх, Бэлхийн гэр хорооллын айлууд орон сууцад орох юм байна лээ шүү. Энийг Барилгын яам сайн уншаад, ойлгоод дэмжээд яваарай гэж би хэлье.

Р.Сэддорж: Хариулт байгаа юу? 2 номер.

Я.Самбууням: Төрийн аудитын байгууллагаас хийж гүйцэтгэх аудитын сэдвийг Төсвийн байнгын хороогоор баталдаг. Яг энэ аудитын сэдвийн үндэслэлийг нь гаргаад гишүүн та бас сэдвийн үндэслэлийг нь гаргах юм болбол бид дараа жилийн хийгдэх аудитын сэдэвтээ оруулаад аудит хийх бололцоотой. Судалж үзээд баярлалаа.

Р.Сэддорж: Өөр хариулт байна уу, болчихсон уу? Жавхлан сайд хариулах юм уу үгүй юу? Жавхлан сайдын микрофоныг.

Б.Жавхлан: Би өмнөх гэхдээ таны асуултад нэмэлт мэдээлэл өгөх гээд байна. Ер нь байгаа Өрийн удирдлагын тухай хуулиар бол аймгууд орон нутгууд бонд гаргаж болохоор, үнэт цаас гаргаж болохоор байгаа. Тэр зохицуулалтын хүрээнд нийслэл гаргаж байгаа. Тэгэхдээ тодорхой хэмжээний бол босготой. Тэр босго шаардлагыг биелүүлсэн аймгууд болбол болно. Тийм. Ялангуяа Өмнөговь аймаг болбол ер нь нийслэлийн ард бусад аймгуудаас ер нь их ойрхон зогсож байгаа потенциалын л аймгийн нэг л дээ. Тийм. Тэр талаар тэгээд дараа дараагийн төсвүүд дээр бодлогоо нийлүүлж ярилцах хэрэгтэй л болж таарах байх даа. Тийм.

Р.Сэддорж: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх бол хамт хэлчихсэн гэж үзэж байгаа. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Гараа өргөө. Батнайрамдал арай түрүүлж өргөсөн үү? Батнайрамдал гишүүн. Та 2

шийдчих. Энхтүвшин гишүүн үү? Ингээд Төсвийн байнгын хорооны хуралд Энхтүвшин гишүүн уншиж танилцуулна. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

13.26 цаг

Гурав.Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрийн өмчийг Нийслэлийн өмчид шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Дараагийн асуудалдаа оръё. Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг танилцуулъя, оруулъя. Ажлын хэсэг хэвээрээ юм байна. Ажлын хэсэг хэвээрээ гэж мэдэгдэж байна. Ажлын хэсгийг орохыг орж ирэхийг урьж байна. Төр, хувийн

хэвшлийн түншилэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Жаргалан гишүүнээр тасаллаа. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн.

Ч.Лодойсамбуу: Баярлалаа. Би Жавхлан сайдтай болбол 3 цагаар 2 удаа ярилцлага хийсэн. Ер нь асуултад ярьж хариулдаг вэ, ямар тактик хэрэглэдэг вэ гэдгийг мэднэ л дээ. Манай Жавхлан сайд бол заримдаа жоохон заль гаргаад ямар ч байсан нэг аргалаад өнгөрнө гэдэг тактик баримталдаг. Тэгээд энэ дагаж орж ирж байгаа Тендерийн хууль, Хувийн хэвшлийн түншилэлийн тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хууль дээр гарч байгаа өөрчлөлтүүд дээр чинь яалт ч үгүй л таны хэлээд байгаа тэр шууд гэрээ гэж шууд бичээгүй ч гэсэн шууд гэрээ байгуулах нөхцөл нь үүсчихсэн л байгаа байхгүй юу. 37.1.3 дээр нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг хэвийн тасралтгүй хангах нэн яаралтай нөхцөл үүссэн шалтгаанаар энэ хуульд зааснаар аргаар төслийг зарлаж, сонгон шалгаруулах хугацааг мөрдөх боломжгүй.

Өөрөөр хэлэх юм бол компанид урилга явуулаад нэн яаралтай хийх ажил юм тийм учраас 2 хүртэл компанид урилга явуулаад нөгөө хоёроосоо сонгон шалгаруулна гэдэг чинь урилга явуулж байхдаа л сонгон шалгаруулалт нь болоод дуусчихсан байна шүү дээ. Тэгээд энийг шууд гэрээ байгуулна гэж заавал бичихгүйгээр хэлж ойлгох. Энийг болбол тэгэхдээ эсэргүүцээд байгаа юм биш Сангийн сайдаа. Ер нь болбол ажил яаралтай явах шаардлагатай. Худалдан авах ажиллагаа, ер нь ажил гүйцэтгүүлэх энэ ажил дээр болбол асуудлууд үүсдэг. Энийг хурдан хийх шаардлага гардаг. Гэхдээ эргээд яг та нарын зориод байгаа ажлаас чинь хойш энэ хууль хэрэгжихдээ юм болгон энэ хуулиар явдаг болчих вий дээ л гэж айгаад байгаа шүү дээ. Тэр Тендерийн

хууль дээр чадавхад суурилсан гээд. Хэнийг чадавхтай вэ, чадавхгүй вэ гэдгийг төрийн яам, мэргэжлийн холбоод нь хамтарч байгаад чадавхын оноо гэж хийгээд, тэр оноогоор дамжуулаад, чадавхаар нь эрэмбэлээд ажил хийлгэх гэж байна гэдэг чинь бас л ялгаагүй. Энэ том том мега төслүүдийг хэрэгжүүлнэ, эхлүүлнэ, ямар ч байсан ажил хийнэ гэж байгааг чинь ойлгож байгаа. Энийг бол дэмжиж байгаа.

Гэхдээ нөгөө талдаа энэ хууль чинь цаашидаа шууд бүх юмыг яг энэ чадавхад зориулсан гэдгээр нь оруулаад явчих эрсдэл байхгүй юу л гэж асуугаад байгаа шүү дээ? Эрсдэл байхгүй. Сая Сайнзориг гишүүн болбол тодорхой хэлж байна. Эрсдэл гарна. Энэ эрсдэлийг нь харин яаж багасгах вэ гэдгийг хэдүүлээ илүү ярилцах нь зүйтэй гэж байгаа. Хариулахаар нь тодруулга асууя.

Р.Сэддорж: Эхлээд бол энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцохыг хэлэлцэж байгаа юм байна. Хэлэлцэж байгаа. 2-т нь бол тэр нэмэлт, өөрчлөлт дээр сая асуулт асуулаа. Одоо яах билээ? Шууд эхлээд хүчингүй болсон дээр яг дарааллаар л явах юм байна л даа. Лодойсамбуу гишүүний асуултад Жавхлан сайд. Холилдоод л явчихлаа л даа. Ингээд шууд хариулъя Жавхлан сайд.

Б.Жавхлан: Лодойсамбуу гишүүний асуултад хариулъя. Би шууд тэр сүүлд эрсдэл гээд тодруулсан тэрийг, тэр хэсгийг чинь л энэ асуулт гэж ойлголоо шүү дээ тийм ээ, зальдаагүй биз дээ. Тэр эрсдэлийг бол ингээд бууруулчихмаар байгаа юм байна. Гишүүд бас нэг хуульч гишүүн хэлж байсан. Наадах дотор чинь уг нь бүтэн уншвал нэг ийм байгаа шүү дээ. Энэ аргачлалыг нь хэрэглэх жагсаалтыг ЗГ өөрөө батална гэж байгаа юм. Хэрвээ тэрэн дээр хардаад байвал Их Хурлаар баталдаг болгоод тэрийг нь өөрчилчихвөл ЗГ бол тэрийг бол

зөвшөөрөхөд бэлэн байна. Дэмжээд явахад. Их Хурал гаргасан 10, 20 хэдэн мэдэхгүй яг зөвхөн энэ төслүүд дээр л энэ аргыг хэрэглэнэ гээд л Их Хурал дээр үүнийг хэлэлцээд, тогтоолоор батлаад гаргачихад явахад бол ямар ч хардалт байхгүй. Та өөрөө тэнд нь оролцоод, эрэмбэлээд тэгээд л гарчихвал бидэнд хууль ямар ч хардалт сэрдэлт байхгүй. Та бараг өөрөө тэр зарчмын зөрүүтэй санал гаргаад явчихад бол бид нар дэмжээд л явна.

Р.Сэддорж: 1 дүгээрт.../үг тасрав/

Б.Жавхлан: Хууль зүйн техникийн хувьд манай Батзул дарга тайлбарлачихъя. Нийслэлийнхэн хэлэх юм уу.

Р.Сэддорж: Юу яая яг Дэгийн тухай хуулиараа явъя, явах юм байна. Одоо энэ хүчингүй болсонд тооцох тухай заалтыг хэлэлцэж байгаа. Ингээд Жаргалан гишүүн. Одоо ингээд дахиад явах юм байна, яг үүгээр чинь. Жаргалан гишүүн дараагийнх дээр нь юм уу?

Б.Жаргалан: Дараагийнх дээр нь асууя. Тийм.

Р.Сэддорж: Ингээд гишүүд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай төслийн 1 дүгээр зүйлтэй гишүүд асуулт асууж, санал хариулж дууслаа. Ингээд зарчмын зөрүүтэй санал байна уу? Хүчингүй болсонд тооцох тухай энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй. Санал байхгүй байна. Саяын хүчингүй болсон дээр үү? Тэр арай болоогүй байна. Тийм. Ингээд хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл дээр зарчмын зөрүүтэй санал алга байна гэж үзлээ.

Ингээд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим

зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Дараагийн хууль дээр юм байна шүү гишүүд андуураад байгаа байх. Нөгөө нэмэлт, өөрчлөлт чинь дараагийн юун дээр юм байна. Хүчингүй болсон нь одоо ингээд дуусаж байгаа хэлэлцээд. Мөн үү, хүчингүй болсон дээр Уянга гишүүн байгаа юм уу? Жаргалан гишүүн байхгүй тийм ээ, буцаагаад авчих наадхаа. Ингээд асуух асуулт асууж, хариулт дууссаны, дууслаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал байна уу? Алга байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг хэлэлцэж дууслаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж, явуулъя, явуулж эхэлье. Ажлын хэсэг хэвээрээ байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Одоо асуух асуултуудаа. Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Лодойсамбуу гишүүн одоо хариултаа авна шүү дээ та. Лодойсамбуу гишүүний асуултад эхлээд хариулчихъя. Нийслэлээс үү? Нийслэлээс, 4 номер.

Н.Мандуул: Энэ Тендерийн хууль дээр Жавхлан сайдын энэ хэлсэн юуг нь дэмжиж байгаа юм. Тэр хардлага сэрдлэг болоод байвал тэгээд Их Хурлаараа жагсаалтаа батлаад тэгээд, тийм үү? Төр, хувийн хэвшлийн түншлэл дээр ер нь бол нийслэлийн хувьд нэг ийм байр суурь баримтлаад байгаа юм. Өмнө нь бол ингээд иймэрхүү томоохон төсөл хөтөлбөрийг бол хэрэгжүүлэх санхүүгийн ямар ч нөөцгүй явж ирсэн. Зөвхөн төсвөөрөө явж байсан. Тэгээд

одоо бол гадна, дотоодын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох нэг боломж нь нээгдээд бид 6 сард анхны хөрөнгө оруулалтаа татаад ингээд явж байгаа.

Харин 3 дахь нэг томоохон эх үүсвэр нь бол энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн түншлэл буюу хувийн хэвшилтэйгээ хамтраад төсөв дээр ачаалал аль болох багаар үүрээд ингээд томоохон төслүүдээ хөдөлгөө гэсэн ийм зүйл байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол хэд хэдэн процессын юунууд байгаад байгаа юм. Хамгийн эхлээд нийслэлийн хувьд бол ИТХ-аасаа зөвшөөрлөө авна. Тэгээд гэрээ хэлэлцээрийн шат руу орно. Санал ирүүлсэн ААН-үүдтэй бид бас нэлээн сайн хэлэлцээр хийгээд, буцаагаад нөгөө нөхцөлөө бас иргэдийн хуралдаа танилцуулаад тэрхүү гэрээний нөхцөлүүд маань болж байна гэвэл тэгээд гэрээ байгуулаад тэгээд явах иймэрхүү зохицуулалтыг энэ хууль дээр бас оруулж өгсөн байгаа юм.

Р.Сэддорж: Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Гишүүний асуултад зүгээр нэмэлт мэдээлэл болгоод шүү. Энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль маань өмнөх нөгөө Концессын хуулиараа бодлогын хувьд бол эрс арай өөр дэвшилттэй болж гарч ирж байгаа юм шүү. Яах вэ өмнөх Концессын хууль үүргээ гүйцэтгэсэн л байх янз янзаар л яригддаг. Гэхдээ тэрэн дотор барих-шилжүүлэх гэдэг нэг юм гашиун түүх үлдээсэн туршлагауд өмнөх хуультайгаа цуг үлдсэн. Шинэ хууль дээр барих-шилжүүлэх гэдэг юм байхгүй. Тэгэхээр энэ төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэх бүх төслүүд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэнэ. Хувийн хэвшил мөнгөө гаргана, төр мөнгөө гаргахгүй. Тэр нь тэгээд тарифаараа байна уу, юугаар байна вэ хувийн хэвшил өөрсдөө тэндээсээ орлогоо олоод явна. Хугацааны эцэст энийг төр лүү шилжүүлж байвал төр, хувийн хэвшлийн

түншлэл гэдэг ийм зарчим руугаа явах юм байгаа юм.

Энэ дотор нийслэлээс гаргадаг зүйлүүд дээр бас Нямбаатар сайдын өмнө хийж байсан тайлбарыг би зүгээр саналаа. Жишээ нь нийслэлийн өмчид байдаг дэд бүтцийн ч юм уу, нийслэлийнхний амин чухал ийм шаардлагатай зүйлүүд их байдаг юм байна лээ. Тэрэн дотор гэнэтийн аваар осол гарвал нэн яаралтай шийдвэрлэх олон зүйлүүд төр, хувийн хэвилийн түншлэлээс гадна Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулиар шийдэгдэж байгаа асуудлууд ч байгаа. Одоо 1 зуух ингээд л эвдэрчихлээ гэхэд тэрийг тендер зарлаад хэдэн сар хүлээх үү. Эсвэл нэн яаралтай горимоор энэний худалдан авах ажиллагааг шууд хийх үү. Тэрийг нь хийж чадах хэмжээний нийслэлийн өөрийнх нь тусгай зөвшөөрөлтэй компани байж байхад тэрийгээ оруулаад гүйцэтгүүлэх үү эд нар гээд л их л зовлон байдаг юм байна лээ. Тэгээд тэр болгон дээрээ бас хуулийн гарц гаргалгаа ийм юмнуудыг оруулж ирж байгаа л ийм зовлон байх шиг байгаа юм. Тэгээд би нэмээд өмнө нь сонссоноор нэмэлт мэдээлэл өглөө шүү.

Р.Сэддорж: Лодойсамбуу гишүүн тодруулга.

Ч.Лодойсамбуу: Ер нь хэн нь эхлээд мөнгөө гаргах нь 2 дугаар асуудал тийм биз дээ. Ямар ч байсан хэн нь ч хийсэн бай эцэст нь төсвөөс л зардлаа нөхдөг юм байгаа биз дээ. Нөхнө биз дээ тийм ээ. Тэгэхээр энэ дээр хэнээр хийлгэх гэж байгаа вэ гэдэг дээр чинь сонгон шалгаруулалт алга болоод байна гэдэг дээр чинь л маргаан, эрсдэл үүсээд байгаа юм биш үү энийгээ боловсронгуй болгох талаар хэдүүлээ ярилцвал яасан юм бэ л гэдэг ийм саналыг дахин дахин хэлээд байгаа юм. Тэрнээс болбол энэ яаралтайгаар ажил хийхгүй болбол болохоо байгаад байгаа асуудлуудыг бол бүгдийг нь ойлгож байгаа шүү дээ.

Ер нь болбол энэ ЗГ энэ шинээр бүрэлдсэн парламент ялангуяа шинээр сонгогдсон гишүүд бид нар бас нэг зүйлийг анхаарахгүй бол бас болохгүй байна. Энэ бид нар ерөөсөө энэ засаглалынхаа зарчмыг нурааж хаях энэ ажлын хэрэгсэл болоод байна. Энэ шинээр сонгогдсон гишүүд. Энэ гүйцэтгэх үгүй ээ, ЗГ-аас оруулж ирж байгаа яаралтайгаар гялс хэлэлцүүлэе гэж байгаа бүх үйл ажиллагаа болбол ерөөсөө энэ шинэ дээр нь гялалзуульа л гэж байгаа юм. Энэ гялалзуулахдаа юуг хийж байна гэхээр өнгөрсөн парламентаар амжаагүй, амжаагүй ч гэж дээ хийгээгүй ажлыг нь гүйцээхийн тулд Их Хурлын дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа одоо гүйцээж хийхийн тулд.

Хүсэж байгаа төсвөө батлуулахын тулд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа дахиад 10 хэд дэхээ өөрчилж орж ирж байгаа. Тэгээд ажил хийх нэрийдлээр нээлттэй сонгон шалгаруулалтыг одоо байхгүй болгоод байна. Тэгэхээр үндсэндээ бид нар энэ том том зарчмын юмнуудыг нурааж унах дээр энэ шинээр сонгогдсон ялангуяа гишүүд маань нэг хэрэгсэл болоод байна гэдгээ өөрсдөө ойлгоод, нам намынхаа бүлэг дээр бас асуудлуудаа хэлээд, энэ дээр өөрсдийнхөө энэ саналыг хэлээд, энэ ЗГ-аас оруулж ирж байгаа саналууд дээр саналаа хэлэх, болиулах, буцаах, шаардлага хүргүүлэх ийм бүрэн эрхтэй шүү дээ. Энийгээ бас эдлээд, энэ нь ажилд садаа болж байгаа хэрэг биш ажлыг л сайн хийх гэж оруулж ирсэн болохоос ямар 4 жил гишүүн байж үзэх гэж орж ирж байгаа биш. Тэгэхээр шинэ гишүүд маань бас энэ дээрээ анхаараач гэж уриалж байгаа юм.

Р.Сэддорж: Баярлалаа.
Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Би нэгмөсөн энэ дагалдахаар орж ирж байгаа бүх хуулиудтай холбоотой саналаа хэлчихье. Тэгэхээр 1 дүгээр асуудал нь болохоор ер

нь энэ төсвийн тодотголыг дагаж ийм томоохон асуудлуудыг зохицуулж байгаа энэ томоохон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зүйл оруулж ирж байгаа нь бол бас зохимжгүй байгаад байгаа юм. Хууль тогтоомжийн тухай хууль гэж бид баталсан. Аливаа хууль тогтоомжид өөрчлөх, шинэчлэх тэр үйл ажиллагаа нь болохоор олон төрлийн хэлэлцүүлэг, судалгаа энэ тэрд үндэслэсэн байх ёстой.

Гэтэл энэ нөгөө төсвийн тодотголыг дагаад л яаралтай горимоор орж ирээд ингээд явчихаар тэр Хууль тогтоомжийн тухай хуулийн зарчим бас алдагдаж байна. Тэгээд дээрээс нь ерөнхийдөө бас ингээд иргэд мэдээлэлгүй, гишүүд ч гэсэндээ бас мэдээлэл багатай ийм байдлаар энэ нэг баахан чухал нэмэлт, өөрчлөлтүүд яваад байна. Тэгээд энэ хамтарсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг бид яг өмнөхөн хэлэлцлээ. Тэгээд үйл ажиллагааны хөтөлбөрт болохоор яг энэ төсвийн тодотголыг дагаж орж ирж байгаа төрийн худалдан авах ажиллагаа болон төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой чухал чухал тийм зорилтууд дурдагдсан. Тэгэхээр хамтарсан ЗГ нэг мөр энэ н... дээр ямар бодлоготой байх юм, энэ төр, хувийн хэвшлийн түншлэл дээр ямар бодлоготой байх юм тэдгээрийгээ ингээд нэгмөсөн боловсруулаад, тэгээд ийм намрын чуулганаар ч юм уу нэг ийм даацтай хуулийн төслүүд багц хуулиудаа өргөн бариад ороод ирж болдоггүй юм уу гэсэн саналыг л удаа дараалан тавиад байгаа юм.

Яах вэ тэгэх юм бол бид нарын хооронд бас итгэлцэл нэмэгдэж байна. Энэ чадавхад суурилсан хэлэлцээний арга гээд байгааг чинь болохоор бүгдээрээ л бас хардаж л байна шүү дээ яах аргагүй, одоо тэгээд урилгаар гээд л хүмүүсийг оролцуулна гээд байгаа юм. Тэгээд л гадна, дотнын томоохон тэр ААН-үүд гээд л яриад байгаа юм. Аль хэдийн хүмүүсээ тэр шалгарах хүмүүсээ

шалгаруулчхаад л, урилга өгөх гээд хүлээгээд, энийгээ зүгээр Их Хурлаар албажуулж байна гэсэн л ийм хардлага яваад байна шүү дээ. Тэгэхээр яаралтай ажил хийх нь чухал гэдгийг ойлгож байгаа. Гэхдээ итгэлцэл маш чухал. Тэгж байж ийм бас ийм харилцан энэ нам хооронд ч тэр, институт хооронд ч тэр, Их Хурал ЗГ хооронд ч тэр итгэлцэл байж бас энэ ажлууд чинь урт хугацаанд урагшаа явна. Эс бөгөөс бид нар өнөөдөр ингээд нэг баахан юмнууд баталчихдаг. Тэгээд дараа нь араас нь болохоор нэг овоолсон шороотой баахан өр ширтэй үлдвэл яах вэ гэдэг асуудал.

2 дугаарт Сангийн сайдыг байгаа дээр бас энэ Эдийн засгийн байнгын хороонд хамааралгүй боловч энэ ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудалтай нэг холбоотой нэг асуулт асуух гэсэн юм. Түүн дээр болохоор ААНОАТ-ын тухай хуульд нийгмийн хариуцлагын хүрээнд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг борлуулалтын орлогын нэг хувь хүртэл хэмжээгээр хөнгөлнө гэхчхэн байгаад байгаа юм. Тэгээд энэ нэмэлт 1 минутаа авчих тэгэх үү Сэддорж даргаа. Тэгээд.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт өгөөд л дараа нь л яадаг гээд байна даа. Дэгээрээ бол тэгж байгаа юм байна. Тэгээд дараа нь 2 минут байгаа. Хариулт, Жаргалан гишүүний асуултад хариулт. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Сүүлийн асуулт нь тасарчих шиг боллоо. Энэ удаа орж ирж байгаа дагаж байгаа хуулиуд бол бүгд тодотголтой холбоотой, тодотголд тусгагдсан, ялангуяа сүүлийн энэ хагаст эхлүүлье гэж байгаа томоохон бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлуудтай л холбоотой. Тэрийг л дэмжсэн. Энэ богино хугацаанд ажлуудаа эхлүүлчихье гэсэн шууд холбоотой л зүйлүүд байгаа. Харин ингээд нэмэлт, өөрчлөлтүүд эсвэл шинэ

хууль ч юм уу, суурь хуулиуд ийм хуулиуд ч юм уу оруулья гэвэл хэзээ ч оруулсан оройтохгүй шүү дээ. 25 оны төсөвтөө дагаж орж дахиад болно, тусдаа ч өргөн барьсан болно. Тийм учраас энэ бол бас нээлттэй асуудал. Сүүлийн асуултыг зүгээр би гүйцэт сонссонгүй, үгүй ээ асуулт нь гүйцсэнгүй тийм ээ, та нэмээд асуучих уу?

Р.Сэддорж: Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд аливаа албан байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогын нэг хуртэл хэмжээгээр хасаж хөнгөлнө гэхчхэн ийм зүйл орж ирж байгаа. Тэгээд нэг баахан яг ямар ямар хөрөнгө оруулалтууд хамаарах вэ гэдэг жагсаалт явж байна. Тэгэхээр бид нар ингээд яах вэ энэ нийгмийн хариуцлагын хүрээнд хувийн хэвшилээр төрийн өөрийнх нь хийх, хийж хэрэгжүүлэх ёстой тэр зүйлүүдийг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх гээд байна шүү дээ тийм ээ. Тэрийгээ бас урамшуулах гээд байна.

Тэгэхээр энэ хэдий хэмжээний татварын хөнгөлөлтийн талаар ярьж байгаа вэ гэдэг дээр бол энэ танилцуулгад бол ерөөсөө ямар ч зүйл оруулаагүй байна. Ямар ч тийм судалгаанууд бас алга, өнгөрсөн хугацаанд ер нь ийм яг энэ төрлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтуудыг хувийн хэвшлийнхэн ямар байдлаар хийсэн юм бэ гэдэг юм уу, цаашидаа ер нь яаж ямар үнийн дүн орж ирэх юм бэ гэдэг төсөөлөл ч гэдэг юм уу тийм ээ. Магадгүй үнэхээр тэр нийгмийн хариуцлагын хөрөнгө оруулалтуудыг урамшуулах гээд байгаа бол нэг тодорхой дүнгээр нэг тааз болгож оруулж ирдэг ч юм уу гэх маягаар ингээд нэг ийм арай илүү дэлгэрэнгүй, илүү тийм оновчтой зохицуулалт хийхгүй бол энэ бол бас ингээд зарим томоохон ААН-үүдийн хувьд бол бас татвараас

зайлсхийх, зугтах бас нэг тийм хэрэгсэл болж болзошгүй.

Тэгээд дээрээс нь энэ нөгөө жагсаалтыг нь батлах нь дахиад л нөгөө нэг ийм ЗГ дээрээ байж байгаа тийм ээ. Тэгэхээр ялангуяа энэ томоохон уул уурхайн ААН-үүдийн хувьд болохоор тэр нөгөө орлогын нэг хувь гэдэг чинь бол бас л их өндөр дүн гарна шүү дээ. Тэгээд төр бол зарим зүйлээ бол өөрөө хийх ёстой тийм үү. Жишээлбэл ингээд амьдрах орчинтой холбоотой, төрийн үйлчилгээтэй холбоотой асуудлуудаа. Заавал энийг хувийн хэвшил рүү outsourcing хийж яах гээд байгаа юм бэ?

Р.Сэддорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Би эхлээд хариулчихъя. Дараа нь манай Татварын бодлогын дарга нэмж хариулна. Жаргалан гишүүний асуултад энэ 2 юмны л туйл байна л даа. Зарим нэг нь төр хэтэрхий их оролцоотой байна энийгээ болиоч гэх юм. Та бол ер нь бүгдийг нь бараг төр хийгээд байх хэрэгтэй л гэх гээд байх шиг байна. Та тэгэх гээд байх шиг байна, тийм.

Тэгэхээр энийг одоо бид нар сэдлийг нь гаргаж байгаа асуудал. Ер нь бол сүүлийн жилүүдэд манай ААН-үүд ч томорч байна. Тэр хэрээр бас нийгмийн хариуцлагууд нь ч өндөр болж байх шиг байна. Ухамсар, соёл нь ч, үүрэг хариуцлага нь ч өндөр болж байх шиг байна. Ялангуяа спортын салбар, бусад соёлын салбар, нийгмийн салбар, хот тохижилт, ногоон хөгжил байгууламж гээд ер нь хувийн хэвшлийнхэн нэг иймэрхүү юм хийчихье. Тэгвэл бидэнд ямар хөнгөлөлт байх вэ гэж хандах нь бол нэлээн их болж ирж байна. Энэ их сайн хандлага гэж харж байгаа. Юу юугүй ингээд бүгдийг нь бид нар тооцоо хийгээд гаргаад ирэх бол боломж бол одоохондоо хомс.

Жишээ нь ер нь болбол таны бас тэр болгоомжилж байгаа зүйл бол яг бид нартай л ижилхэн байна. Энэ бас татвараас бултах иймэрхүү суваг нээчих вий гээд. Тэгэхээр орлогынх нь нэг хувиар нь хязгаарлачхаж байгаа юм. Юу юугүй хамаагүй хэдэн тэрбумын том бүтээн байгуулалт хийгээд, бүгд тэр нь орлогынх нь бараг 50 хувь нь байж болно шүү дээ зарим тохиолдолд. Тийм учраас энийг нэг хувь гэж нэлээн тийм чанга хязгаарлаж байгаа гэсэн үг. Тооцоолол юмнууд болон ямар чиглэлийн ажлуудыг хувийн хэвшил төрийн үүрэг хариуцлагаас бас үүрэлцэж байна гэж үзэх вэ гэдэг талаар манай газрын дарга нэмээд хариулчих.

Р.Сэддорж: 6 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт үүнтэй холбоотойгоор татвараас зайлсхийх боломжуудыг бол бид нар тодорхой хэмжээнд хааж байгаа. 1 дүгээрт энэ зардлууд бол хуульд заасан шаардлагуудыг бол хангах ёстой. Тэр нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байх, холбогдох баримт И баримтаар баталгаажсан байх энэ бүх шаардлагууд бол хангагдана. 2 дугаарт хамгийн гол татвараас зайлсхийх эрсдэл бол харилцан хамаарал дээр гардаг. Энэ дээр бол бид харилцан хамааралгүй этгээдэд олгосон гэдэг энэ шалгуур бол орж байгаа.

Дараагийн нэг юу нь бол бид энэ зардлууд бол яг үндсэн хөрөнгөд элэгдэлд тооцсон үндсэн хөрөнгөд орсон хөрөнгө оруулалтууд тооцогдох ёстой. Тэгэхгүй бол юу гэдэг юм зөвлөх үйлчилгээ ч байдаг юм уу иймэрхүү хэлбэрийн үйлчилгээнүүд бол энд хамаарахгүй. Сайдын хэлснээр бол энэ хөнгөлөлт эдлэх дүн нь бол тухайн жилийн татвар ногдох орлогын нэг хувиар хязгаарлагдаж байгаа. Зүгээр бид нар зүгээр 2023 оны жилийн эцсийн тоогоор төсөөлөд Монголын бүх

компани яг хуульд заасан дээд хэмжээгээрээ энэ хөнгөлөлтийг эдэллээ гэхэд бол 70 орчим тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдлэхээр байгаа. Тэгэхдээ энэ хөнгөлөлт нь бол эргээд нийгмийн сайн сайхны төлөө нийгмийн хариуцлагын хүрээнд энэ олон нийтэд чиглэсэн ийм үр дүн. Та энд 22.9 дэх жагсаалтыг харуулбал дандаа нийгмийн салбарын нийгэмд чиглэсэн, нийгмийн сайн сайхны тусын тулд орж байгаа ийм үйл ажиллагаа хамрагдсан байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Мөнхсоёл гишүүнийг нэмээрэй. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр 4 асуулт байна. 1 дүгээрт дээрээс нь эхлээд явчихъя. 1 дүгээрт 31.5 дээр болохоор тендер.../үг тасрав/

Р.Сэддорж: Энийг Төсвийн байнгын хороо хэлэлцэж байгаа юм байна шүү. Манай Байнгын хороон дээр байхгүй байгаа юм байна.

Г.Уянгахишиг: Одоо энийгээ хэлэлцэж байгаа биз дээ.

Р.Сэддорж: Одоо нэмэлт, өөрчлөлт Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1 дүгээр зүйлийг хэлэлцэж байна.

Г.Уянгахишиг: Түншлэл дууссан шүү дээ. Түншлэлийн, тэгвэл энийгээ биш юм уу тийм ээ? Энэ чинь сая чадавх энэ тэр яриад, сая чинь чадавхын үнэлгээ энэ тэр яриад байсан шүү дээ. Тэр чинь уг нь энэ хууль дээрээ байгаа шүү дээ.

Р.Сэддорж: Гишүүд бол зүгээр санал дээрээ чөлөөтэй ярьж байсан юм. Тийм. Хуулийн хэлэлцүүлэг.../үг тасрав/

Г.Уянгахишиг: Тэгвэл саналаа хэлчхэж болох уу? Яг адилхан хуулийн төсөл шүү дээ энэ чинь.

Р.Сэддорж: Төсвийн байнгын хороон дээр.

Г.Уянгахишиг: Төр, орон нутгийн өмчийн хөрөнгө гэж Тендерийн хууль шүү дээ. Үгүй ээ харин тийм. Тэгэхээр нөгөө гишүүд болбол яг энэ, дарга Байнгын хороон даргаа санал хэлж болох уу, болохгүй юу?

Р.Сэддорж: Гялс хэлчихгүй юу.

Г.Уянгахишиг: Тэгэхээр энэ хууль дээр үндсэндээ 4 санал байгаад байгаа юм. Тэгэхээр нэг нь энэ 31.5 дээр тендер шалгаруулалтын аргаар тухайн аргаар 2-оос доошгүй удаа зарлахад нэг ч тендер ирээгүй бол төрийн болон орон нутгийн өмчит эсвэл өмчийн оролцоотой хуулийн этгээдээр тухайн худалдан авах бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгүүлж болно гэхчхэн байгаа. Тэгэхээр энийг хэрэгжсвэл, энэ яг хуулийн заалт хэрэгжилт дээр орж ирэхэд хувийн хэвшил дээр болбол санхүүжилтийн эх үүсвэр өөрөө зардал бол маш өндөртэй байгаа.

Тэгэхээр яг тендерийн үнэлгээ дээр ч гэдэг юм уу, яг нөхцөл байдлын хувьд хувийн хэвшил орж ирж чадахааргүй нөхцөл байдал үүсэж болно. Энэ дээрээ ингээд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд ороод явчихаар дараа нь нөгөө нэг буцаад тэр практик дээр нөгөө ТӨК, төрийн өмчийн оролцоотой чинь туслан гүйцэтгэгчид аваад, дахиад хувийн компаниудыг оруулаад ирдэг. Энэ дээр яг асуудал үүсээд байдаг. Тэгэхээр энэ тал дээрээ бас энэ заалт өөрөө байх ёстой юу, үгүй юү гэдэг дээр анхаарах ёстой болов уу гэж бодож байна.

Дараагийн асуудал нь болохоор энэ 36 дугаар зүйл 36¹ буюу чадавхад

суурилсан хэлэлцээний арга. Энэ дээр 3 асуудал байгаад байгаа. 1 дүгээрт болохоороо 36/1, 3 дээр зөвхөн урилга явуулж болно гэж ойлгогдоод байна. Тэгэхээр одоо яг захиалга чадавхад суурилсан хэлэлцээний аргаар зохион байгуулах тендер.../минут дуусав/

Р.Сэддорж: Уянгахишиг гишүүн ингэх юм байна. Та байна шүү дээ одоо гараад Төсвийн байнгын хороон дээр гараад гялс саналаа хэлээдэх гэж байна. Эд нар чинь хоорондоо холбоотой юм байна шүү дээ, тийм. Тэрэн дээр чинь албан ёсоор протоколд тэмдэглэж авах юм байна. Одоо бид нар энэ нэмэлт, өөрчлөлтийн 6 зүйлийн 1 дүгээрийг л хэлэлцээд явж байгаа юм. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн. Ингээж ажлын албанаас зөвлөж байгаа юм байна шүү гишүүнээ. Баатаржавын Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Сайн байцаана уу, уучлаарай би уг нь зөндөө саналтай байсан боловч Төсвийн байнгын хороо дээр Төсвийн тогтвортой байдлын хуулийн тухай бас саналаа хэлье гэж бодож байна. Энэ юун дээр болохоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах дээр би зүгээр энэ 37.9.5 дээр зарим нэг нөгөө зүйл, заалтууд нь нэлээн субъектив шинжтэй харагдаад байна л даа.

Жишээлбэл 37.9.5 хамгийн сайн нөхцөл санал болгосон гэдэг чинь бид нарын нөгөө өмнө нь Тендерийн хууль төрийн болон юу худалдан авах үйл ажиллагаатай холбоотой хууль хэрэгжиж байхад босго дүнгээ хамгийн өндөр тавьсан нь шалгарах магадлал өндөртэй байдаг байсан шүү дээ гэх мэт ийм нөгөө тухайн үнэлгээний хорооны хандлагатай субъектив хандлагатай холбоотой маш их ийм зөрчлүүд гардаг байсан. Эргээд энэ нь ААН-үүдийн хооронд бас зөрчил үүсгэдэг байсан. Энэ Жаргалан гишүүний хэлж байгаа итгэлцлийн асуудал чинь бас энэ шалтгаанаас болоод үүсдэг. Тэгэхээр

ийм субъектив шинжтэй зүйлүүдийг аль болохоор бага оруулмаар санагдлаа гэдэг энэ тодорхой саналыг хэлмээр байна.

2 дугаарт нь болохоор бас тэр өмнө нь зарим Жаргалан гишүүн энэ тэр хэлсэн. Нэг хувь гэж хэлж байгаа орлогынх нь нэг хувьд хүртэл хөнгөлөлт олгож байгаа ч гэсэн бас ийм ямар нэгэн байдлаар тухайн шалгуурыг давчихаар тэр зүйл ангиуд байгаад байна. Өөрийн ажиллагсдын хүүхэд биш бусад оюутан, сурагчдад тэтгэлэг олгосон бол бас энэ спорт, соёл юу билээ заал барьсан бол гээд эд нар чинь бас жоохон хэмжих шалгуур үзүүлэлт тодорхой гарахгүй бол нэлээн субъектив, нөгөө л мэдээлэлд ойр, эрх мэдэлд ойр хүмүүс бас өөрсдөдөө ашигтай тусгаад, эргээд гишүүдийн тэр хүнд буурах ийм хандлага үүсэх вий гэсэн бас болгоомжлол байна.

Р.Сэддорж: Санал санал хэллээ. Уянгахишиг гишүүн та юугаа үргэлжлүүлээд хэлчих үү, энэ протоколд ч бас давхар орж л байг тийм ээ. Уянгахишиг гишүүн 2 минут.

Г.Уянгахишиг: Тэгвэл үргэлжлүүлээд хэлчихье. Түүрэн яриад явж байсан 36/1 урилга хүргүүлэх тухай байгаа. Тэгэхээр хувийн хэвшилээс чадавхад суурилсан энэ хэлэлцээнд оролцох хүсэлтэй болбол хүсэлтээ илэрхийлж болох юм уу буюу зөвхөн урилга хүлээн авснууд нь оролцоно гэхээр энэ дээр яг адилхан чадвартай боловч урилга хүлээж авахгүй үлдчихвэл яах вэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ талаасаа бас хуулийнхаа зохицуулалт дээр анхаарч үзээч гэдэг санал байна.

Дараагийн санал болохоороо 36/9 жагсаалтыг ЗГ батална гэж байгаа. Тэгэхээр нэгэнтээ энэ дээр нэлээн том төсөл хөтөлбөрүүд бас орж ирэх магадлалтай байгаад байгаа учраас энэ жагсаалтыг Их Хурлаар батлах, хэлэлцүүлэх боломж байх уу? Энэ дээр

ийм өөрчлөлт оруулах боломж байх уу гэдэг асуулт байна, санал байна.

Дараагийнх нь болохоороо 36/10 байгаа. Энэ 36/10 дээр болохоороо чадавх бүхий аж ахуй эрхлэгчээр энэ хуулийн 36/2.1-д заасан үе шатыг шууд сонгон гүйцэтгүүлж болно гэдэг заалт байгаад байгаа юм. Тэгэнгүүт 36/2.1 маань юу юм бэ гэхээр нөгөө төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх анхан шатын судалгаа, техникийн тодорхойлолт боловсруулах буюу энэ дотор ТЭЗҮ орж байна уу гэдэг асуулт байна. Тэгээд ТЭЗҮ-ийн ажлыг шууд гэрээ байгуулах зарчмаар явчихаар өнөөдрийн төсвийн тодотгол дээр орж ирж байгаа нэлээн том том ТЭЗҮ хийлгэх төсвийн асуудлууд байгаад байгаа шүү дээ.

Нэмэлт зардлууд байгаад байгаа. Тэгэхээр энэ бүх ажлууд чинь өөрөө энэ хуулийнхаа заалтаар шууд гэрээ байгуулагдаад явчих юм уу гэдэг ийм санал, асуулт, тодруулах зүйл байгаад байна гэсэн үг.

Р.Сэддорж: Уянгахишиг гишүүний саналыг сонслоо. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл рүүгээ оръё. 6 зүйлтэй. 2 дээр нь явж байна. 2 дугаар зүйл дээр санал хэлэх, асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу? Алга байна. 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна уу? Алга байна. 4 дүгээр зүйлтэй Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу? Алга байна. 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу? Манайхан материалаа харж байгаа тийм ээ хуулиа? Алга байна. 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. 6 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ингээд Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Дагаж мөрдөх журмын тухай хууль. Уянгахишиг гишүүн үү тийм ээ. Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, аль нь билээ. Уянгахишиг гишүүнийг урьж байна.

Г.Уянгахишиг: Энэ дээр 1 дүгээр зүйл дээр 7/1 зүйл нэмж байгаа тийм ээ. Тэгээд энэ зүйл нь болохоороо энэ хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт зарласан тохиолдолд

шалгарсан этгээдтэй Концессын тухай хуулийн дагуу концессын гэрээ дагалдах гэрээг байгуулна гэхчхэн ийм заалт яваад байгаа юм. Тэгэхээр өмнө нь буюу нэмэлт оруулахаас өмнөх Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль дээр хэрвээ Концессын тухай хуулиараа гэрээ байгуулчихсан бол гэрээ хэрэгжээд явж байгаа бол цаашидаа энэ хуулийнхаа дагуу явна гэдэг тэр нь давуу хүчинтэй байна гэдэг зохицуулалтууд нь бол байгаа.

Тэгэнгүүт бид нар одоо энийг шалгаруулалт зарласан тохиолдолд шалгарсан этгээдтэй гээд явчихаар шалгаруулалт зарлачхаад тэр нь шалгаруулалтаа явуулах, буцаагаад тэрэнтэй гэрээ байгуулах энэ болгон дээр хүчин төгөлдөр бус болчихсон гэрээгээ ашиглаад явна гэдэг бол өөрөө хуулийн зарчмын хувьд болохгүй зүйл байгаад байгаа. Энэ цаашаагаа энэ Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулиар явах ёстой. Энэ дээр асуудал гарч ирэх юм нь жишээлбэл нөгөө Концессын тухай хууль дээр болохгүй байгаад байсан барьж-шилжүүлэх гэдэг арга байгаад байгаа шүү дээ. Тэгээд үүгээрээ яваад хамгийн хуулийн баахан завхрал гарчихсан гэдэг дээр буюу Тендерийн хуулиар зугтаасан асуудлууд чинь энэ Концессын хууль руу ороод явчихсан.

Гэтэл энэ одоо сонгон шалгаруулалтаа нөгөө барьж-шилжүүлэх гэдгээрээ зарлачихсан байж байгаад тэрнийхээ дагуу үргэлжлүүлээд явуулах гэж байгаа төслүүд дээр дахиад нөгөө Концессын хуулиа бариад явах юм уу? Тэгэхээр 1 ийм асуудал гарч ирээд байгаа учраас энэ болбол яг ингэж өөрчлөлт орох болбол шаардлага байхгүй гэдэг саналтай байна.

Р.Сэддорж: Эдийн засгийн хөгжлийн яам хариулаарай. Хэн хариулах вэ? 2 номер, өөрийгөө танилцуулаад.

З.Энхболд: Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд. Гишүүний асуултад хариулъя. Өмнөх дагаж мөрдөх журмын хууль дээр болбол гэрээ байгуулагдсан болбол тэр гэрээний харилцааг өмнөх Концессын хуулиар зохицуулж явна гэсэн ийм зохицуулалт байсан. Энэ удаагийнх болохоор сонгон шалгаруулалт зарласан болбол тэр сонгон шалгаруулалт зарлагдаад үр дүн гарсан энэ харилцааг болбол өмнөх хуулиар зохион байгуулна гэсэн ийм хуулийн заалт болбол орж ирж байгаа.

Энэ асуудлыг ярилцахдаа болбол бид хэд Хууль тогтоомжийн хуулийг энэ Дагаж мөрдөх журмын хууль дээр ийм өөрчлөлт оруулах нь Хууль тогтоомжийн хуулийг зөрчих үү, үгүй юү гэдгийг бид анх өргөн мэдүүлэхдээ болбол харсан. Тийм учраас Хууль тогтоомжийн хуультай зөрчилдөхгүй гэж үзсэн байгаа.

Таны хэлж байгаа Концессын хуулиар явах юм болбол нөгөө барих-шилжүүлэх асуудал руу орох юм биш биз дээ гэсэн эрсдэл байна гээд. Тэгэхээр барих-шилжүүлэх асуудлыг бол өмнөх Концессын хууль хэрэгжих явцад Улсын Их Хурлын тогтоолоор хориглочихсон ийм байгаа. Тэгэхээр өмнө зарлагдчихсан байгаа концессын сонгон шалгаруулалт дээр болбол барих-шилжүүлэх нөхцөлөөр болбол сонгон шалгаруулалт зарлагдаагүй байгаа гэж үзэж болно.

Р.Сэддорж: Тодруулах уу? Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Нэмээд тодруулах асуулт нь болохоор одоо энэ дээр зарласан тохиолдолд гэхихсэн байна шүү дээ. Тэгэхээр энэ өөрөө нөгөө шалгаруулалт зарлагдахад тухайн шалгаруулалт нь яваагүй байсан ч гэсэн энэ рүүгээ орох гээд байна уу? Шалгаруулалт яваад шалгарчихсан этгээд нь буюу энэ нөхцөлд болбол буцаагаад тэр чинь нөгөө тендерийн материал тараахдаа ямар аргаар

явуулах вэ, ямар нөхцөлөөр гэрээ байгуулах вэ, яах вэ, ийх вэ гэдэг юм чинь тендерийн материалдаа байгаа шүү дээ. Тэгэхээр тэрнийхээ дагуу шалгарчихсан этгээддээ буюу энэ хуулийг тухайн Концессын тухай хууль хүчин төгөлдөр бус тооцогдох үед шалгарчихсан байгаа этгээдүүдийн хувьд яригдаж байвал энэ бас арай өөрөөр томъёологдох ёстой болов уу л гэж хараад байна л даа.

Р.Сэддорж: Хариулт, 2 номер, тодорхой хариулаарай.

З.Энхболд: Концесс юу, Төр, хувийн хэвшлийн түншилэлийн хууль хэрэгжихээс өмнө зарлагдсан Концессын хуулийн дагуу зарлагдсан төсөл арга хэмжээнүүд болбол барих-шилжүүлэх нөхцөлөөр болбол зарлагдаагүй. Яагаад гэхээр 2017 онд энийг болбол Их Хурлын тогтоолоор хориглосон байгаа. Тэгэхээр сонгон шалгаруулалт нь зарлагдаад явж, зарлагдаад тэгээд зарлагдаад үр дүн гараад шалгарсан оролцогч байх юм болбол Концессынхоо тухай хуулийн дагуу цааших үйл ажиллагаагаа зохицуулж явна гэсэн ийм агуулгаар л оруулж ирсэн гэж ойлгож байгаа.

Р.Сэддорж: Асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу? Алга байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу? Алга байна. Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Төрийн өмчийг Нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Ажлын хэсэг хэвээрээ. Тогтоолын төсөлтэй

холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Мэдэж байгаа юу тийм ээ? Төрийн өмчийг Нийслэл рүү гэдэг чинь нөгөө юуны үйлдвэр биз дээ. Өрийг нь яах гэж байгаа юм бэ? Тэрийг асуулт дээрээ ярья даа. Саналтай гишүүд байна уу? Уянгахишиг гишүүн. Уянгахишиг гишүүнээр санал нэр авч дууслаа. Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Энэ асуудал дээр болохоор бас нэлээн асуудалтай зүйлүүд байгаад байгаа гэж ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл нийслэлийн хувьд бол сая бонд гаргасан. Тухайн бондын танилцуулга дээр бол яг энэтэй холбоотой өр ороогүй, энэтэй холбоотой зардлууд ороогүй энэ төсөлтэй холбоотой.

Тэгэхээр нийслэлийн бонд гаргахад тухайн бондыг худалдаж авсан хүмүүст амласан амлалт бол бондын танилцуулга дээр байгаа. Тэгэхээр энэ танилцуулга дээр орж ирсэн бонд төлөгдөх хүртэл энэ төрийн өмчөөс хамгийн нэлээн алдагдалтай байгаа компанийн балансаар шилжээд ороод ирэхээр нөгөө бонд эзэмшигчдийн маань эрх ашиг яах вэ? Энэ нь өөрөө нийслэлийн өөрийнх нь чадавхад хэр нөлөөлөх вэ гэдэг ийм асуулт байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ тал дээр болбол бид нар нэлээн сайн тооцоо судалгаатай буюу тухайн нийслэлийн бондын өр төлөх чадварт хэрхэн нөлөөлөх вэ гэдэг дээр шинжээч, хөндлөнгийн шинжээч юм уу тийм ээ, тодорхой хэмжээний тооцоолол хийж үзэх ёстой гэдэг ийм саналтай байна.

Р.Сэддорж: 4 номерын микрофон өгье. Хариулт.

Н.Мандуул: Гишүүний асуултад хариулъя. Энэ угаасаа Тавантолгой түлшний зохион байгуулалт, тэр борлуулалт, хяналтыг нь угаасаа нийслэлийнхэн зохион байгуулж, оролцож ажилладаг юм байна лээ.

Тэгэхээр ер нь бол энэ сайжруулсан түлшний асуудлыг нэг цэгцлэхийн тулд бол ер нь ингээд нийслэл өөрсдөө бас яг аваад орох нь зүйтэй гэсэн тийм зарчмын асуудал яригдаж байгаа юм.

Таны тэр хэлсэн тэр өр төлбөрийн асуудал бол чухал асуудал. Үүнтэй бол санал нийлж байгаа юм. Тэгээд нийслэлийн зүгээс үүнийг Төсвийн байнгын хорооны ажлын хэсэг дээр бас яг нэлээн дэлгэрэнгүй ярилцахаар тийм төлөвтэй байгаа.

Р.Сэддорж: Энэ бүгд протоколд тэмдэглэгдэж, зохих газруудад очиж байгаа. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Тэр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Тэр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тэр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн өмчийг Нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралд Улсын Их Хурлын гишүүн хэн унших вэ, танилцуулах вэ? Соронзонболд гишүүн. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд уншиж танилцуулна.

14.12 цаг

Ингээд Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Анхны хуралдаандаа идэвхтэй оролцсон нийт гишүүддээ баярлалаа.

Дэлгэц дээр 88 хувийн ирцтэй явж байна
шүү. Баярлалаа.

Хуралдаан өндөрлөснийг
мэдэгдье. Одоо сууж байгаа гишүүдийн
нэрсийг дурдъя. Соронзонболд гишүүн,
Мөнхсоёл гишүүн, Уянгахишиг гишүүн,
Жаргалан гишүүн, Батсүмбэрэл гишүүн,

Батнайрамдал гишүүн, Цэнгүүн гишүүн
та бүхэндээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА